

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН  
ХӨГЖЛИЙН МАСТЕР  
ТӨЛӨВЛӨГӨӨ  
/2011-2021/**

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН /2011-2021 он/  
ХӨГЖЛИЙН МАСТЕР ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ  
АГУУЛГА**

**НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

- 1.1 Дорноговь аймгийн хөгжлийн Мастер төлөвлөгөө боловсруулах үндэслэл
- 1.2 Мастер төлөвлөгөө боловсруулахад баримталсан чиглэл, зарчмууд
- 1.3 Дорноговь аймгийн хөгжлийн өнөөгийн байдал
- 1.4 Дорноговь аймгийн хөгжлийн боломж, давуу болон сул талын үнэлгээ

**ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛ**

- 2.1 Дорноговь аймгийн Алсын хараа, тэргүүлэх чиглэл, хөгжлийг хангах хүний хүчин зүйлийн оролцоо
- 2.2 Эдийн засаг, орон нутгийн төсөв, санхүү, татварын болон хөрөнгө оруулалтын бодлого
- 2.3 Өрсөлдөх чадварыг сайжруулах бодлого
- 2.4 Аж үйлдвэр, боловсруулах аж үйлдвэрийн хөгжил
- 2.5. Хоршоо, жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээний хөгжил
- 2.6 Хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрлэлийн хөгжил
- 2.7 Аялал жуулчлалын салбарын хөгжил
- 2.8 Дэд бүтцийн хөгжил
  - 2.8.1 Зам тээврийн хөгжил
  - 2.8.2 Эрчим хүчний салбарын хөгжил
  - 2.8.3 Мэдээлэл харилцаа холбоо, технологийн хөгжил
- 2.9 Хот байгуулалт, барилга бүтээн байгуулалтын салбарын хөгжил
- 2.10 Сумдын бүсчилсэн хөгжил

**ГУРАВ. ХҮНИЙ БОЛОН НИЙГМИЙН ХӨГЖИЛ**

- 3.1. Хүн амын өсөлтийг түргэтгэх, хүний хөгжлийг хангахад чиглэсэн бодлого
- 3.2. Жендерийн тэгш байдлыг хангах бодлого
- 3.3. Гэр бүлийн хөгжлийн бодлого
- 3.4 Ядуурал, ажилгүйдлийг бууруулах бодлого
- 3.5 Боловсрол, соёлын хөгжлийн бодлого
- 3.6 Эрүүл мэндийн хөгжлийн бодлого

**ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ САЛБАРЫН БОДЛОГО**

- 4.1 Байгаль орчны салбарын хөгжлийн бодлого
- 4.2 Гамшгаас урьдчилан сэргийлэх бодлого

**ТАВ. ЭРХ ЗҮЙТ ТӨРИЙН БАЙГУУЛАЛЫН БОДЛОГО**

- 5.1 Эрх зүйт төрийн бодлого

- 5.2 Нутгийн төр захиргааны байгуулал, төрийн албаны шинэтгэлийн бодлого
- 5.3 Гадаад бодлого
- 5.4 Батлан хамгаалах салбарын бодлого

## **ЗУРГАА. ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ НИЙТЛЭГ АРГА**

- 6.1 Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалтын үндсэн чиглэл
- 6.2 Эдийн засгийн өсөлтийг хангах үндсэн арга
- 6.3 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэр
- 6.4 Олон нийтийн харилцаа, хамтын ажиллагааны төлөвлөгөө

## **ДОЛОО. МАСТЕР ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ**

- 7.1 Мастер төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ерөнхий зарчим
- 7.2 Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх байгууллага, хугацаа
- 7.3 Хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлт (3 үе шат бүрээр)

## Нэг. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

### 1.1. Дорноговь аймгийн хөгжлийн Мастер төлөвлөгөө боловсруулах үндэслэл

Монгол улсын үндсэн хууль, Монгол улсын XXI зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр, Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, Монгол улсын бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хууль, Төвийн бүсийн үйл ажиллагааны хөтөлбөр, Монголын мянганы хөгжлийн зорилт, Мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого, “Төрөөс Төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого” болон төрийн захиргааны төв байгууллага, нутгийн өөрөө удирдах ёсны ба захиргааны байгууллагуудаас улсын, бүсийн, орон нутгийн хөгжилтэй холбогдон гаргасан тогтоол шийдвэр, төсөл, бодлогын бусад баримт бичгүүдийн үзэл санаа нь Дорноговь аймгийн хөгжлийн энэхүү хөгжлийн мастер төлөвлөгөөнд тусгалаа олсон бөгөөд уг хөтөлбөрийг боловсруулах үзэл баримтлалын үндэс болсон юм.

Дорноговь аймгийн хөгжлийн мастер төлөвлөгөө нь аймгийн хүн амын амьдралын чанарыг дээшлүүлэх, хүрээлэн буй байгаль орчны тогтвортой байдлыг хангах, хүний хөгжлийн үзүүлэлтүүдийг сайжруулах ерөнхий зорилгыг агуулахын зэрэгцээ уул уурхай олборлох, боловсруулах үйлдвэрийн салбарт түшиглэсэн эдийн засаг, нийгмийн хөгжлийн нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэгдсэн болно.

Орон нутгийн засаглал, нийгэм, эдийн засгийн хөгжил, байгаль орчин, хот байгуулалтын асуудлын хүрээнд сумдын бүсүүдийн хөгжлийн уялдаа, эдийн засгийн шүтэлцээнд суурилуулан авч үзлээ. Төр, хувийн хэвшлийн түншлэл, зах зээлийн харилцаанд суурилсан эдийн засгийн харилцаа, сайн засаглал, орон нутгийн бие даасан байдал зэргийг бүс нутгийн хөгжлийн тулгуур зарчим гэж тодорхойллоо.

Дорноговь аймаг нь Бүс нутгийн хөгжлийн гол тулгуур төв болон хөгжих ирээдүйтэй. Иймд энэхүү аймгийн хөгжлийн мастер төлөвлөгөөг цаг хугацааны хувьд гурван үе шаттайгаар төлөвлөсөн.

Нэг. 2011-2013 онд “Шинэ Дорноговь” хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилтийг бүрэн хангахад чиглэсэн бодлого арга хэмжээг хэрэгжүүлэн, Сайншанд аж үйлдвэрийн цогцолбор байгуулах бэлтгэл ажлын хүрээнд бүтээн байгуулалт, суурь дэд бүтцийг байгуулах ажлыг хот байгуулалтын оновчтой бодлоготой уялдуулан хийж, хүн амын эрчимтэй төвлөрөл бүхий сууринд нийгмийн суурь үйлчилгээг хүргэх, орон нутгийн боломжит бүтээгдэхүүн үйлдвэрлэлээр хэрэглээг хангахад чиглэгдсэн бэлтгэл ажлууд голлон хийгдэхээр стратеги зорилтуудыг томъёолсон.

Хоёр. 2014-2016 онд Өмнөд говийн дэд бүтцийг хөгжүүлэх хөтөлбөрийг эрчимжүүлэн, Сайншандын хүнд аж үйлдвэрийн цогцолбор, Замын-Үүдийн чөлөөт бүс байгуулах зэрэг бүтээн байгуулалтын ажлын зэрэгцээгээр бусад салбарт боломжит бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлж, аймаг эдийн засгийн хөгжлийн хувьд бие даах нөхцлийг хангахад чиглэгдсэн стратеги зорилтуудыг салбар бүрт томъёоллоо.

Гурав. 2017-2021 онд уул уурхайн олборлох, боловсруулах үйлдвэрүүдээс бусад байгаль орчинд аюулгүй салбаруудын нэмүү өртөг бүхий бүтээгдэхүүн үйлдвэрлэл эдийн засгийн бүтцэд голлох байрыг эзэлж, бие даан баялагийг бий

болгож, хүний хөгжлийг хангахад чиглэгдсэн бодлогын стратеги зорилтууд голлон томъёологдсон.

Газар нутгийн байршил, байгалийн баялаг, ашигт малтмалын нөөц, эдийн засгийн тэргүүлэх чиглэлийн хөгжлийн ирээдүйн төлөв, хандлага, зам харилцаа, эрчим хүчний хангамж, одоогийн хоорондын харилцан уялдаа зэргийг харгалзан сумдыг дөрвөн бүсэд хуваан авч үзсэн. Бичил бүсүүдийн хөгжлийн загварууд нь харилцан адилгүй байх боловч нийтлэг шинжүүдээр нь авч үзвэл эдийн засгийн бүтэц, үндсэн үүргүүдээрээ ялгагдана.

Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлэх Сайншандад аж үйлдвэрийн цогцолбор барих төсөл нь Дорноговь аймгийн төдийгүй Монгол Улсын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, техник, технологийн хувьд харилцан уялдаатай, нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэрүүдийг хөгжүүлэх, нийгэм, эдийн засгийн хөгжилд эерэг, таатай нөлөө үзүүлэх юм. Энэхүү төслийн хүрээнд “Коксын үйлдвэр”, “Хар төмөрлөгийн үйлдвэр”, “Нүүрс хийжүүлэх үйлдвэр”, “Зэс хайлуулах үйлдвэр”, “Барилгын материалын үйлдвэр”, “Газрын тос боловсруулах үйлдвэр”-үүд, тэдгээрийн найдвартай үйл ажиллагааг хангах дэд бүтэц, инженерийн болон нийгмийн хангамжтай, байгаль орчинд ээлтэй, шилдэг хот төлөвлөлттэй олон улсын хэмжээнд эдийн засгийн хувьд өрсөлдөх чадвар бүхий аж үйлдвэрийн хот район байгуулагдах юм. Цогцолборын үйлдвэрүүд нь үе шаттайгаар баригдах ба тухайлбал “Коксын үйлдвэр” Тавантолгой-Сайншандын төмөр замыг ашиглалтанд орох, “Газрын тос боловсруулах үйлдвэр” Тавантолгой-Чойбалсангийн төмөр замыг барихтай цаг хугацааны хувьд уялдаж байхаар төлөвлөгдөж байна.

Аймгийн оролцоо, дэмжлэг нь эдгээр төслүүдийг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, дэд бүтцийн зарим төслүүдийг санхүүжүүлэхэд анхаарч, төсөл хэрэгжүүлэх урьдчилсан нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэгдэх юм.

“Сайншанд” аж үйлдвэрийн бүтээн байгуулалтад хамрагдаж болох үйлдвэрүүд, дэд бүтцийн төслүүдийг хамруулан нийтдээ (Засгийн газрын 2009 оны 320-р тогтоолыг үндэслэн тооцоход) 10 гаруй тэрбум долларын хөрөнгө оруулалт шаардагдахаар урьдчилсан тооцоо гарсан байна.

“Сайншанд” аж үйлдвэрийн цогцолбор байгуулах төсөл болон аймгийн хөгжлийн энэхүү мастер төлөвлөгөөнд тусгагдсан хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтад шаардагдах хөрөнгийг бүрдүүлэхэд нэг төрлийн хөрөнгийн эх үүсвэрт түшиглэх боломжгүй юм. Иймд хөтөлбөр, төслийг санхүүжүүлэх хөрөнгийг боломжит эх үүсвэрүүдээс, үе шат бүрт бүрдүүлэхээр төлөвлөж байна. Үүнд хувийн хөрөнгө оруулалт, төр, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт голлох байр суурьтай байна.

Дээрх бүтээн байгуулалтын томоохон цогцолборыг ашиглалтанд оруулснаар манай улсын эдийн засгийн бодит өсөлт огцом нэмэгдэж аж үйлдвэрийн салбарын ДНБ-д эзлэх хэмжээ 57 хувьд, боловсруулах аж үйлдвэрийн салбарын ДНБ-д эзлэх хэмжээ 14 хувьд, эдийн засгийн өсөлт 2013-2021 онуудад дунджаар 15.8 хувьд хүрч өсөх боломж байна. Харин Дорноговь аймгийн аж үйлдвэрийн салбарын ДНБ-ний жилийн дундаж өсөлт 75 хувьд, боловсруулах аж үйлдвэрийн салбарын ДНБ-ний жилийн дундаж өсөлт 8 хувь буюу түүнээс дээш өсөх боломжтой болох юм.

## **1.2 Мастер төлөвлөгөө боловсруулахад баримталсан чиглэл, зарчмууд**

Мастер төлөвлөгөөг боловсруулахад Монгол Улсын мянганы хөгжилд суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, Төвийн бүсийн хөгжлийн хөтөлбөр, Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, салбаруудын хөгжлийн хөтөлбөр, аймгийн чадавхи, нөөц, боломж, дотоод, гадаад орчны нөхцөлүүд, иргэд, бизнес эрхлэгчид, төр, олон нийтийн байгууллагуудын нийтлэг хүсэл тэмүүлэл, санал санаачлагад тулгуурласнаас гадна мастер төлөвлөгөө боловсруулахдаа дараах чиглэл, зарчмуудыг баримталлаа:

1. Байгаль орчныг хамгаалах, экологийн тэнцвэрийг хангах, нөөцийг зохистой ашиглах;
2. Бизнесийн таатай орчин бүрдүүлэхэд төр, захиргааны байгууллагуудын үүрэг, хариуцлагыг дээшлүүлэх;
3. Орон нутгийн нөөц боломжинд тулгуурлан эдийн засгийн өсөлтийг хангах;
4. Хүний хөгжлийг хангаж, иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэх;
5. Шинэ техник, дэвшилтэт технологи бүхий жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх;
6. Мэдээлэл, сурталчилгааг өргөжүүлэх замаар боломжит хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх;
7. Оролцогч талуудын оролцоог өргөжүүлэх, түншлэл, хамтын ажиллагааны зарчмыг баримтлах;
8. Тухайн бүс нутаг ба орон нутгийн онцлогийг харгалзах, орон нутгийн нөөцөд тулгуурлах;
9. Эдийн засаг, нийгэм, байгаль орчны хүрээг бүхэлд нь хамруулах ба бодлогын уялдааг хангах;
10. Аймгийн хөгжилд зориулагдсан төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэхийн тулд бодлогын хэрэгжилтэд тогтмол хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж байх;
11. Аймгийг хөгжүүлэх бодлогын тэргүүлэх чиглэл, зорилтыг үндэслэл сайтай боловсруулах, тэдгээрийг хэрэгжүүлэх зорилтот хөтөлбөр боловсруулах;
12. Хувийн хэвшлийн технологийн хөгжил болон инновацийн чадварыг ашиглах, үйлдвэрлэлийн тэргүүлэх салбаруудын технологийн чадавхитай холбоотой асуудлуудыг судлан авч хэрэгжүүлэх
13. Мэдлэгт суурилсан эдийн засгийн үндсийг тавих
14. Аймгийн хүний нөөцийн менежментийн шинэчлэлийг хийхэд чиглэгдсэн байна.

## **1.3 Дорноговь аймгийн хөгжлийн өнөөгийн байдал:**

**Аймгийн товч түүх:** Дорноговь аймаг нь XI, XII зууны үеийн Монголын эзэнт гүрний үед Хэрэйд аймаг, Манжийн ноёрхлын үед Түшээт хан аймаг, автономит төрийн үед Богд хаан уулын аймаг нэртэй байсан юм.

Эртнээс нааш өмнөд хилийн хаалга болсон Замын-Үүдээс Чойрыг дамжин их Хүрээ ордог гүнж зам, Чуулалт хаалгаас Улиастай ордог харчин буухиа ертөөний их замууд тус аймгийн нутгаар дайран өнгөрдөг байжээ. Энэ нь Монгол улсад гадаад худалдаа, соёл хөгжил нэвтрэх гол зам болж байв.

1911 онд Монголчууд Манжийн эсрэг тэмцэлдээ ялж, олноо өргөгдсөн Богд хаант Монгол улсыг байгуулахад Мэргэн вангийн хошуу нэрийг сэргээн тогтоосон байна.

1921 оны Ардын хувьсгалын дараагаар Монголын ард түмэн улс төр, нийгэм, эдийн засаг, соёлын амьдралдаа шинэ шинэ өөрчлөлт хийн, амжилт олж, хөгжил дэвшлийн замд орсон юм.

1931 онд Улсын Бага хурлын Тэргүүлэгчид, Засгийн газрын шийдвэрээр Дорноговь аймгийг байгуулснаар тус аймгийн шинэ үеийн түүх эхэлсэн билээ.

1942 онд Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолоор Хөдөлмөрийн гавъяаны улаан тугийн одонгоор, мал сүргээ өсгөж, улсын төлөвлөгөөт даалгаваруудыг амжилттай биелүүлсний учир 1974 онд Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн зарлигаар мөн Хөдөлмөрийн гавъяаны улаан тугийн одонгоор тус тус шагнагдсан билээ.

**Байршил, нутаг дэвсгэрийн бүтэц, бүрэлдэхүүн:** Дорноговь аймаг Монгол орны зүүн өмнөт хязгаарт Өмнөговь, Дундговь, Говьсүмбэр, Хэнтий, Сүхбаатар аймгуудтай хил залган оршдог ба БНХАУ-тай 575 км газраар хиллэдэг. 109,5 мянган кв км нутаг дэвсгэртэй. Тус аймаг 14 сум, 60 багтай. 59.8 мянган хүн амтай, 1056.8 мянган толгой малтай.

Хойд, урд хоёр гүрнийг холбосон, төвийн бүсийн хөгжлийн гол тэнхлэг болсон төмөр зам дайран өнгөрдөг. Энэ замын дагуу тус аймгийн бүх сумын 42,8 хувь, хүн амын 54,8 хувь нь оршин байдаг.

**Газрын гадарга:** Дорноговь аймгийн Айраг, Алтанширээ, Даланжаргалан, Дэлгэрэх, Иххэт сумд тал хээрийн бүсэд, Өргөн, Улаанбадрах, Эрдэнэ, Замын-Үүд, Хатанбулаг, Сайншанд, Сайхандулаан, Хөвсгөл сумд цөлөрхөг хээрийн бүсэд, Мандах сум цөлийн бүсэд хамаарагддаг. /Засгийн газрын 2006 оны 71-р тогтоол/

“Овоо”, “Дайнтовог”, “Бааст”, “Найман”, “Туулай”, “Тармаг” зэрэг уудам талууд, “Гурванбаян”, “Үнэгт”, “Төхөм”, “Хоёр заан” зэрэг өргөн хөндийнүүдтэй, нутгийн хойд хэсэг нь говь хээр хосолсон завсрын бүсэд оршино. Мөн “Оцол сансар”, “Их бага дулаан”, “Хутаг уул”, “Аргал”, “Аргалант”, “Баян”, “Арван найман” богд зэрэг уул толгод оршдог бөгөөд хамгийн нам дор газар “Баянгийн говь” далайн түвшнээс дээш 703 метр өндөрт оршино.

Аймгийн Хөвсгөл сумын хойгуур, “Гөлөө”-ний говиос зүүн тийш “Баясгалант хонгор” /1061/ овоо хүртэл өргөргийн дагуу 120 орчим км урт зурваст бага зэрэг нумран сунасан салхин гаралт бүрхэвч хэлбэрийн элс, түүнтэй зэрэгцэж сумын төвийн урдуур, “Дуутын тойром”-оос зүүн тийш улсын хил давтал 250 гаруй км урт “Хөвсгөл орчмын элс”, Эрдэнэ сумын нутагт баруун хойноос зүүн урагш сунаж, зүүн урд хэсэгтээ ацлан салсан 1100 гаруй ам дөрвөлжин км талбайд “Бүрдэний элс” үргэлжилдэг. Замын-Үүд орчмын элснээс “Борхойн талын элс” нилээд том нь юм. Салхин гаралтай энэ элс баруун хойноос зүүн урагш үл мэдэг сунаж 68 ам дөрвөлжин км талбай эзэлж оршдог.

**Уур амьсгал:** Тус аймаг бүхэлдээ говийн бүсэд хамаардаг, говь хээр хосолсон нутагтай. Эх газрын эрс тэс уур амьсгалтай, зуны улиралд +41 хэм хүртэл халж, өвлийн улиралд -40 хэм хүртэл хүйтэрдэг. Салхины дундаж хурд 4,2-4,6 м/сек, зарим үед 35 м/сек хүртэл ширүүсэх тохиолдол бий.

Дорноговь аймаг нь өргөрөгийн 42-46°- т орших учир нийлмэл цацрагийн хэмжээ 120-140 ккал/см<sup>2</sup> буюу 5028-5866 мДж/м<sup>2</sup> хүрдэг.

Цаг агаарын тааламжгүй нөлөөлөл болох хүчтэй цасан ба шороон шуурга, ган, зу дын аюул цөөн бус удаа тохиодог, сүүлийн жилүүдийн хуурайшилтын улмаас цөлжилтийн явц хурдасч байна. Говийн эмзэг байгалийг нөхөн сэргээх боломж хязгаарлагдмал.

Гадаргын усны нөөц бараг үгүйгээс гүний усыг татаж ахуй амьдрал болон мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлд ашигладаг.

**Ан амьтан, өвс ургамал:** Манай нутагт агнуурын хөхтөн 21 зүйл, жижиг хөхтөн 20-иод зүйл, 88 зүйл шувуу, 12 зүйл мөлхөгчид амьдардаг. Манай орны сээр нуруутан амьтдын зүйлийн бүрэлдэхүүний 20 орчим хувь нь Дорноговь аймагт нутагладаг. Заг, суль, харгана-хазаар өвс, хялганат, агь-өдлөг хялганат бүлгэмдэлтэй бэлчээрийг даган 12380 орчим хулан, 3280 орчим хар сүүлт, үетэн, агь-өдлөг хялганат бэлчээрт 1470 орчим аргаль, 100 гаруй янгир, агь-өдлөг хялгана, дэрст бэлчээрт дагуур огодой, бор туулай, бозлог тархан амьдардаг.

Ургамлын хувьд говийн цөлөрхөг хээрийн монгол өвст, монгол өвс, хазаар өвс, цөлөрхөг хээр голлох боловч монгол өвст-таанат, монгол өвс бударганат хээр, баглуурт буюу бор бударганат цөл нилээд дэлгэрсэн. Чихэр өвс, заг, хайлааст, зэрэг модлог ургамал, харгана бударгана зэрэг бутлаг ургамал, таана, хөмөл, монгол өвс, хазаар баглуур, шарилж, ерхөг зэрэг нэг ба олон наст ургамал ургадаг.

Зүүнбаянгаас нефтийн хайгуулын өрөм хүртэл элс ихтэй, заг, бударгана тохиолдоно. Сайншандаас баруун тийш Галбын говь хүртэл үргэлжилсэн томоохон хотгоруудын хажуугаар монгол өвст юмуу гол төлөв бударгана-монгол өвст, бударганат болон дэрст цөлийн ургамалжилттай. 15-20 км өргөнтэй өргөргийн дагуу сунаж тогтсон Хөвсгөлийн элсний район нь тэр орчмын ургамалжилтанд өвөрмөц төрхийг бүрдүүлнэ.

**Байгалийн нөөц, баялаг:** Тус аймгийн нутаг дэвсгэрт ашигт малтмалын томоохон 38 төрлийн 73 орд, 440 гаруй илэрцүүд тогтоогдсон. Үүний дотор зэсийн 2 орд, 26 илэрц, гөлтгөнийн 3 орд, 22 илэрц, хайлуур жоншны 24 орд, 52 илэрц, цеолитын 5 орд, 9 илэрц, нүүрсний 6 орд, 16 илэрц байгаа нь аж үйлдвэрийн хөгжилд ихээхэн ирээдүй байгааг харуулж байна.

#### **Эдийн засгийн салбар:**

**Дотоодын нийт бүтээгдэхүүн:** Тус аймаг нь 2010 онд ДНБ оны үнээр 57.7 тэрбум төгрөг болж 2008 оныхоос 14.3 хувиар буюу 7.2 тэрбум төгрөгөөр өслөө. Нэг хүнд ногдох ДНБ 2010 онд 966.4 мянган төгрөгт хүрч өмнөх оноос 110.4 мянган төгрөгөөр өсч, Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-ний 0,8 %-ийг, Төвийн бүсийн дотоодын нийт бүтээгдэхүүний 5,6 %-ийг үйлдвэрлэж байгаа бөгөөд энэ үзүүлэлтээр төвийн бүсдээ 6-р байр эзэлж байна.

Нэг хүнд ногдох ДНБ-ний хэмжээ оны үнээр 2006 онд 412,6 мянган төгрөг байсан бол 2010 онд 966.4 мянган төгрөг болж, 553.8 мянган төгрөгөөр буюу 2 дахин өссөн байна.

ДНБ-ийг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар авч үзвэл 34.7 хувийг хөдөө аж ахуй, 4.2 хувийг олборлох болон боловсруулах үйлдвэр, 13.5 хувийг тээвэр агуулахын үйл ажиллагаа, 0.8 хувийг барилга, 9.6 хувийг бөөний болон жижиглэн худалдаа, гэр ахуйн, барааны засварлах үйл ажиллагаа, 10.3 хувийг боловсрол, 9.4 хувийг төрийн удирдлага батлан хамгаалах, албан журмын нийгмийн даатгалын үйл ажиллагаа, 17.5 хувийг бусад салбар тус тус эзэлжээ.

Аймгийн эдийн засгийн хөгжлийн бодлого нь Сайншандын хүнд аж үйлдвэр байгуулах төсөлд тулгуурлан үйлдвэр, үйлчилгээний салбарын хөгжлийг түргэтгэн, аймгийн нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүнийг Төвийн бүс, цаашлаад Монгол Улсын түвшинд хүргэж нэмэгдүүлэн, эдийн засгийн хурдацтай өсөлтийг бий болгох явдал юм.

**Аж үйлдвэр:** Аж үйлдвэрийн салбарын эдийн засгийн үзүүлэлтүүдэд аж ахуйн нэгж байгууллагын зардал, бүтээгдэхүүний үйлдвэрлэлт биет хэмжээ, үнийн дүнгээр, бүтээгдэхүүний борлуулалт, үндсэн хөрөнгө болон санхүүгийн байдлыг харуулсан үзүүлэлтүүдийг оруулдаг.



Аж үйлдвэрийн салбарт оны үнээр 2.9 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 3.3 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүнийг зах зээлд борлууллаа.

Нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлт өнгөрсөн оны мөн үеэс 71.0 хувиар, бүтээгдэхүүн борлуулалтын орлого 38.4 хувиар тус тус нэмэгдсэн байна.

Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2005 оны зэрэгцүүлэх үнээр 2.4 тэрбум төгрөгт хүрч, өнгөрсөн оны мөн үеийнхээс 51.8 хувиар нэмэгдсэн байна.

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 86.7 хувийг төрийн өмчийн ААНБ, 13.3 хувийг хувийн өмчийн ААНБ үйлдвэрлэсэн байна.

Аж ахуйн нэгжийн хариуцлагын хэлбэрээр авч үзвэл улсын үйлдвэрийн газар 86.7 хувь, компани 10.8 хувь, хоршоо 0,03 хувь, өрхийн аж ахуй 2.7 хувийг тус тус үйлдвэрлэжээ.

Үйлдвэрлэлийг аж үйлдвэрийн дэд салбараар нь авч үзвэл цахилгаан, хий, усан хангамжийн үйлдвэрлэл 86.7 хувь, хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл 4.4 хувь, боловсруулах салбарын бусад үйлдвэрлэл 8,9 хувийг тус тус эзэлж байна. Аж үйлдвэрийн салбарт ажиллагсдын тоо өмнөх оноос 19.9 хувиар нэмэгдсэн байна.

**Хөдөө аж ахуй:** 2010 оны жилийн эцсийн мал тооллогын дүнгээр 1056.8 мянган толгой мал тоологдсоны дотор 28.1 мянган тэмээ, 77.4 мянган адуу, 40.4 мянган үхэр, 421.3 мянган хонь, 489.6 мянган ямаа тоологджээ. Нийт малын тоо 2009 оныхоос 1.9 хувь буюу 20.1 мянган толгойгоор буурсан хэдий ч малын 4 төрөлд өссөн байна. Тухайлбал: тэмээ 7.8 %, адуу 6.3 %, үхэр 1.2 %, хонь 3.1 % өсч, харин ямаа 7.5 хувиар буурсан байна.

2010 оны мал тооллогоор цэвэр үүлдрийн 12.1 мянга, сайжруулсан нутгийн үүлдрийн 239.4 мянга, нутгийн шилдэг омгийн 112.4 мянган мал тоологдов.

Өнгөрсөн онтой харьцуулахад цэвэр үүлдрийн мал 0.2 хувиар, нутгийн шилдэг омгийн мал 5.5 хувиар, сайжруулсан нутгийн үүлдрийн мал 1.3 хувиар өсчээ.

2010 онд аймгийн хэмжээнд газар тариалангийн талаар тодорхой арга хэмжээ зохион байгуулж иргэдэд үрийн төмс, зээлээр тараан өгөх, ногоо тарихад нь дэмжлэг тусламж үзүүлсэнээр нийт 41.9 га талбайд төмс, 48.6 га-д хүнсний ногоо, 161.6 тн төмс, 170.1 тн хүнсний ногоо хураан авлаа. 1 га-аас 3.8-5.5 тн төмс, хүнсний ногоо хураан авсан нь 2009 оныхоос төмс 1.7 тн, хүнсний ногоо 1.8 тн-оор нэмэгдсэн.

2010 онд 172 гахай, 286 шувуу тоологдсон нь өмнөх оноос 78 ба 47 толгойгоор буурчээ. Тэжээвэр амьтад өсгөн үржүүлдэг өрхүүд 7.45 тонн гахайн мах бэлтгэж 60.2 сая.төгрөгийн борлуулалт, 12,4 мян,ширхэг өндөг бэлтгэж 3120.5 мян.төгрөгийн борлуулалт хийсэн байна.

2010 онд 365 худаг сэргээн засварласны 342 нь энгийн уурхайн, 23 нь инженерийн хийцтэй бөгөөд худгийн засвар шинэчлэлтэд нийт 208.6 сая төгрөг зарцуулсан байна.

2010 оны байдлаар аймгийн хэмжээнд хөдөө аж ахуйн салбарт 10, хадгаламж зээлийн үйлчилгээ эрхэлж байгаа 4, худалдаа эд хэрэглээний 5, үйлдвэр, үйлчилгээний чиглэлээр 4, нийт 23 хоршоо үйл ажиллагаа явуулж байна.

Хамт олон, айл саахалт, сум орон нутгаараа хоршин хамтран үйлдвэр, үйлчилгээ эрхлэх нь ажлын бүтээмжийг дээшлүүлэн, хөрөнгө зардлыг хэмнэх, цаашлаад төрөл бүрийн эрсдлээс сэргийлэхэд чухал ач холбогдолтой юм.

Улс орны хөгжлийн чиг хандлага, төсөл, хөтөлбөрийн чиг баримжааг харахад эдийн засгийн үр өгөөж ажлын байр бий болгох, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор хоршоодод дэмжлэг үзүүлэх чиг баримжаатай байна. Мөн ойрын үед хэрэгжих Монгол мал хөтөлбөр, ХАА-н гаралтай түүхий эдийн биржийн тухай хуулийн төсөл ч мөн ялгаагүй хоршоодод давуу эрх олгох, хөрөнгө оруулалтыг чиглүүлэхээр тусгаад байгаа юм.

**Төсөв, мөнгөн гүйлгээ:** Дорноговь аймаг орон нутгийн төсвийн хувьд 2003 оноос бие даан өөрөө өөрийгөө санхүүжүүлж ирсэн, төсвийн зарлагаас давсан орлогоо улсын төсөвт төвлөрүүлдэг аймаг юм.

Орон нутгийн төсөвт 2000 – 2009 онд нийт 32380263,2 мянган төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна.

Аймгийн төсвийн орлогын 90.0 орчим хувийг татварын орлого, үлдэх хувийг татварын бус орлого, хөрөнгийн орлого бүрдүүлдэг ба төсвийн зарлагын хувьд урсгал зардал 60.0 гаруй хувь, хөрөнгийн зардал 40.0 орчим хувийг эзэлдэг.

Аймаг 2000 – 2002 онд улсын төсвөөс санхүүгийн дэмжлэг авч байсан бөгөөд 2003 оноос эхлэн бие даан өөрөө өөрийгөө санхүүжүүлж эхэлсэн. 2000-2002 он хүртэл улсын төсвөөс 6990969.1 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг авсан бол 2004 - 2010 онд улсын төсөвт 9927854.0 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлээд байна. Улсын төсөвт төвлөрүүлэх орлого жил ирэх тусам өсөн нэмэгдэж байна.

**Банк, санхүүгийн салбар:** Аймгийн хэмжээнд нийт 5 арилжааны банк 1 ББСБ үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд банкууд үйлчилгээнийхээ хүрээг өргөтгөж харилцагч иргэдийн хөрөнгийг банкинд төвлөрүүлэн, зээл олголтыг нэмэгдүүлж, аймгийн эдийн засгийн хөгжилд чухал үүрэг гүйцэтгэж байна.

Дорноговь аймагт ХААН банк, Худалдаа Хөгжлийн банк, Хадгаламж банкны 118-р салбар, ХАС банкны 02-р тооцооны төв, Голомт банкны 28-р тооцооны төв, Ундрах дэвшил ББСБ үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд арилжааны банкны 3 салбар, 31 тооцооны төв, 1 хадгаламжийн касс, нийт 35 нэгж онлайн сүлжээнд холбогдон харилцагчдад хөнгөн шуурхай үйлчилгээ үзүүлж байна.

2010 оны жилийн эцсийн байдлаар арилжааны банкуудын кассын орлого 151.5 тэр бум төгрөг болж өмнөх оноос 28.4 хувь, цэвэр зарлага 135.3 тэрбум төгрөг болж өмнөх оноос 35.8 хувиар тус тус өссөн байна. Цэвэр орлого нь зарлагаас 11.9 хувиар илүү байна.

Иргэдийн мөнгөн хадгаламж 12.4 тэрбум төгрөг болж аймгийн нэг хүнд дундажаар 207.9 мянган төгрөгийн, нэг хадгаламж эзэмшигчид дундажаар 481.2 мянган төгрөгийн хадгаламж ногдож байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад хадгаламж эзэмшигчийн тоо 6.8 хувь, хадгаламжийн үлдэгдэл 37.4 хувь тус тус өсчээ. Хадгаламжийн хэмжээ нэмэгдэж банкинд итгэх итгэл дээшилсэн ч арилжааны банкуудаас аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд олгосон зээлийн хэмжээ буурч зээлийн өрийн үлдэгдэл 60.8 хувиар буурсан, зээлийн багцад чанаргүй зээлийн эзлэх хувь 1.10 хувьд хүрч өмнөх оноос 3.4 функтээр буурсан.

**Барилга угсралт, их засвар:** 2010 онд 78 объектод нийт 25325.5 сая төгрөгийн шинэ барилга, өргөтгөл, шинэчлэлт, их засварын ажил хийгдсэн байна. Нийт хөрөнгийн 10.8 хувийг улсын төсөв, 6.5 хувийг орон нутгийн төсөв, үлдэх хувийг хувийн болон бусад төсөл хөтөлбөрийн хөрөнгөөр санхүүжүүлсэн байна. Тухайлбал: 2010 онд улс болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр нийт 8018.4 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажил хийгдсэн бөгөөд үүнээс томоохон ажлуудыг дурьдвал: “Ёс заншил, өв соёл хүндэтгэлийн ордон”-ы барилгын ажил /927,8 сая/, Замын-Үүд сумын 10 ортой халдвартын эмнэлгийн барилга угсралтын ажил, Алтанширээ сумын 60 хүүхдийн сургуулийн дотуур байрны барилга тус тус баригдаж эхэлсэн. Замын-Үүд сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах ажил /332.0 сая/, Сайншанд сумын 920 хүүхдийн суудалтай ерөнхий боловсролын сургуулийн шинэ барилгын ажлын үргэлжлэл /400.0 сая/, Сайншанд сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн спорт заалны барилгын ажлын дуусгал, Өргөн, Эрдэнэ, Сайншанд, Дэлгэрэх сумдын инженерийн хийцтэй худаг, уст цэг шинээр гаргах, засварлах ажил /148.5 сая/, Бэлчээр усжуулах зорилгоор гүний өрмийн худгуудад салхин сэнсэн шахуурга

суулгах ажил /150 сая/, Айраг, Замын-Үүд сумдын аврах гал унтраах ангийн галын авто машины гаражийн барилгын ажил /620.0 сая/, Шивээговь Халзан-Уул рашаан сувилал хүртэл 30 км 6 кв-ын цахилгаан дамжуулах агаарын шугам /256.0 сая/, Сайншанд сумын Зээгийн хөтлийн цэвэр усны шугамын угсралтын ажил, аймгийн Нэгдсэн эмнэлэгээс Төмөр замын вокзал хүртэл 4.475 км хатуу хучилттай автозамын засвар, шинэчлэлтийн ажил /739,9 сая/, Сайншанд сумын 150 хүүхдийн цэцэрлэгийн барилга, Сайншанд сумын хог хаягдлын төвлөрсөн цэгийг ландфиллын аргаар тохижуулах зэрэг ажлууд хийгдэж дууссан.

**Тээвэр, Холбоо:** Бүс нутгийн автозамыг хөгжүүлэх төслийн хүрээнд Азийн хөгжлийн банк, БНСУ-ын Засгийн газрын хөнгөлөлттэй зээл, Мянганы сорилтын сангийн хөрөнгө оруулалт санхүүжилтээр Чойр-Сайншанд-Замын-Үүд чиглэл буюу АН-3 чиглэлийн улсын чанартай 423 км автозам баригдаж байна.

Улсын замаас Сайншандын төврүү 6.9 км, Өргөн, Эрдэнэ сум хүртлэх 37.8 км автозамыг барих ажил уг төслийн хүрээнд хийгдэж байна.

Дорноговь аймгийн хэмжээнд хөнгөвчилсөн хучилттай автозам 18.1 км, цемент бетон хучилттай автозам 5.4 км, хайрган хучилттай автозам 2.2 км, 19 метр урт төмөр бетон гүүр, 93 метр бетон хоолой ашиглагдаж байна. Аймгийн төвөөс бүх сумдтай ердийн хөрсөн замаар холбогдсон.

Орон нутгийн автозамын сүлжээг сайжруулах зорилгоор орон нутгийн замын санг бүрдүүлэн ажиллаж автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвараас жилдээ 170-190 сая төгрөгийг орон нутгийн замын санд төвлөрүүлэн шинээр зам барих, засвар шинэчлэлийн ажилд зарцуулж байна. 2000-2010 оны хооронд 28,5 км замд 1234,3 сая төгрөгийн засвар шинэчлэл хийж, аймгийн төв болон бусад сум сууринд явган хүний зам 2.2 км-ыг 52.0 сая төгрөг, замын гэрэлтүүлэгт 150.8 сая төгрөг, замын тэмдэг тэмдэглэгээнд 11.6 сая төгрөг, гүүр хоолойн ажилд 35.2 сая төгрөгийн ажлыг хийж автозам, замын байгууламжийг тохижуулах ажилд нийт 1483.9 сая төгрөгийг улсын болон орон нутгийн хөрөнгө оруулалт, орон нутгийн замын сангийн хөрөнгөөр хийж гүйцэтгэсэн байна.

2004 онд БНХАУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжийн хүрээнд Замын-Үүд суманд Улсын хилээс сумын төв, төвийн доторхи автозам, замын байгууламжийг бүрэн шинэчилсэн.

Цаашид бүс нутгийн хөгжлийн хүрээнд Сайншандаас Хамарын-хийд-Зүүнбаян-Хөвсгөл-Ханги-мандал хүртэлх чиглэлд 260 км хатуу хучилттай хар зам, Сайншандаас Сүхбаатар аймгийн Баруун-Урт сум хүртэл сайжруулсан хайрган хучилттай автозамыг улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, уул уурхай компаниудын дэмжлэгтэйгээр барихаар төлөвлөөд байна.

Бүх сумд үүрэн холбооны сүлжээ болон шилэн кабелиар интернетэд холбогдсон. Олон сувгийн кабелийн телевизтэй. Үүрэн телефоны оператор 5 компаний салбар ажиллаж байгаагаас мобикомын 10, скайтелийн 9, юнителийн 11, F-Zon-2, G-Mobile -9 нийт 51 салбар сум суурин газруудад Скайтел 5500 хэрэглэгч, Мобиком 13000 хэрэглэгч, юнител 19500 хэрэглэгч, G-mobile 2300 хэрэглэгчтэй болоод байна. 30.0 мянган хэрэглэгчдэд үйлчилгээ үзүүлж нийт 2046.2 сая төгрөгийн орлоготой ажилласан нь өнгөрсөн оноос 86.1 сая төгрөгөөр илүү байна.

**Хүн ам зүй, нийгмийн салбар:** 2010 оны жилийн эцэст 59.8 мянган байнгын оршин суугчтай болж, 2009 оныхоос 3.6 хувиар, 2000 оны хүн амын тооллогоос 18.2 хувь буюу 9.2 мянган хүнээр өсөв. Аймгийн хүн амын тоо 2000 оны тооллогоос хойш жилд дундажаар 1,87 хувиар өсчээ.

Хүн амын тоогоор эхний 5 –д Сайншанд (21.1 мянга), Замын-Үүд (13.8 мянга), Айраг (3.6 мянга), Хатанбулаг (3.1 мянга), Даланжаргалан, Эрдэнэ (2.6 мянга) сумд орж байна.

Хүн амын жилийн дундаж өсөлт Замын-Үүд суманд хамгийн өндөр байна. Тус сумын хүн амын тооны өсөлт 1995 оноос эрчимжиж 2000 оноос хойш жилд дундажаар 10.8 хувиар өсч 2010 оны эцэст 13,8 мянган байнгын оршин суугчтай болжээ.

109.4 мянган кв.км нутаг дэвсгэрт 59.8 мянган хүн ам оршин суудаг бөгөөд 1 кв.км нутаг дэвсгэрт 0.55 хүн ногдож байна. Замын-Үүд, Сайншанд, Даланжаргалан сумын хүн амын нягтрал аймгийн дундажаас дээгүүр байна.

### Ажиллах хүч:

Ажиллагсад: Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэст бүртгүүлсэн, ажил идэвхитэй хайж байгаа иргэдийн тоо 2010 оны жилийн эцэст 642 байгаа нь өмнөх оноос 20.7 хувиар өсчээ. 2010 онд 775 хүн шинээр бүртгүүлсэн ба бүртгэлтэй ажилгүй иргэдээс 798 хүн ажилд зуучлуулан оржээ.

2010 онд 1332 иргэн шинээр ажилд орсны 63.3 хувь нь байнгын ажлын байртай болжээ. Эдийн засгийн үйл ажиллагааны салбараар авч үзвэл уул уурхай болон олборлох аж үйлдвэрийн салбарт 31.8 хувь, нийгмийн салбарт 26.5 хувь, боловсролын салбарт 10.6 хувь бусад салбарт 31.2 хувь нь ажилд орсон байна. Шинээр ажилд орсон хүний тоо өмнөх оныхоос 33.1 хувиар өсчээ.

Боловсрол, соёл: 2010-2011 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын 20 сургуульд 10940, Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, ЭМШУИС-ийн харьяа салбар сургуульд 1793, нийт 12733 оюутан, сурагч суралцаж байна. Сурагчдын сурлагын стандарт хангалт 97.0 хувь байгаа нь өнгөрсөн онтой харьцуулахад 1.0 пунктээр өссөн байна. ЭМШУИС-ийн харьяа салбар сургуульд 200 оюутан элсэн орсны 146 нь их эмч болон бусад дээд мэргэжлээр, 54 эм зүйч мэргэжлээр элссэн ба МСҮТ-д 12 мэргэжлээр 437 хүүхэд шинээр элсэж 843 оюутантайгаар хичээллэж байна.

Хүн амын эрүүл мэнд: Дорноговь аймгийн хүн амын эрүүл мэндийн үйлчилгээнд эрүүл мэндийн бүх шатны 87 байгууллагад нийт 856 хүн ажиллаж байна. Үүний дотор 210 их эмч, 88 эх баригч, бага эмч, 185 сувилагч ажиллаж байна. Нэг их эмчид 285 хүн, 1 сувилагчид 323 хүн ногдож байна. 2010 онд эмнэлэгийн орны тоо 366 болж 2.8 хувиар өслөө. 13.8 мянган хүн эмнэлэгт хэвтэж эмчлүүлсний 46.7 хувь нь аймгийн нэгдсэн эмнэлэгт, 5.3 хувь нь хувийн өмчийн эмнэлэгүүдэд хэвтэж эмчлүүлжээ.

### **1.4 Дорноговь аймгийн хөгжлийн боломж, давуу болон сул талын үнэлгээ:**

<u>Давуу тал</u>	<u>Сул тал</u>
<ul style="list-style-type: none"> <li>- ОХУ болон БНХАУ-ыг холбосон, төвийн бүсийн дэд бүтцийн гол тэнхлэг болсон төмөр зам дайран өнгөрдөг. Энэ замын дагуу тус аймгийн 6 сум /бүх сумын 42.8%/ оршдог.</li> <li>- Дорноговь аймаг БНХАУ-тай хиллэдэг. Хилийн байнгын үйл ажиллагаатай Замын-Үүд боомт, Ханги-Мандал түр боомт ажилладаг нь хил орчмын хамтын ажиллагааны тааламжтай нөхцөл бүрдүүлдэг.</li> <li>- Чойр-Сайншанд-Замын-Үүд чиглэлийн 432 км авто зам барих ажил хийгдэж байна.</li> <li>- Багануур-Сайншанд 220 кВ, Сайншанд-Замын-Үүд 110 кВ, Сайншанд-Зүүнбаян 35 кВт-ын төвлөрсөн цахилгаан эрчим хүчний системд холбогдсон.</li> <li>- Мандах, Хатанбулаг сумдад нар болон салхин цахилгаан станцтай, бусад сумд төвийн өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах шугамд холбогдсон.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Гадаргын усны нөөц бага</li> <li>- Сумдын үйлдвэрлэл, дэд бүтцийн хөгжил янз бүр байгаагаас хүн амын шилжих хөдөлгөөн их гардаг.</li> <li>- Хүн ам цөөн</li> </ul>

<ul style="list-style-type: none"> <li>- Харилцаа холбоо, мэдээлэл дамжуулах боломж харьцангуй сайн үүрэн холбооны 5 оператор үйл ажиллагаагаа явуулж байгаа</li> <li>- Айраг, Алтанширээ, Даланжаргалан, Дэлгэрэх, Сайхандулаан, Мандах, Сайншанд, Замын-үүд, Эрдэнэ, Өргөн сумд шилэн кабелиар холбогдсон.</li> <li>- Аж үйлдвэрт хэрэглэх түүхий эд, жонш, чулуу, хүрэн нүүрсний ордуудтай ойр байрлалтай.</li> <li>- Сайншандаас хойшоо 10 км-т ЗХУ-ын үед цэргийн зориулалтаар ашиглаж байсан хүнд даацын нисэх онгоц хүлээн авах 2,8 км-ын буух зурвас нөөц аэродромтой.</li> <li>- Мөн Сайншандаас 45 гаруй км-т Бор хөөврийн говийн гүний усны томоохон нөөцтэй.</li> <li>- Газар чичирхийллийн хувьд нутаг дэвсгэр бүхэлдээ аюулгүй буюу 6 баллын бүсэд хамаарагддаг, мөнх цэвдэггүй</li> <li>- Палантеологийн чухал олдворууд бүхий байгалийн унаган төрхөөрөө байгаа говь нутаг</li> <li>- Мал сүргээ өсгөх тааламжтай бэлчээр нутагтай</li> <li>- Хүн ам цөөтэй ч насны бүтэц харьцангуй залуу, эдийн засгийн идэвхитэй хүн амын эзлэх хувь өндөр</li> <li>- Хүн амын боловсролын түвшин харьцангуй сайн.</li> <li>- Анхан шатны сургуульд хамрагдалт сайн, бичиг үсэг тайлагдалтын түвшин өндөр</li> </ul>	
<p style="text-align: center;"><b>- <u>Боломж</u></b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Олон улсын агаарын нислэгийн гол шугам дайран өнгөрдөг</li> <li>- Сайншанд-Зүүнбаян-Ханги мандалын чиглэлийн 260 км авто замын ажил хийгдэхээр зураг төсөв бэлэн болсон.</li> <li>- Таван толгой-Зүүнбаян-Сайншандын чиглэлийн төмөр замыг барих нь Цагаан суварга, Үнэгт, Зүүнбаян зэрэг зэс молибден, гөлтгөнө, цеолит, нефтийн арвин ордуудыг дайран өнгөрөх ачаа эргэлт, эдийн засгийн өндөр ач холбогдолтой бөгөөд Даланзадгад-Сайншанд-Чойбалсан чиглэлийн 1100 км төмөр зам баригдах ажлын суурь тавигдсан.</li> <li>- Монгол Улсын Засгийн газраас Сайншанд аж үйлдвэрийн цогцолбор төв байгуулах бодлого чиглэл гарч, бодитой хэрэгжих нь тодорхой болсон.</li> <li>- Мөн Оюутолгой, Таван толгой, Цагаан суварга гээд томоохон ордуудтай болон өмнөд хөрштэй газар зүйн байршлын хувьд ойр.</li> <li>- Байгалийн баялаг, ашигт малтмал, эрдсийн асар их нөөцтэй</li> <li>- Говийн байгаль, нүүдлийн соёл, түүх дурсгалууд, эртний шим ертөнцийн үлдэгдэл, ховор ан амьтан их зэрэг нь аялал жуулчлал хөгжүүлэх тааламжтай орчин болдог</li> </ul>	<p style="text-align: center;"><b><u>Саад бэрхшээл</u></b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Цаг агаарын тааламжгүй нөлөөлөл ихтэй. Хүчтэй цасан ба шороон шуурга, ган, зудын аюул цөөн бус удаа тохиодог</li> <li>- Эмзэг байгальтай. Нөхөн сэргээгдэх нөхцөл хүнд. Элсний нүүдэл, цөлжилтийн давагдашгүй хүчин зүйлийн нөлөөлөлтэй</li> </ul>

## **ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛ**

### **2.1 ДОРНОГОВЬ АЙМГИЙН ХӨГЖЛИЙН АЛСЫН ХАРАА, ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛҮҮД**

#### **2.1.1 АЛСЫН ХАРАА:**

**Эдийн засгийн тогтвортой өсөлт хангагдсан, байгаль орчинд ээлтэй, хүн ам оршин суух таатай нөхцөл бүрдсэн эдийн засаг, нийгмийн бие даасан Бүс нутгийн хөгжлийн тулгуур төв болж хөгжинө.**

#### **2.1.2 ХӨГЖЛИЙН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ:**

2.1.2.1 Хүнд аж үйлдвэр, уул уурхайн олборлох, боловсруулах үйлдвэрлэл, эрчимжсэн мал аж ахуй, хоршоо, жижиг дунд үйлдвэрлэл, зам тээврийн үйлчилгээ, аялал жуулчлалын салбарыг түлхүү хөгжүүлсэн эдийн засгийг төлөвшүүлж, түүний хөгжлийг түргэтгэх

2.1.2.2 Нийгмийн үйлчилгээний байгууллагуудын хүчин чадлыг өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээнд тулгуурлан өргөтгөх, үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх замаар хүн ам оршин суух, хөгжих таатай нөхцөлийг бүрдүүлэх

2.1.2.3 Хүрээлэн байгаа орчны аюулгүй тогтвортой байдлыг хангах

2.1.2.4 Төрийн албыг төлөвшүүлж, түүний ил тод, нээлттэй, шударга, шуурхай байдлыг хангах

### **2.2 Эдийн засаг, орон нутгийн төсөв, санхүү, татварын болон хөрөнгө оруулалтын бодлого**

#### **2.2.1 Эдийн засгийн бодлого:**

Эдийн засгийн бодлогын зорилт нь 2010-2016 онд Сайншанд аж үйлдвэрийн цогцолбор байгуулах бэлтгэл ажлыг хангах, хөрөнгө оруулалтын үр ашгийг тасралтгүй дээшлүүлж, үйлдвэр, үйлчилгээний салбарын хөгжлийг түргэтгэх замаар дотоодын нийт бүтээгдэхүүнийг нэмэгдүүлж, эдийн засгийн эрчимтэй хөгжлийн үндэс суурийг тавих, 2017-2021 онд хувийн хэвшилд түшиглэсэн, өндөр технологт суурилсан, экспортын баримжаатай, боловсруулах салбарын үйлдвэрлэлийг эрчимтэй хөгжүүлж, эдийн засгийг олон талтай болгож, мэдлэгт суурилсан эдийн засгийг төлөвшүүлэн хөгжүүлж, нэг хүнд ногдох дотоодын нийт

бүтээгдэхүүнийг 15,0 мянган долларт хүргэж нэмэгдүүлэн, эдийн засгийн хурдацтай өсөлтийг бий болгох явдал юм.

Сумдын бүсчлэлд тулгуурлан дэд бүтцийг эрчимтэй хөгжүүлж, сумдын бүсийн онцлог нөөц бололцоонд тулгуурласан үйлдвэр, үйлчилгээг бий болгон сумд хоорондын хөгжлийн түвшний ялгааг багасган бизнес эрхлэх таатай орчин бүрдүүлж, эдийн засгаа тэнцвэртэй хөгжүүлнэ.

### **Учирч болох эрсдэл, түүнийг тооцох нь:**

- Макро эдийн засгийн нөхцөл байдал муудаж, улсын төсвийн нөөц боломж буурах.
- Үйлдвэрлэлийн менежментийн чадавхи бүхэлдээ доогуур, үйлдвэрлэгчид урт хугацаанд бизнесээ төлөвлөн хөгжүүлэх сонирхол, чадавхи бага байгаа өнөөгийн байдал цаашид үргэлжлэх;
- Үйл ажиллагааны эрсдэл буюу төсвийн хөрөнгийг зүй зохистойгоор дахин хуваарилахад төрийн байгууллагуудын бэлэн бус байгаа байдал. Энэхүү эрсдэл үүсэх магадлал нэлээд өндөр бөгөөд үр дагавар нь тавьсан зорилгодоо хүрч чадахгүй байх, хугацаа алдах, тухайн үр дүнд хүрэхэд шаардагдах зардал өсөх зэрэг болно.
- Давагдашгүй хүчин зүйлийн эрсдэл буюу олон улсын улс төр, эдийн засаг, технологийн нөхцөл байдлын таагүй өөрчлөлт.

**Нэгдүгээр үе шат (2011-2013 он): Эдийн засгийн хөгжлийн өнөөгийн түвшинг бататган, үйлдвэржилтийн бодлогыг тууштай дэмжиж, уул уурхай, боловсруулах үйлдвэр, хөдөө аж ахуй, орон нутгийн түүхий эдэд тулгуурласан жижиг, дунд үйлдвэрлэлийг эрчимтэй хөгжүүлж, тээвэр, холбоо, нийтийн аж ахуй, ахуйн үйлчилгээг сайжруулан, мал аж ахуй, газар тариалангийн бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлэх, бизнесийн шударга өрсөлдөөнийг хөгжүүлэх замаар эдийн засгийн хурдацтай өсөлтийг бий болгоно.**

**2.2.1.1 Тэргүүлэх зорилт: Эдийн засгийн бүтцийг сайжруулж, ДНБ-д үйлдвэр үйлчилгээний салбарын эзлэх хувийг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.**

#### **Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

2.2.1.1.1 Төвийн бүсийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгах асуудлуудыг оновчтой тодорхойлж, бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулна;

2.2.1.1.2 Сайншандын аж үйлдвэрийн цогцолбор байгуулах ажлын суурь бэлтгэлийг хангаж, эхлүүлнэ;

2.2.1.1.3 Төмөр замын талаар төрөөс баримтлах бодлого, Өмнөд говийн дэд бүтцийг хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд бүтээн байгуулалтын ажлуудыг эхлүүлнэ;

2.2.1.1.4 Аймаг орон нутагт үйлдвэрлэх боломжтой хүнсний болон өргөн хэрэглээний барааны үйлдвэрлэлийг хөгжүүлж, импортоос хэт хараат байдлыг багасгах суурийг тавина;

#### **Хоёрдугаар үе шат (2014-2016 он):**

### **2.2.1.2 Тэргүүлэх зорилт: Аймгийн эдийн засгийн салбарын бүтцийг шинэчлэн, ДНБ-ний жилийн дундаж өсөлтийг нэмэгдүүлнэ.**

#### **Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

2.2.1.2.1 Сайншандын аж үйлдвэрийн цогцолбор байгуулах төслийн хүрээнд Кокс, хар төмөрлөг, нүүрс хийжүүлэх, зэс хайлуулах, барилгын материал, газрын тос боловсруулах зэрэг үйлдвэрүүд байгуулах бэлтгэлийг хангаж, усан хангамж, зам харилцаа холбоо, байгаль орчны дэд бүтцийг шинээр байгуулахад орон нутгаас шалтгаалах арга хэмжээг авч, дэмжлэг үзүүлнэ;

2.2.1.2.2 Олон улсын байгууллагууд, банк, санхүүгийн байгууллагуудтай хамтран зээлдэгч буюу үйлдвэрлэл эрхлэх хүсэлтэй оролцогчдыг хамруулсан сургалт, зөвлөгөөг үе шаттайгаар явуулна;

2.2.1.2.3 Төвийн бүсийн хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлж, эдийн засгийн салбарын хүрээнд тавьсан үр дүнг хангасан байна;

2.2.1.2.4 Боловсруулах аж үйлдвэрийг дэвшилтэт арга, технологиор хөгжүүлэх замаар нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжиж, аймгийн эдийн засгийн суурь бүтцийг сайжруулна;

2.2.1.2.5 Шинжлэх ухаан, технологи, инновацийг нэвтрүүлэн хөгжүүлнэ;

2.2.1.2.6 Үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтцийг шинээр байгуулах, өргөтгөх асуудлыг үйлдвэржилтийн бодлоготой уялдуулан төр, хувийн хэвшлийн түншлэлд түшиглэн хөгжүүлнэ;

### **2.2.1.3 Тэргүүлэх зорилт: Бизнес эрхлэх таатай орчинг бүрдүүлж, мэдлэг мэдээлэлд суурилсан эдийн засгийн үндэс суурийг тавина.**

#### **Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

2.2.1.3.1 Дотоод, гадаадын зах зээлд өрсөлдөх боломжтой өндөр технологид суурилсан үйлчилгээ, оюуны багтаамжтай бага оврын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг түлхүү хөгжүүлнэ;

2.2.1.3.2 Мэдээлэл харилцаа холбооны орчин үеийн сүлжээг бий болгоно;

2.2.1.3.4 Эдийн засагт дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх замаар мэдлэг, мэдээлэлд суурилсан эдийн засгийн үндэс суурийг бий болгоно;

2.2.1.3.5 Экспортын баримжаатай, импортыг орлох үйлдвэрлэлийг дэмжиж нийт үйлдвэрлэлийн хэмжээ, цар хүрээг өргөтгөнө;

2.2.1.3.6 Сумдын урт хугацааны хөгжлийн баримт бичиг, хөтөлбөрүүд, хот суурин газруудын ерөнхий төлөвлөгөөний дагуу хөгжлийг түргэтгэхэд чиглүүлнэ;

#### **Гуравдугаар үе шат (2017-2021 он):**

### **2.2.1.4 Тэргүүлэх зорилт: Оюуны шингэц бүхий, өндөр технологт суурилсан үйлдвэрлэлийн эзлэх байр суурийг бэхжүүлж, аймгийн бие даан хөгжих нөхцөлийг бүрдүүлэх**

#### **Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

2.2.1.4.1 Сайншандын аж үйлдвэрийн цогцолборт тулгуурлан аймаг бие даан хөгжих нөхцөлийг бүрдүүлнэ;

2.2.1.4.2 Үйлдвэрлэл, технологийн паркуудаар дамжуулан дэвшилтэт техник, технологийг тууштай нэвтрүүлэхийг дэмжинэ;

2.2.1.4.3 Эрчим хүчний хэмнэлтэт технологи болон сэргээгдэх эрчим хүчний технологийг ашиглахыг дэмжинэ;



2.2.1.4.4 Үйлдвэрлэл, үйлчилгээ, бизнес эрхлэх таатай орчин бүрдүүлж олборлох, боловсруулах үйлдвэрийн бүтээгдэхүүнийг экспортод гаргана;

2.2.1.4.5 Мал аж ахуй, газар тариалангийн түүхий эд боловсруулах үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн, экологийн цэвэр бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжинэ;

2.2.1.4.6 Өндөр технологийн болон оюуны шингэц бүхий бага оврын техник, тоног төхөөрөмжийн импортыг дэмжинэ;

**2.2.1.5 Тэргүүлэх зорилт: Зах зээлийн эрэлт хэрэгцээ, шаардлагыг хангахуйц өрсөлдөх чадвартай салбарыг бий болгон хөгжүүлнэ.**

#### **Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

2.2.1.5.1 Барилгын материалын шинэ технологид түшиглэсэн шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн гаргахыг дэмжинэ;

2.2.1.5.2 Өндөр технологид тулгуурласан гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх таатай орчныг бий болгох, түүгээр дамжуулан шинжлэх ухааны шинэ мэдлэг, менежмент, үйлдвэрлэлийн судалгааны лаборатор бий болгох нөхцөлийг бүрдүүлнэ;

2.2.1.5.3 Дотоодод үйлдвэрлэсэн өндөр технологийн бүтээгдэхүүнийг экспортлоход анхаарна;

2.2.1.5.4 Гадаад, дотоодын дэвшилтэт тэргүүний технологийг сонгон нэвтрүүлэх, нутагшуулах үйл ажиллагааг эрчимжүүлнэ;

2.2.1.5.5 Бүтээгдэхүүний үр өгөөж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх замаар эдийн засгийн шинэчлэлд оруулах хувь нэмрийг нэмэгдүүлнэ;

**Гарах үр дүн:** Аймгийн ДНБ-ний бодит өсөлт тогтворжиж, мэдлэгт суурилсан эдийн засгийн үндэс суурь бий болж, бизнес эрхлэх таатай орчин бүрдэн, аймгийн эдийн засагт аж үйлдвэр, үйлчилгээний салбар тэргүүлэх байр суурьтай болсноор аймгийн Дотоодын нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээ нэмэгдэж, 1 хүнд ногдох Дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээг 2021 оны зорилтот хүрэх түвшинд хүргэнэ.

## **2.2.2 Орон нутгийн төсөв, санхүү, татварын бодлого**

### **Өнөөгийн байдал:**

Дорноговь аймгийн орон нутгийн төсөвт 2000 – 2009 онд нийт 32380263.2 мянган төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна. Үүнд:

- Хувь хүний орлогын албан татвар 3818694.2 мянган төгрөг
- Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ 4200370.0 мянган төгрөг
- Дотоодын бараа үйлчилгээний нэмэгдсэн өртгийн албан татвар 2755179.1 мянган төгрөг
- Лицензийн төлбөр 4787550.0 мянган төгрөг
- Бусад татвар хураамж 4863422.5 мянган төгрөг

## **Банк, санхүүгийн салбар**

Аймгийн хэмжээнд нийт 6 арилжааны банк 1 ББСБ үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд банкууд үйлчилгээнийхээ хүрээг өргөтгөж харилцагч иргэдийн хөрөнгийг банкинд төвлөрүүлэн, зээл олголтыг нэмэгдүүлж, аймгийн эдийн засгийн хөгжилд чухал үүрэг гүйцэтгэж байна.

### **Давуу тал:**

- Аймаг, сумын Иргэдийн төлөөлөгчдийн Хурлаар баталсан төсвийн орлогын төлөвлөгөөг жил бүр амжилттай биелүүлдэг.
- Орон нутгийн төсвийн хувьд өөрийгөө санхүүжүүлж, санхүүгийн хувьд орон нутгийн бие даасан байдлыг бэхжүүлэх бүрэн боломжтой.
- Сүүлийн жилүүдэд хилийн боомтуудын хүчин чадал нэмэгдэж, гадаад худалдааны эргэлт сайжирч, үүнээс улбаалан хил, гаалийн худалдаа, зорчигчдын хөл хөдөлгөөн нэмэгдэн ялангуяа Замын-Үүдийн боомтоор зорчигчдын тоо олширч, гадаад, дотоодын машинаас авах татвар, хураамж, ард иргэдээс авах төлбөр өсөн нэмэгдэж байна.
- Тус аймгийн төв Сайншанд хотод аж үйлдвэрийн парк байгуулагдахтай холбогдуулан Монгол улсын томоохон үйлдвэрүүд байгуулагдаж, хүн ам олноор суурьших нөхцөл үүсч байгаа ба үүнийг дагалдах үйлдвэр, жижиг бизнес хөгжих тул аймгийн эдийн засаг өснө.

### **Сул тал:**

- Эдийн засагт түшиц суурь болохуйц хувийн хэвшлийн томоохон аж ахуйн нэгж цөөн, татварын бааз суурь муутай.
- Зах зээлийн багтаамж муу, мөнгөний урсгалыг өөрийн аймагт татах нөхцөл сайн бүрдээгүй.

### **Учирч болох эрсдэл, түүнийг тооцох нь:**

- Төсвийн орлогын зарим нэр төрлүүд тухайлбал Замын-Үүд, Ханги Мандалын хилийн боомттой холбоотой орлогууд гадаад хүчин зүйл болох хүн малын халдварт өвчин, гадаад дотоод улс төрийн нөхцөл байдал, хил гаалийн эрх зүйн өөрчлөлт гэх мэт нөхцлүүдээс шалтгаалан буурах эрсдэлтэй.
- Бэлэн мөнгөөр үйл ажиллагаа явуулдаг салбар их бөгөөд мэдээлэл солилцох механизм бүрдээгүйгээс далд эдийн засгийг илрүүлэх боломж хангалтгүй.
- Татвар төлөгчдийн зан үйл, тэдгээрийн татварт хандах сэтгэл зүй төлөвшөөгүйгээс татварын хууль тогтоомжийг сайн дураар биелүүлэхгүй байх, орлогыг нуун даргадуулах татвараас зугтаах эрсдэлтэй.
- Төсвийн зарлагыг байгууллагын үйл ажиллагааны үр дүн болон хөтөлбөрт суурилсан бодитой төлөвлөхгүй байгаагаас шалтгаалан төсвийн үр ашгийг тодорхойлох боломжгүй байх.

### **Бүх үе шат (2011-2021 он)**

**2.2.2.1 Тэргүүлэх зорилт: Санхүүгийн хувьд орон нутгийн бие даасан байдлыг ханган, бүх шатны төсөв захирагчдийн эрх мэдлийг дээшлүүлнэ.**

**Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

2.2.2.1.1 Төсөв, санхүүгийн асуудлыг зохицуулсан холбогдох хуульд орон нутгийн төсвийн эрх мэдлийг дээшлүүлэх, төсвийн төвлөрлийг сааруулах чиглэлээр өөрчлөлт оруулах саналыг боловсруулж, холбогдох байгууллагуудад хүргүүлнэ;

2.2.2.1.2 Бүх шатны төсвийн эрх захирагчдын төсөв санхүү, эдийн засгийн мэдлэгийг дээшлүүлж, сургалт семинарт хамруулна;

2.2.2.1.3 Төсвийн орлогын тогтвортой байдлыг хангаж, орон нутгийн төсвийн хувьд бие даан өөрийгөө санхүүжүүлнэ;

**2.2.2.2 Тэргүүлэх зорилт: Орон нутгийн банк, санхүүгийн тогтолцоо үйлчилгээг боловсронгуй болгож, хувийн хэвшлийн бизнесийн таатай орчин бий болгоно.**

**Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

2.2.2.2.1 Банк, санхүүгийн үйлчилгээг өргөжүүлэх, зээлийн хүүг бууруулан бизнес эрхлэгчдийг дэмжинэ;

2.2.2.2.2 Олон улсын нийтлэг арга зүйд тулгуурласан статистикийн үндэсний стандартыг мөрдөж, мэдээллийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэн, хэрэглэгчдийг чанартай мэдээлэл, шуурхай үйлчилгээгээр хангана;

2.2.2.2.3 Даатгалын үр өгөөжийг дээшлүүлж, хэрэгжүүлж ажиллана;

2.2.2.2.4 Санхүү, банк, татвар, аудит, хяналт шалгалтын ажлын уялдаа холбоог сайжруулж, хариуцлагыг нэмэгдүүлэх, төлөвлөлт, бүртгэл мэдээлэл, хяналтын үр дүнг дээшлүүлнэ;

**2.2.2.3 Тэргүүлэх зорилт: Төсвийн эх үүсвэрийг орон нутгийн хөгжлийн бодлогод зориулан оновчтой хуваарилах замаар хүн амын бодит орлого, нийгмийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэн салбарын хөгжлийг дэмжихэд чиглэгдэнэ.**

**Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

2.2.2.3.1 Татварын орлогын бааз суурийг өргөтгөн төсвийн зарцуулалтын үр ашгийг дээшлүүлнэ;

2.2.2.3.2 Татварын нэр төрөл, татвар ноогдуулах аргачлалыг олон улсын жишигт нийцүүлж, хуримтлагдсан татварын зээлийн татварын тогтолцоог хэрэгжүүлнэ;

2.2.2.3.3 Төсвийг аймгийн хөгжлийн хөтөлбөртэй уялдуулан боловсруулж, хэрэгжүүлэх эрх зүйн зохицуулалтыг бий болгоно;

**Хүрэх үр дүн:** Төсвийн тогтвортой байдал хангагдан, орон нутгийн төсвийн тэнцэл эерэг гарч, санхүүгийн дотоод хяналт дээшилж, төсвийн үр ашиг нэмэгдсэн байна.

## **2.2.3 Хөрөнгө оруулалтын бодлого**

**Үндэслэл буюу өнөөгийн байдал:** Хөрөнгө оруулалтын бодлогын арга хэмжээг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, жил бүрийн аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд бодлогын зорилгоор тусгаж, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэн, батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулан тайлагнаж ажиллаж байна.

Хөрөнгө оруулалтын сүүлийн жилүүдийн статистик тоон мэдээнээс дүгнэхэд: 2000-2004 онуудад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 4326.3 сая төгрөгийн, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 3519.8 сая төгрөгийн, төсөл хөтөлбөрөөр 1837.7 сая төгрөгийн, хувийн хөрөнгө оруулалтаар 3714.6 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн бол, 2004-2009 оны байдлаар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 18824,7 сая төгрөгийн, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 7693,2 сая төгрөгийн, төсөл хөтөлбөрөөр 23539,1 сая төгрөгийн, хувийн хөрөнгө оруулалтаар 16457,9 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн нь 2000-2004 оны дундажтай харьцуулбал улсын төсвийн хөрөнгө оруулалт 4,4 дахин, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт 2,2 дахин, төсөл, хөтөлбөрийн хөрөнгө оруулалт 12,8 дахин, хувийн хөрөнгө оруулалт 4,4 дахин нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

“Сайншанд” аж үйлдвэрийн цогцолбор байгуулах төсөл болон аймгийн хөгжлийн мастер төлөвлөгөөнд тусгагдсан хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтад шаардагдах хөрөнгийг бүрдүүлэхэд нэг төрлийн хөрөнгийн эх үүсвэрт түшиглэх боломжгүй. Иймд төслийг санхүүжүүлэх хөрөнгийг боломжит эх үүсвэрүүдээс, үе шаттайгаар бүрдүүлэхээр төлөвлөх юм. Үүнд хувийн хөрөнгө оруулалт, төр, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт голлох байр суурьтай болж байна.

**Давуу тал:**

- Төвлөрсөн дэд бүтцийн салбарын хөгжил сайтай.
- Цахилгаан дулаан, ус хангамж зэрэг дэд бүтцийг өргөжүүлэх боломжтой.
- Төмөр замын талаар төрөөс баримтлах бодлого, Сайншанд аж үйлдвэрийн цогцолбор төв байгуулахад чиглэл батлагдсан.

Боломжууд:

- “Сайншанд” аж үйлдвэрийн цогцолбор барьж байгуулсанаар эдийн засгийн бодит өсөлт, аж үйлдвэрийн салбарын хөгжилд ихээхэн хувь нэмэр үзүүлнэ.
- Шинэ үйлдвэрүүд баригдах бөгөөд үүнтэй уялдан ихээхэн хэмжээний дэд бүтэц, барилга бүтээн байгуулалтын ажлууд хийгдэнэ.

**Сул тал:**

- Хөдөлмөрийн нөөцийн дутмаг байдал.
- Байгаль орчинд сөрөг нөлөө гарах магадлалтай.
- Усны нарийвчилсан судалгаа хийх шаардлагатай байгаа.

**Учирч болох эрсдэл, түүнийг тооцох нь:**

- Хөрөнгийн эх үүсвэр дутсанаас эхлүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилт удаашрах, цаг хугацаа алдах магадлалтай.
- Аж үйлдвэрийн цогцолборт байгуулах үйлдвэрүүдийн өрсөлдөх чадвар нь дэлхийн зах зээлийн шаардлагыг хангахгүй байх.
- Байгалийн нөөц хүрэлцэхгүй байх.
- Санхүүгийн нөөцийн дутмаг байдал.
- Зах зээл дэх үнийн хэлбэлзэл төслийн үр ашгийг бууруулах явдал.

**Нэгдүгээр үе шат (2011-2013 он): Эдийн засгийн хөгжлийн өнөөгийн түвшинг бататган, үйлдвэржилтийн бодлогыг тууштай дэмжиж, уул уурхай, боловсруулах үйлдвэр, хөдөө аж ахуй, орон нутгийн түүхий эдэд тулгуурласан хоршоо, жижиг, дунд үйлдвэрлэлийг эрчимтэй**

**хөгжүүлж, тээвэр, холбоо, нийтийн аж ахуй, ахуйн үйлчилгээг сайжруулан, мал аж ахуй, газар тариалангийн бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлэх, бизнесийн шударга өрсөлдөөнийг хөгжүүлэх замаар эдийн засгийн хурдацтай өсөлтийг бий болгоно.**

**2.2.3.1 Тэргүүлэх зорилт: Урт хугацааны хөрөнгө оруулалтын төслийг дунд хугацааны болон богино хугацааны хөгжлийн хөтөлбөрт тусгах замаар хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд чиглүүлнэ.**

**Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

2.2.3.1.1 Орон нутгийн хөгжлийн бодлого болон хот байгуулалт, дэд бүтцийн салбарт хийгдэх хөрөнгө оруулалтын бодлогыг хэрэгжүүлнэ.

2.2.3.1.2 Концессын хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлж, сумдын эмнэлэг, сургууль, цэцэрлэг, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв, спорт цогцолбор, худалдаа үйлчилгээ зэрэг нийгмийн дэд бүтцийн барилга байгууламжийг төр-хувийн хэвшлэлийн түншлэлд тулгуурлан барьж байгуулан, өргөтгөх ажлыг хийж эхлүүлнэ.

**2.2.3.2 Тэргүүлэх зорилт: Өмнөд говийн дэд бүтцийг хөгжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлэн, Сайншанд аж үйлдвэрийн цогцолбор төслийг эхлүүлэх бэлтгэлийг хангана.**

**Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

2.2.3.2.1 Өмнөд говийн дэд бүтцийг хөгжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ;

2.2.3.2.2 Шинээр барьж байгуулах болон дахин төлөвлөлт хийж хөгжүүлэх хот, суурины байршил, хүчин чадлыг тодорхойлох, хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй болгох тал дээр анхаарч ажиллана;

2.2.3.2.3 “Сайншанд” аж үйлдвэрийн цогцолбор төсөл хэрэгжихтэй холбогдуулан эрүүл мэнд, боловсрол, орон сууцны хангамж зэрэг нийгмийн суурь үйлчилгээг сайжруулахад чиглэгдсэн хөрөнгө оруулалтыг түлхүү хийхэд анхаарна;

2.2.3.2.4 Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийг өргөтгөх чиглэлээр хөрөнгө оруулалт хийнэ;

2.2.3.2.5 Хүн амд нийгмийн үйлчилгээг хүргэхэд төр-хувийн хэвшлийн идэвхитэй оролцоо, хамтын ажиллагааг дэмжинэ;

**Гарах үр дүн:** Сургуулийн өмнөх насны хүүхдийн сурч, хүмүүжих орчин нөхцөл сайжирч, зарим сумдын шинэ цэцэрлэгүүдийн барилга баригдаж эхэлсэн байна. Өмнөд говийн дэд бүтцийг хөгжүүлэх хөтөлбөрийн хэрэгжилт эрчимжиж, “Сайншанд” аж үйлдвэрийн цогцолбор байгуулах суурь бэлтгэл ажлууд хийгдэж эхэлсэн байна.

**Хоёрдугаар үе шат (2014-2016 он):**

**2.2.3.3 Тэргүүлэх зорилт: Төсвийн хөрөнгө оруулалтыг Мянганы хөгжлийн зорилтуудтай оновчтой уялдуулан нэмэгдүүлж, урт, дунд хугацааны хөгжлийн хөтөлбөр, төслүүдэд суурилуулан хэрэгжүүлнэ.**

**Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

2.2.3.3.1 Төсвийн хөрөнгө оруулалтыг орон нутгийн хөгжлийн индекс тулгуурлан зорилтот хөтөлбөр, аймгийн хөгжлийн урт хугацааны төлөвлөгөө, төслүүдэд үндэслэн хуваарилах бодлогыг дэмжинэ;

2.2.3.3.2 Төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурласан бүтээн байгуулалтын ажлуудыг эрчимжүүлнэ.

2.2.3.3.3 Дэд бүтцийн салбарт хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ;

2.2.3.3.4 Мэдээлэл, холбооны орчин үеийн техник, технологи нэвтрүүлэх, мэргэжилтэй ажиллах хүчнийг бэлтгэхэд төсвийн хөрөнгө оруулалтаар дэмжлэг үзүүлнэ;

2.2.3.3.5 Нийгмийн үйлчилгээний батлагдсан жишиг нормативын дагуу сумдын эмнэлэг, сургууль, цэцэрлэг, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв, спорт цогцолбор, худалдаа үйлчилгээ зэрэг нийгмийн дэд бүтцийн барилга байгууламжийг барьж, хүн амын соёл, боловсрол, эрүүл мэндийн болон бусад төрлийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэхэд анхаарна;

2.3.3.3.6 Хөрөнгө оруулалтын боломжит эх үүсвэрийг бүх сумдын хөгжлийн стратеги төлөвлөгөөнд тусгагдсан хөтөлбөр, төслүүдийг хэрэгжүүлэхэд чиглүүлнэ.

**2.2.3.4 Тэргүүлэх зорилт: “Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны зорилтот хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлнэ.**

**Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

2.2.3.4.1 Хүн амд нийгмийн үйлчилгээг хүргэхэд төр-хувийн хэвшлийн идэвхитэй оролцоо, хамтын ажиллагааг дэмжин, нийгмийн суурь үйлчилгээний салбарт хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлж, чанар хүртээмжийг сайжруулна;

2.2.3.4.2 Хот байгуулалт, төлөвлөлтийг зохион байгуулахдаа инженерийн барилга, байгууламж, нийтийн тээвэр, агаарын тээвэр, нийтийн аж ахуй, орон сууц, гэр хороолол, нийгмийн дэд бүтэц, газар ашиглалт зэргийг харгалзан олон улсын жишигт нийцүүлэн төлөвлөдөг болно;

2.2.3.4.3 “Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны зорилтот хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ;

**Гуравдугаар үе шат (2017-2021 он):**

**2.2.3.5 Тэргүүлэх зорилт: Төсвийн хөрөнгө оруулалтыг урт, дунд хугацааны хөгжлийн хөтөлбөр, төслүүдэд суурилуулан хэрэгжүүлэх бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.**

**Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

2.2.3.5.1 Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хуваарилалтыг иргэд олон түмэнд нээлттэй ил тод болгож, тэдний санал хүсэлтийг тусгадаг болох нөхцөлийг бүрдүүлнэ;

2.2.3.5.2 Төвөөс алслагдсан, хөгжлөөрөө сул сумын дэд бүтэцэд хөрөнгө оруулалт хийх замаар нийгэм, эдийн засгийг нь түлхүү хөгжүүлнэ;

**Гарах үр дүн:** “Сайншанд” аж үйлдвэрийн цогцолбор төв байгуулагдан, хөгжлийн үр шимийг сум бүр хүртэх нөхцөлийг бүрдүүлсэн байна. Шинэ техник, технологи бүхий үйлдвэрүүд шинээр байгуулагдан, ажлын байрны тоо хэмжээ нэмэгдэж, ажилгүйдэл, ядуурлын түвшин буурч, аймгийн хүн амын дийлэнх хувь нь чинээлэг амьдрах нөхцөл бүрдсэн байна.

## 2.3 Өрсөлдөх чадварыг сайжруулах бодлого

**Өнөөгийн байдал:** Улс орнуудын бүтээмжийн түвшин дээшилснээр хөгжих боломж нэмэгддэг. Иймээс хөгжиж буй орнуудын эдийн засгийн хөгжлийн гол асуудал нь газарзүйн байрлалд тулгуурлан өрсөлдөх чадварын үндсэн дээр бүтээмжийг аль болох хурдан хугацаанд өсгөж, улмаар урт хугацааны явцад тогтвортой байж чадах нөхцлийг бүрдүүлэх явдал юм.

Өрсөлдөх чадвараараа дээгүүр зэрэглэлд ангилагддаг улс орнуудын хувьд:

- Төрийн байгууллагуудын бүтэц, бодлого болон макро эдийн засгийн удирдлагын сайн тогтолцоо бүрдсэн;

- Боловсролын түвшингээрээ дэлхийд өрсөлдөхүйц хэмжээнд хүрсэн;

- Хөгжлийн бодлого нь технологийн шинэчлэл, инновацид чиглэсэн байдаг ба технологийн шинэчлэл, инноваци нь даяарчлагдаж буй дэлхийд өрсөлдөх чадварыг дээшлүүлэх гол хүчин зүйл болдгийг харуулж байна.

Дэлхийн эдийн засаг хурдацтай өөрчлөгдөж байгаатай уялдан бүтээмж, улмаар өсөлтийн түвшинг тодорхойлдог гол хүчин зүйлс ч мөн өөрчлөгдөж байна. Бүтээмжийг өсгөхийн тулд байгаа хүчин зүйлс, нөөцийн ашиглалтаа сайжруулах хэрэгтэй нь эргээд хөрөнгө оруулалтын эргэлт сайжрах, эдийн засгийн өсөлтийг хурдасгах боломжийг бий болгодог. Иймээс дунд болон урт хугацаанд эдийн засгийн өсөлт хадгалагдах орчин бүрдсэн улс орнуудын өрсөлдөх чадвар сайн байдаг.

Улс орнуудын өрсөлдөх чадвар нь олон тооны, мөн олон төрлийн хүчин зүйлсээр тодорхойлогддог. Макро эдийн засгийн таатай орчинг бий болгох нь өсөлтийг хурдасгахад чухал үүрэгтэй боловч энэ нь дангаараа өсөлтийг урт хугацааны туршид нэмэгдүүлэх хангалттай нөхцлийг бүрдүүлж чаддаггүй. Институцийн тогтолцоо, боловсролын түвшин, хууль эрх зүйн таатай орчин гэх мэт бусад олон хүчин зүйлс өсөлтөнд нөлөөлдөг. Гэвч эдгээр хүчин зүйлс нь тухайн улсын хөгжлийн түвшингээс хамаарч, улс орон бүрт өөр өөр үүрэгтэй байдаг. Мөн дэлхийн эдийн засгийн өөрчлөлттэй уялдан өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг хүчин зүйлс нь мөн өөрчлөгдөж байна. Жишээлбэл, 1990-ээд онд зөвхөн нөөцийг бий болгосноор эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэхэд хангалттай гэж үздэг байсан бол өнөө үе хамгийн сүүлийн үеийн технологийг ашиглан бизнесийн үйл ажиллагаа, удирдлагыг сайжруулах замаар өсөлтийг нэмэгдүүлэхэд их анхаарч байна.

### **Бүх үе шат (2011-2021 он):**

**2.3.1 Стратегийн зорилт: Иргэдийн мэдлэг боловсролыг дээшлүүлж, мэдлэгт түлхүү хөрөнгө оруулах замаар өрсөлдөх чадварыг нь дээшлүүлнэ:**

### **Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

2.3.1.1 Мэдлэгт хөрөнгө оруулалт хийх тэр дундаа бага дунд боловсролыг хөгжүүлж, өрсөлдөх чадвартай иргэдийг бэлтгэнэ.

2.3.1.2 Ажилтнуудын техникийн болон удирдахуйн ур чадварыг тогтмол дээшлүүлэх, инженерийн болон мэргэжлийн боловсрол сургалтыг сайжруулахуйц сургалтын тогтолцоог бий болгоно.

2.3.1.3 Нарийн мэргэжлийн ажилтан, ажилчдыг сургаж бэлтгэх, мэргэшүүлэх зорилт дэвшүүлж, хэрэгжүүлэх, Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүдийг хөгжүүлнэ.

2.3.1.4 Иргэдийн эдийн засаг, бизнесийн мэдлэгийг дээшлүүлж, хэрэглээний зөв дадал соёлд сургана.

2.3.1.5 Зөв зохистой хооллох болон эрүүл мэндээ хамгаалах, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх мэдлэг чадварыг эзэмшүүлнэ.

**2.3.2 Стратегийн зорилт: Үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын өсөлтийг дэмжиж, өндөр технологийг нэвтрүүлэх боломжийг бүрдүүлэн, өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ:**

#### **Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

2.3.2.1 Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах орчинг бүрдүүлнэ.

2.3.2.2 Дотоодын буюу орон нутгийн зах зээлийн чадавхийг сайжруулж, олон тулгуурт эдийн засгийн бүтцийг дэмжиж ажиллана.

2.3.2.3 Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлж, орон нутгийн өвөрмөц онцлогт тулгуурласан экспортод чиглэсэн үйлдвэрлэлийг дэмжинэ.

2.3.2.4 Эдийн засгийн чөлөөт бүс болон эрх зүйн бусад тусгай зохицуулалттай аж үйлдвэрийн бүсүүдийг байгуулан ажиллуулж, байгаль орчинд ээлтэй өндөр технологи нутагшуулахыг дэмжинэ.

2.3.2.5 Үйлдвэрлэл үйлчилгээний салбарын байгууллагуудын бизнесийн мэдлэгийг дээшлүүлж, бизнесийн боловсронгуй байдлыг хангаж ажиллана.

2.3.2.6 Байгаль орчинд ээлтэй аялал жуулчлалын онцгой бүсийг сонгож хөгжүүлнэ.

**2.3.3 Стратегийн зорилт: Бизнесийн орчинг сайжруулж, өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ:**

#### **Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

2.3.3.1 Институцийн тогтолцоог сайжруулж, хууль эрх зүй, стратегийн баримт бичгийн тогтвортой ил тод байдлыг хангаж ажиллана.

2.3.3.2 Төрийн үйлчилгээг шуурхай болгох зорилгоор шинэ дэвшилтэд хэлбэрийг тууштай нэвтрүүлнэ;

2.3.3.3 Эдийн засгийн тогтвортой байдлыг хангах нөхцөл боломжийг бүрдүүлж ажиллана.

2.3.3.4 Эрдэмтэн судлаачдыг бэлтгэх замаар судалгаа шинжилгээний төвүүдийг өргөтгөн, чадавхийг сайжруулж, инновацийн чадварыг дээшлүүлнэ.

2.3.3.5 Барааны, санхүүгийн, хөдөлмөрийн зах зээлийн үр ашигтай байдлыг хангаж ажиллана.

2.3.3.6 Эдийн засаг үйлдвэрлэлийн бүх салбарт шинэ технологи нэвтрүүлэх боломжийг бүрдүүлж ажиллана.

2.3.3.7 Бүс нутгийн хэмжээнд өрсөлдөх чадвартай, орчин үеийн зам тээвэр, мэдээлэл, холбоо, эрчим хүчний дэд бүтцийг бий болгоход анхаарна.



2.3.3.8 Баригдсан дэд бүтцийг өргөтгөх, хамгаалах арчлах асуудлыг бодлогын баримт бичигт тусгаж шийдвэрлэнэ.

2.3.3.9 Ирээдүйн өөрчлөлтөнд бэлтгэлтэй байх, сэргээгдэх эх үүсвэрийг ашиглах боломжийг бүрдүүлнэ.

2.3.3.10 Нийгмийн дундаж давхарга нэмэгдэх орчин нөхцөлийг бүрдүүлнэ.

## 2.4 Аж үйлдвэр, боловсруулах аж үйлдвэрийн хөгжил

**Өнөөгийн байдал:** Аж үйлдвэрийн салбарын эдийн засгийн үзүүлэлтүүдэд аж ахуйн нэгж байгууллагын зардал, бүтээгдэхүүний үйлдвэрлэлт биет хэмжээ, үнийн дүнгээр, бүтээгдэхүүний борлуулалт, үндсэн хөрөнгө болон санхүүгийн байдлыг харуулсан үзүүлэлтүүдийг оруулдаг.

Аж үйлдвэрийн салбарт оны үнээр 1,7 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 2,3 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүнийг зах зээлд борлууллаа.

Нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлт өнгөрсөн оны мөн үеэс 10,5 хувиар, бүтээгдэхүүн борлуулалтын орлого 31,2 хувиар тус тус буурсан байна.

Өмнөх оноос бүтээгдэхүүний үйлдвэрлэлт буурсан нь оны эхнээс гэрийн мод, жижиг төмөр эдлэл үйлдвэрлэгдээгүйтэй холбоотой байна. 2008 оноос Дорнын говь ХХК Дорноговь дахь салбартаа мах бэлтгэл хийхээ больсон нь аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт, борлуулалт өмнөх онуудаас буурах гол шалтгаан болжээ.

Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2005 оны зэрэгцүүлэх үнээр 1,5 тэрбум төгрөгт хүрч, өнгөрсөн оны мөн үеийнхээс 13,4 хувиар буурсан байна.

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 79,0 хувийг төрийн өмчийн ААНБ, 21,0 хувийг хувийн өмчийн ААНБ үйлдвэрлэсэн байна.

Аж ахуйн нэгжийн хариуцлагын хэлбэрээр авч үзвэл улсын үйлдвэрийн газар 79,0 хувь, компани 11,0 хувь, хоршоо 0,02 хувь, өрхийн аж ахуй 10,0 хувийг тус тус үйлдвэрлэжээ.

Дорноговь аймаг ашигт малтмалаар баялаг бөгөөд одоогийн байдлаар хайлуур жонш, цеолит, гөлтгөнө, чулуу ун нүүрс, газрын тос, алт, зэс, никель, төмөр, марганец, хром, гянт болд, цагаан тугалганы зэрэг 38 төрлийн ашигт малтмалын 73 орд, 440 гаруй илэрцүүд тогтоогдоод байна.

Тус аймагт Монгол орны хэмжээнд тогтоогдсон нийт хайлуур жоншны нөөцийн 29.7 хувь нь байдаг.

Мөн аймгийн нутаг дэвсгэрт орон нутгийн төдийгүй, улс орны эдийн засгийн онцгой ач холбогдол бүхий Зүүнбаян, Цагаан элсний газрын тосны орд газар байрладаг.

Цагаансуваргын зэс-молибден, Хонгор /Дарцагт/, Чандмань уулын төмрийн хүдэр, холимог металл, Лугийн голын газрын ховор элемент, Сулинхээрийн хромит, Айраг, Иххэт, Өргөн, Даланжаргалан сумдын нутаг дахь хайлуур жонш, Цагаанцавын цеолит, Алагтогоо, Элдэв, Хашаатхудаг, Олонгийн ухаа, Түшлэг /Хаалгын уул/, Хамрын хурлын нүүрс, Баян-Уул, Цагаан дэлийн болор-цахир, Үнэгт, Хоньчийн гөлтгөнө, Билүүт, Хөхцав, Сөгдөхийн шохойн чулуу, Дарцагт /Итгэл найдвар/-ын бал чулуу зэрэг томоохон ордуудад геологи хайгуулын ажил хийгдэж, нөөцийг тодорхойлсон. Сүүлийн жилүүдэд Хатанбулаг сумын Зосхайрхан, Цахиуртай, Эрдэнэ сумын Далайн элс, Улаанбадрах сумын Дулаан уул, Алтанширээ сумын Эрдэнэцогтын говь, Сайхандулаан сумын Оюут-Улаан, Хүрийн

ус зэрэг алт, уран, нүүрсний илрэл, эрдэсжсэн цэг бүхий газарт эрэл хайгуулын ажил үргэлжлэн хийгдэж байна.

Манай аймагт 1930-аад оны сүүлчээс 1960-аад оны сүүлч хүртэл Түшлэг /Хаалгын/ уулын нүүрсний уурхай, Зүүнбаянгийн нефтийн үйлдвэр зэрэг уул уурхайн анхны үйлдвэрүүд байгуулагдан ажиллаж байсан. Түшлэгийн уурхай 1937 оноос хойш далд уурхайн аргаар 11250 тонн орчим нүүрс олборлосон байна. Харин Зүүнбаянгийн үйлдвэр 1950-1969 онд нийт 555000 тонн /3459500 баррель/ газрын түүхий тос олборлон боловсруулжээ. Эрдэс баялгийн нөөцөд тулгаруулан сүүлийн 30 гаруй жилд Айраг, Өргөн, Хажуу-Улааны уулын /хайлуур жонш олборлох/ үйлдвэрүүд, Үнэгтийн гөлтгөнийн уурхай, Олон-Овоогийн чулуун завод, 1990-ээд оноос Элдэв, Хашаатхүдгийн нүүрсний уурхай, Сөгдөхийн шохойн чулууны карьер зэрэг уул уурхай, барилгын материалын үйлдвэр ажиллаж, эх орны экспортыг нэмэгдүүлэх, түлш эрчим хүчний баазыг өргөтгөх, улс, орон нутгийн төсвийн орлогыг бүрдүүлэхэд ихээхэн хувь нэмэр үзүүлж байна.

**Давуу тал:** Европ Азийг холбосон төмөр зам дайран өнгөрдөг, аймгийн ихэнх томоохон орд газрууд төмөр замд ойр оршдог. Энэ төмөр замаар олон улсын зах зээлд уул уурхайн бүтээгдэхүүнээ экспортлоход зардал багатай.

**Сул тал:** Байгаль орчин сөрөг нөлөөтэй, экологийн тэнцвэрт байдал алдагдах, усны нөөц хомсдох, ард иргэдийн оршин байх орчин багасч, малын бэлчээр устгах аюултай.

### **Бүх үе шат (2011-2021 он):**

**2.4.1 Тэргүүлэх зорилт: Гадаад зах зээлд өрсөлдөх чадвартай эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх замаар боловсруулах аж үйлдвэрийн салбарыг өсгөх.**

#### **Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

2.4.1.1. Боловсруулах үйлдвэр байгуулах газруудыг тодорхой болгон сумдын ерөнхий төлөвлөгөөнд суулгаж өгөх;

2.4.1.2 Сайншанд болон бусад нөөц бүхий сумдад барилгын материалын болон малын гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэр байгуулах /Барилгын материалын түүхий эдийг боловсруулах үйлдвэр, хавтгай шил, эрдэс будаг зэрэг болон Арьс шир боловсруулах үйлдвэр байгуулах/;

2.4.1.3 Сумдын нөөц боломж, хэрэгцээнд тулгуурлан талх нарийн боов, гутал, эсгий, махан бүрээгдэхүүн, сүү цагаан идээний болон төрөл бүрийн оёдлын үйлдвэрлэл, нэхмэл, сүлжмэл бүтээгдэхүүн, ноос, ноолуур боловсруулах үйлдвэрлэлийг бий болгох;

2.4.1.4 Сумдад малын гаралтай түүхий эд боловсруулах, бүтээгдэхүүний бирж /төвлөрсөн зах/ байгуулах;

2.4.1.5 Сумдад худалдаа, үйлчилгээний бөөний сүлжээний цэг салбарыг нээж ажиллуулах, биржийн бараа таталтын тогтолцоог бий болгох;

2.4.1.6 Ноос, ноолуур угаах, мах боловсруулах, чулуу боловсруулах, цаасан уут болон хулдаасан эдлэлийн үйлдвэрүүд, жоншны нөөцийг түшиглэн баяжуулах үйлдвэрүүд байгуулахыг дэмжих;

2.4.1.7 Экспортод баримжаалсан боловсруулах үйлдвэрлэлийг эрчимтэй хөгжүүлэх;

2.4.1.8 “Сайншанд” аж үйлдвэрийн цогцолборыг барьж эхлэхтэй холбогдуулан Зуурмагийн узель бүхий бетон, төмөр бетон эдлэлийн үйлдвэр, бутлан ангилах үйлдвэр, эрдэс хөвөнгийн үйлдвэрийг шинээр байгуулж эхлэх;

**2.4.2 Тэргүүлэх зорилт: Томоохон орд газруудын ашиглалтыг эрчимжүүлж, олон улсын стандартад нийцсэн техник, технологийг нэвтрүүлж, эцсийн бүтээгдэхүүн үйлвэрлэлтийг нэмэгдүүлнэ.**

**Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

2.4.2.1 “Цагаан суварга”-ын зэсийн орд, “Элдэв”-ийн нүүрсний уурхай, Зүүнбаянгийн нефтийн ордыг 2012 онд ашиглаж эхлэх нөхцөлийг бүрдүүлнэ;

2.4.2.2 Хайгуулын лиценз бүхий талбайн хайгуулын ажлыг эрчимжүүлэх талаар лиценз эзэмшигчидтэй тогтмол уулзалт зохион байгуулна;

2.4.2.3 Эрдэс баялаг, түүхий эдийн нөөцийг иж бүрэн ашиглах, хаягдалгүй, байгаль орчинд халгүй технологийг нэвтрүүлнэ;

2.4.2.4 Нефть боловсруулах болон зэсийн баяжмалын үйлдвэр, төмөр хайлуулах үйлдвэрүүдийг байгуулах бэлтгэлийг хангана;

2.4.2.5 Уул уурхай, аж үйлдвэрийн цогцолборыг дагасан жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлнэ;

**2.4.3 Тэргүүлэх чиглэл: Уул уурхайн салбарт байгаль орчныг хамгаалж, экологийн тэнцвэрт байдлыг хадгална.**

**Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

2.4.3.1 Хаягдсан талбайн нөхөн сэргээлтийн зардлыг нэхэмжилдэг болох нөхцөлийг бүрдүүлнэ.

2.4.3.2 Уул уурхайн компаниудын хайгуул буюу олборлолтын үйл ажиллагааны явцад эвдэрсэн газрыг нөхөн сэргээж, орон нутгийн удирдлагад нь хүлээлгэн өгсөн байдалд тавих хяналтыг сайжруулан, байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээний хэрэгжилтэнд жил бүр үнэлэлт дүгнэлт өгдөг болно.

**2.4.4 Тэргүүлэх зорилт: Оюуны шингэц бүхий өндөр технологт суурилсан үйлдвэрлэлийн эзлэх байр суурийг бэхжүүлнэ.**

**Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

2.4.4.1 Газрын тосны олборлолт, боловсруулалтыг нэмэгдүүлэн нефть болон нефтийн бүтээгдэхүүний дотоодын хэрэгцээний тодорхой хувийг хангадаг болно;

2.4.4.2 Дэвшилтэт технологи ашиглан түгээмэл тархсан барилгын материалын түүхий эдийг боловсруулж, хавтгай шил, эрдэс будаг зэрэг бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхийг дэмжинэ;

2.4.4.3 Эцсийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх үйлдвэр байгуулахыг дэмжинэ.

**Гарах үр дүн:** Аймгийн Дотоодын нийт бүтээгдэхүүнд аж үйлдвэр, боловсруулах үйлдвэр, үйлдвэр үйлчилгээний салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээ тэргүүлэх байр суурьтай болсон байна. Уул уурхайн нөхөн сэргээлт сайжирч, байгаль орчны тэнцвэрт байдал хадгалагдана. Ажлын байрны тоо хэмжээ нэмэгдэнэ.

**2.5 Хоршоо, жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээний хөгжил**

**Өнөөгийн байдал:** Аймгийн худалдаа үйлдвэр, худалдаа, үйлчилгээний салбар нь 2009 оны үнээр 1,7 тэр бум төгрөгний бүтээгдэхүүн үйлдвэрлэн 2,3 тэр бум төгрөгний бүтээгдэхүүнийг дотоод гадаадын зах зээлд борлууллаа. Нийт

бүтээгдэхүүн үйлдвэрлэлт өнгөрсөн оныхоос 10,5 хувиар, бүтээгдэхүүн борлуулалтын орлого 31,2 хувиар тус тус буурсан байна.

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 79,0 хувийг төрийн, 21,0 хувийг хувийн өмчийн үйлдвэрлэл эзэлж байгааг аж ахуйн нэгжийн хариуцлагын хэлбэрээр авч үзвэл улсын үйлдвэрийн газар 79,0%, компани 11,0%, хоршоо 0,02%, өрхийн аж ахуй 10,0%-ийг үйлдвэрлэжээ.

2010 оны байдлаар аймгийн хэмжээнд хөдөө аж ахуйн салбарт 10, хадгаламж зээлийн үйлчилгээ эрхэлж байгаа 4, худалдаа эд хэрэглээний 5, үйлдвэр, үйлчилгээний чиглэлээр 4, нийт 23 хоршоо үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд хүнсний үйлдвэрлэл цех эрхэлдэг аж ахуйн нэгж, иргэд 27 үүнээс гурилан бүтээгдэхүүний цех 22, мах, хиаман бүтээгдэхүүний цех 2, архины 2 үйлдвэр, цэвэр усны 1 үйлдвэр, зайрмагны 1 цех үйл ажиллагаа явуулж байна.

Нийт аж ахуйн нэгжийн 38,3 хувь нь худалдааны салбарт, 10,7 хувь нь нийгэм бие хүнд үзүүлэх үйлчилгээний салбарт, 7,5 хувь нь зочид буудал, зоогийн газрын үйл ажиллагааны салбар үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс худалдааны төв 25, хүнс, барааны дэлгүүр 360, хүнсний мухлаг 152 ажиллаж хүн амыг хэрэгцээт бараа бүтээгдэхүүнээр хангаж байна.

Үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын 75,9 хувийг 1-9 ажилчидтай, 13,4 хувийг 10-19 ажиллагчидтай, 2,6 хувийг 50-с дээш ажиллагчидтай аж ахуйн нэгж, байгууллага тус тус эзэлж байна.

Бөөний болон жижиглэн худалдааны үйл ажиллагаа эрхэлдэг 266 аж ахуйн нэгж байгууллагын 59,8% нь хэвийн үйл ажиллагаа явуулж байна. Худалдааны нийт орлого 21734,5 сая төгрөгт хүрсэн үзүүлэлттэй байна. Энэ нь өмнөх оноос 55.9%-иар өсчээ.

#### **Давуу тал:**

- Аялал жуулчлалын салбар хөгжиж гадаад, дотоодын жуулчдын тоо нэмэгдсэнээр худалдаа үйлчилгээний салбарын хэрэгцээ өсөх хандлагатай байна.
- Элсний нүүдэл ихтэй учир элсээр боловсруулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэл хөгжих боломжтой.

#### **Сул тал:**

- Борлуулалт хязгаарлагдмал, хүн амын нягтаршил, суурьшил цөөн.
- БНХАУ-лстай хил залгаа оршдог тул импортын бүтээгдэхүүн худалдан борлуулж байгаагаас дотоодын үйлдвэрийн хөгжил удаашралтай байна.
- Зээлийн хүү өндөр, хугацаа богино.
- Ажиллах боловсон хүчин хомс.

### **Бүх үе шат 2011-2021 он**

**2.5.1 Тэргүүлэх зорилт: Аж үйлдвэр, дэд бүтцийн хөгжлийн бодлоготой уялдаатайгаар хоршоо, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжих бодлогыг хэрэгжүүлнэ.**

#### **Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

2.5.1.1 Мал аж ахуйн түүхий эд, газар тариалангийн бүтээгдэхүүнийг бүрэн боловсруулах зориулалт бүхий хоршоо, үйлдвэрүүдийг байгуулахыг дэмжинэ;

2.5.1.2 Мянганы зам дагуух /Улаанбаатар-Сайншанд-Замын-Үүд/ үйлдвэрлэл, үйлчилгээ хөгжих боломж бүрдүүлэх, гадаад дотоод худалдааг дэмжинэ;

2.5.1.3 Замын-Үүд, Ханги-Мандал боомтын нэвтрүүлэн өнгөрүүлэх үйлчилгээний чанар, нөхцөлийг сайжруулах, бараа эргэлт, жуулчлалын нэвтрүүлэх боломжийг нэмэгдүүлэх;

2.5.1.4 Үйлдвэрлэл, үйлчилгээнд мэдлэг, орчин үеийн менежмент, мэдээллийн технологийг тууштай нэвтрүүлнэ;

**2.5.2 Тэргүүлэх зорилт: Бизнесийн орчныг сайжруулан, төр хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлнэ.**

**Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

2.5.2.1 Нутгийн өөрөө удирдах ёсны ба захиргааны байгууллагууд болон хувийн хэвшлийн хамтын ажиллагааг түншлэлийн хүрээнд өргөжүүлэн, үр өгөөжийг бодитой болгоно;

2.5.2.2 Хөрөнгө оруулалт, технологи, шинэчлэлийн асуудлыг шийдвэрлэх боломжийг хувийн хэвшилд олгоно;

2.5.2.3 Уул уурхай дагасан бизнесийг орон нутагт хөгжүүлэхэд хувийн хэвшлийг зохистой бодлогоор дэмжинэ;

2.5.2.4 Аймгийн давуу тал, нөөцөд тулгуурлан үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний салбарыг хөгжүүлж, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа бизнес эрхлэгчдийг дэмжинэ;

2.5.2.5 Бизнес эрхлэгчдийг үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг орон нутагт татан төвлөрүүлэх арга хэмжээ авна;

2.5.2.6 Бизнес эрхлэгчдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг дотоод, гадаадын зах зээлд сурталчлах, үзэсгэлэн худалдаанд оролцуулахыг дэмжинэ;

2.5.2.7 Бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжих, төр хувийн хэвшлийн харилцаа холбоог ил тод, нээлттэй болгоно;

2.5.2.8 Гадаадын хөрөнгө оруулалттай үйлдвэр, худалдаа, үйлчилгээний жишиг төвийг шинээр байгуулна;

2.5.2.9 Хөрш орнуудын болон өндөр хөгжилтэй орнуудын бизнес эрхлэгчидтэй туршлага солилцон, нөхөрлөл холбоо байгуулахад туслалцаа үзүүлнэ;

**2.5.3 Тэргүүлэх зорилт: Аймгийн хэмжээнд хүн амын хүнсний хангамжийг сайжруулж, хүнсний хэрэглээний төрөл зүйлийг олшруулна.**

**Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

2.5.3.1 Хүн амын төмс, хүнсний ногооны хангамжийг 2010 оны түвшингээс 2013 онд 30 %, 2016 онд 40 %, 2021 онд 80 хувь, сүү, сүүн бүтээгдэхүүний хангамжийг 2010 оны түвшингээс 2013 онд 20 %-аар, 2016 онд 35 хувь, 2021 онд 50 хувиар өсгөнө;

2.5.3.2 Хүнсний бүтээгдэхүүний зохистой хэрэглээг бий болгоход хувийн хэвшлийн оролцоог дэмжсэн эдийн засгийн хөшүүргийг боловсруулж хэрэгжүүлнэ;

2.5.3.3 Хүнсний хэрэглээний олон хэлбэрийг нэмэгдүүлэх замаар зах зээлийг өргөжүүлж, хувийн хэвшлийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ;

2.5.3.4 Хүнсний ногоо болон бусад хэрэглээний бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхэд чиглэсэн эрчимжсэн аж ахуйг дэмжинэ;

**2.5.4 Тэргүүлэх зорилт: Хүнсний бүтээгдэхүүний чанарыг сайжруулж, эрүүл ахуй, ариун цэврийн хяналтыг боловсронгуй болгоно.**

**Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

2.5.4.1 Хүнсний бүтээгдэхүүний сав, баглаа боодлын стандарт, техникийн нөхцөлийг сайжруулахад анхаарна;

2.5.4.2 Хүнсний үйлдвэрлэл хөгжүүлэх суурь нөхцөлийг бүрдүүлэхийн тулд олон улсын стандартад нийцсэн хяналтын лаборатори байгуулна;

2.5.4.3 Хор судлалын шинжилгээг бүрэн хийхэд шаардлагатай иж бүрэн тоног төхөөрөмжийн лабораторын хүчин чадлыг нэмэгдүүлнэ;

2.5.4.4 Хүнсний бүтээгдэхүүний эрүүл ахуй, ариун цэврийн стандартыг салбарын аж ахуйн нэгжүүдэд нэвтрүүлж, энэ дагуу төрөлжсөн сургалт зохион байгуулна;

2.5.4.5 Чанарын шаардлага хангахгүй бүтээгдэхүүн худалдаалах, эрүүл ахуйн шаардлага хангахгүй үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид тавих хяналтыг сайжруулна;

2.5.4.6 Замын-Үүд, Ханги мандал боомтод хүнсний ногоо болон өргөн хэрэглээний бүтээгдэхүүнд шавьж усгах бордоо, хүний биед хортой химийн бодис болон нян судлах тасаг байгуулахыг дэмжинэ;

**2.5.5 Тэргүүлэх зорилт: Хоршоо, жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийг дэмжих орчин нөхцөлийг бүрдүүлж, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд үзүүлдэг төрийн үйлчилгээг чирэгдэлгүй, түргэн шуурхай болгоно.**

**Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

2.5.5.1 Хоршоо, жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх хүсэлтэй иргэд, аж ахуйн нэгжид нутгийн захиргааны байгууллагаас олгодог зөвшөөрөл, тусгай зөвшөөрөл олгох ажлыг түргэн шуурхай болгож, нэг цэгийн үйлчилгээний нэгжийн хүчин чадлыг нэмэгдүүлнэ;

2.5.5.2 Бизнес мэдээллээр хангах, техник технологийн сонголт хийхэд дэмжлэг үзүүлэх, зөвлөгөө өгөх, үйлчилгээ үзүүлэх үүрэг бүхий хувийн хэвшлийн болон олон улсын байгууллагуудын салбар, хэлтэс, зөвлөх үйлчилгээний компаниудыг үйл ажиллагаагаа явуулахыг бодлогоор дэмжинэ;

2.5.5.3 Хоршоо, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх хүсэлтэй иргэдийг шаардлагатай мэдээ, мэдээллээр хангах, тэдэнд төсөл боловсруулахад арга зүйн туслалцаа үзүүлэх, техник, технологийн сонголт хийхэд нь туслах, зөвлөгөө өгөх бизнес инкубатор төвийг байгуулан ажиллуулна;

2.5.5.4 Бүсийн хөгжлийн давуу тал нөөц боломжийг бүрэн ашиглаж, жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээг бүх талаар дэмжин ажлыг байрыг бий болгоно;

2.5.5.5 Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор өрхийн гар урлалыг дэмжих хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ;

2.5.5.6 Газар тариалан, мал аж ахуйн хосолсон фермерийн томоохон аж ахуй байгуулах төслийг дэмжиж ажиллана;

**2.5.6 Тэргүүлэх зорилт: Аймгийн хүнсний хангамжийг экологийн цэвэр бүтээгдэхүүнээр хангаж, хэрэглээний зохистой бүтцийг бий болгох.**

### **Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

- 2.5.6.1 Байгаль орчинд халгүй технологи нэвтрүүлэхэд хувийн хэвшилд дэмжлэг үзүүлнэ;
- 2.5.6.2 Үйлдвэрлэлийн болон хэрэглээний явцад гарах хог хаягдлыг төрөлжүүлэн ангилж, дахин ашиглах менежментийг нэвтрүүлнэ;
- 2.5.6.3 Хүн амын эрэлт хэрэгцээнд тулгуурлан өндөр технологи бүхий хүнсний жижиг, дунд үйлдвэрлэлийг эрчимтэй хөгжүүлэн, экологийн цэвэр хүнсний бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээг хангах нөхцөлийг бүрдүүлнэ.
- 2.5.6.4 Хүнсний бүтээгдэхүүний чанар, эрүүл ахуйн аюулгүй байдалд тавих хяналтын тогтолцоог боловсронгуй болгож, лабораторийн шинжилгээг хөгжсөн орнуудын жишигт хүргэнэ

**Гарах үр дүн:** Экологийн цэвэр бүтээгдэхүүнийг бүсийн хэмжээнд гаргаж, экспортод нэвтрүүлэх боломжийг бий болгон, лабораторийн тоног төхөөрөмж шинэчилэгдэж, орчин үеийн техник, технологи нэвтэрсэн байна.

**2.5.7 Тэргүүлэх зорилт: Мах, сүү, төмс, хүнсний ногооны боловсруулах үйлдвэрүүдийн техник технологи, тоног төхөөрөмжийг шинэчлэн, сум дундын мах, сүүний үйлдвэр, хоршооллыг бий болгох, хяналтын тогтолцоог сайжруулна.**

### **Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

- 2.5.7.1 Аймаг, сумын хэрэгцээнд тохирсон бага, дунд хүчин чадал бүхий мах, сүү, хүнсний ногоо боловсруулах жижиг дунд үйлдвэр, цех байгуулах, хагас боловсруулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэж зах зээлд гаргана;
- 2.5.7.2 Шар буурцаг, шар манжин зэрэг мах орлуулах бусад бүтээгдэхүүнийг орон нутагтаа тариалдаг, үйлдвэрлэдэг болно;
- 2.5.7.3 Хүн амыг төвлөрсөн хүнсний хангамжаар хангах хүрээнд хүнсний салбар сүлжээ супер маркет, түргэн хоолны газруудыг байгуулах санал санаачлагыг дэмжинэ;
- 2.5.7.4 Аймгийн хэмжээнд үйлдвэрлэж худалдаалж байгаа хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлын талаар орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлан таниулах ажлыг тогтмолжуулна;
- 2.5.7.5 Хүнсний түүхий эдээс бэлэн бүтээгдэхүүн хүртлэх технологийн бүх шат дамжлагад хүнсний нэмэлт, туслах түүхий эдийн бүртгэл мэдээлэл хяналтын тогтолцоог бий болгоно;
- 2.5.7.6 Баяжуулсан хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хэрэглээ, үр дүнг мэдээлэх, хянах үйл ажиллагааг сайжруулна;
- 2.5.7.7 Малын гаралтай бүтээгдэхүүнийг хүлээн авах, бэлтгэн нийлүүлэх хоршоо, зах, биржийн сүлжээг бий болгох, улмаар гадаадад мах экспортлоно.

**Гарах үр дүн:** Хоршоо, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд үзүүлэх үйлчилгээ шуурхай, чирэгдэлгүй болж, бизнес эрхлэх таатай орчин бүрдсэн байна. Үйлдвэрийн аргаар боловсруулсан сүү, мах, жимс, хүнсний ногооны бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээ нэмэгдэж хүн амын хүнсний хэрэгцээг хангадаг болно.

Төр-хувийн хэвшлийн хоорондын харилцаа ил тод нээлттэй болсноор, бизнес эрхлэх таатай орчин бүрдэж, өрсөлдөх чадвар нэмэгдэн, орон нутгийн гаралтай бүтээгдэхүүний хэмжээ нэмэгдэнэ. Хүнсний үйлдвэрлэлийн чадавхи сайжирч, бүтээгдэхүүний нэр, төрөл, сав баглаа боодлын чанар дээшилж, баталгаатай аюулгүй хүнсээр иргэдийн хэрэгцээг хангах нөхцөл бүрдэнэ.

## 2.6 Хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрлэлийн хөгжил

**Үндэслэл буюу өнөөгийн байдал:** 2010 оны жилийн эцсийн мал тооллогын дүнгээр 1056.8 мянган толгой мал тоологдсоны дотор 28.1 мянган тэмээ, 77.4 мянган адуу, 40.4 мянган үхэр, 421.3 мянган хонь, 489.6 мянган ямаа тоологдсон.

2010 оны мал тооллогоор цэвэр үүлдрийн 12.1 мянга, сайжруулсан нутгийн үүлдрийн 239.4 мянга, нутгийн шилдэг омгийн 112.4 мянган мал тоологдов.

Өнгөрсөн онтой харьцуулахад цэвэр үүлдрийн мал 0.2 хувиар, нутгийн шилдэг омгийн мал 5.5 хувиар, сайжруулсан нутгийн үүлдрийн мал 1.3 хувиар өсчээ. Юуны түрүүнд малын чанар чансаа, ашиг шимийн асуудал чухлаар тавигдаж байна. Монгол мал нь тэсвэр тэвчээр сайтай боловч ашиг шимийн хувьд тааруухан, шилмэл омгийн сайн үүлдрийн мал нь ашиг шим өндөр боловч байгаль цаг уурын хүнд нөхцөлд тэсвэр муутай өвс ургамлын хувьд нарийн тэжээл хэрэглэдэг зэрэг сөрөг талтай байгаа юм. Үүнээс үүдээд эдгээрийг хооронд үржил селекц хийх замаар байгаль цаг уурын хүнд нөхцөлд тэсвэртэй, мөн ашиг шим өндөртэй шинэ үүлдэр бий болгох арга замыг судалж байна. Мөн зохиомол хээлтүүлгийн аргыг их хэрэглэж байна. Эдгээр нь чамгүй урт хугацаанд үр дүн нь харагдах тул чанартай зохион байгуулахад анхаарч ажиллах шаардлагатай байна.

Үүнээс гадна туслах аж ахуйн чиглэлээр гахай, тахиан аж ахуй байгуулах, гахай, тахиан мах, өндөг, сүүний хэрэгцээг дотоодын томоохон үйлдвэр аж ахуйн нэгж, иргэдийг хангах цаашлаад бусад орон нутагт нийлүүлэхээр урт хугацааны зорилтыг томъёолоод байна. Сүүний хангамжийг бүрэн хангах асуудал чухлаар тавигдаж байна.

Хөдөө аж ахуйн нэг том салбар бол газар тариалан юм. 2010 онд аймгийн хэмжээнд газар тариалангийн талаар тодорхой арга хэмжээ зохион байгуулж иргэдэд үрийн төмс, зээлээр тараан өгөх, ногоо тарихад нь дэмжлэг тусламж үзүүлсэнээр нийт 41.9 га талбайд төмс, 48.6 га-д хүнсний ногоо, 161.6 тн төмс, 170.1 тн хүнсний ногоо хураан авлаа. 1 га-аас 3.8-5.5 тн төмс, хүнсний ногоо хураан авсан нь 2009 оныхоос төмс 1.7 тн, хүнсний ногоо 1.8 тн-оор нэмэгдсэн.

Мал аж ахуй, газар тариалангийн эрсдлийг бууруулах, малчдын хоршин ажиллах хэлбэрийг дэмжих, бэлчээрийн болон усан хангамжийн менежмент, тэжээл бэлтгэл, мал эмнэлгийн үйлчилгээ зэрэгт төрөөс үзүүлэх тусламж дэмжлэгийг идэвхжүүлж, менежментийн тогтолцоог боловсронгуй болгон усан хангамжийн асуудлыг цогцоор шийдэх нь хойшлуулашгүй зорилт болоод байна.

Мал аж ахуй, газар тариалангийн салбарт хөрөнгө хүч, мөнгөнийн хуримтлал бий болгон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн тогтвортой өсөлтийг хангаж, улмаар бүтээгдэхүүний чанар, өрсөлдөх чадварыг сайжруулах шаардлагатай байна.

### **Давуу тал:**

#### Мал аж ахуй

- Говийн аймгийн нөхцөлд ган зудад тэсвэртэй, говьд зохицсон тэмээн сүргийг өсгөх хөгжүүлэхэд тохиромжтой,
- Төмөр зам болон авто замын дэд бүтцийн давуу талд түшиглэн суурин болон хагас суурин эрчимжсэн аж ахуй хөгжүүлэхэд бусад аймгуудаас давуу талтай

#### Хүнсний салбарын давуу тал:

- Дэд бүтэц хөгжсөн
- Аялал жуулчлалын салбар хөгжиж гадаад, дотоодын жуулчдын тоо нэмэгдсэнээр зах зээлийн эрэлт хэрэгцээ өсөх хандлагатай байна.



### Бэлчээрийн усан хангамжийн тавуу тал

- Газар доорхи усны иж бүрэн судалгаатай
  - Газар доорхи усны ай савны нөөц ихтэй
- ### Газар тариалан
- Дулааны нөөц их, эрт дулаарч орой хүйтэрдэг. Дулаанд тохиромжтой ургамал /тарвас, амтат гуа, хулуу, чинжүү, лооль, өргөст хэмх/ ургах боломжтой. Гэрэлтүүлгийн хугацаа урт учраас урт өдрийн ургамал /гуатан ургамалууд/ ургах, үр үржүүлэх боломжтой. Талбай хүрэлцээтэй. Хадгалалт сайн даадаг, чанар сайн байдаг.
  - Нарны эрчим хүчээр баялаг, уур амьсгал дундад Азитай ойролцоо, ургамал ургах хугацаа урт буюу 140 хоног, нарны гийх цаг нь урт
  - Халуун дулаан уур амьсгалтай тул ховор, үнэт тарималуудыг тариалах боломжтой.

### **Сул тал:**

#### Хөдөө аж ахуй

- Бэлчээрийн ургац тачир ургадаг тул хадлан бэлтгэх боломжгүй
- Байгалийн үзэгдэл элсэн цөл их болж байна
- Эдийн засгийн ач холбогдолтой, малчдын орлогын эх үүсвэр болдог / ноолуур / боловч ургамлын бүрхэвчид муугаар нөлөөлдөг, цөлжилтөд дэмжлэг үзүүлдэг ямаан сүргийн тоо толгойг тодорхой түвшинд барьж байх
- Сайншанд хүнд аж үйлдвэрийн цогцолбор байгуулагдах төсөл хэрэгжсэнээр, хүн амын механик өсөлт ихсэх, малын бэлчээр хомсдох, хүнсний хэрэглээ нэмэгдэх,

#### Хүнсний салбар

- Борлуулалт хязгаарлагдмал
- БНХАУ-лстай хил залгаа оршдог тул импортын бүтээгдэхүүн худалдан борлуулж байгаагаас дотоодын үйлдвэрийн хөгжил удаашралтай байна.
- Зээлийн хүү өндөр, хугацаа богино.

#### Бэлчээрийн усан хангамж

- Газар доорхи усыг ашиглахад газрын гүнээс гаргадаг тул хэт гүний өрөмдлөг хийхэд тоног төхөөрөмж муутай
- Газар доорхи усны хайгуулыг орчин үеийн тоног төхөөрөмжөөр хийлгэж ус гаргах магадлалыг өндөр түвшинд хүргэх.

#### Газар тариалан

- Хөрс хуурай, хур тундас ховор, тогтворгүй, ус нь давсжсан байдаг.
- Шингэц муутай аадар бороо ордог, ундарга муутай цөөхөн булагтай
- Хөрсний үржил шим бага, салхи шороон шуурга ихтэй, агаар харьцангуй хуурай, гадаргуугийн ус байхгүй, гүний ус түшиглэдэг учраас зардал өндөр гардаг. Уламжлалт арга технологи байхгүй, туршлагатай ажиллах хүч бага.

### **Нэгдүгээр үе шат (2011-2013 он)**

**2.6.1 Тэргүүлэх зорилт: Хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, хоршооллын ажил үйлчилгээний чанарыг дээшлүүлж, эрчимжсэн мал аж ахуй, газар тариаланг хөгжүүлэн, бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлнэ.**

**Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

2.6.1.1 Суурин буюу хагас суурин эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлж, өндөр ашиг шимтэй эрчимжсэн мал аж ахуй, газар тариаланг хөгжүүлнэ.

2.6.1.2 Малын үүлдэр угсааг сайжруулах, гойд ашиг шимт мал, торгон сүргийг хамгаална.

2.6.1.3 Гахай, шувууны аж ахуй хөгжүүлэх үүсгэл санаачилгыг дэмжинэ.

2.6.1.4 Гадаадын хөрөнгө оруулалттай газар тариалан, мал аж ахуйн загвар аж ахуйг шинээр байгуулах нөхцөлийг бүрдүүлнэ.

2.6.1.5 Хөрш аймгуудийн холбоо байгуулан малчдыг чөлөөтэй оторлох, нүүдэллэх ажлыг зохион байгуулна;

2.6.1.6 Төв суурин газрын мах, сүү, сүүн бүтээгдэхүүний хангамжийг нэмэгдүүлэхэд анхаарна;

2.6.1.7 Бэлчээрийн усан хангамжийг сайжруулж, худаг гаргах, уст цэг засварлах ажлыг иргэд, малчдын оролцоотойгоор зохион байгуулна.

2.6.1.8 Аймаг, сумын түвшинд бэлчээрийн менежментийн зураглал, төлөвлөгөө боловсруулж, бэлчээрийн менежментийн загвар сум бий болгоно.

2.6.1.9 Хүнс, хөдөө аж ахуйн салбарт хөдөлмөрөөрөө хорших, хөрөнгө хүчээ нэгтгэх, хоршоо, нөхөрлөл хэлбэрээр ажиллах санаачилгыг дэмжин, аймагт нэг, сум бүрт нэг “Загвар” хоршоо бий болгоно.

2.6.1.10 Мал аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрлэлийг сумдад бий болгоно.

2.6.1.11 Мал сүргийг даатгалд хамруулах замаар байгалийн гамшгаас үүдсэн эрсдлийн хохирлыг багасгана.

2.6.1.12 Хувийн мал эмнэлгүүдийн үйл ажиллагааг дэмжиж, мал сүргийг эрүүлжүүлэх, халдваргүйжүүлэх, эмчлэх арга хэмжээ авна;

2.6.1.13 “Атрын гуравдахь аян” хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлнэ.

2.6.1.14 “Хүнсний хангамж, аюулгүй байдал, хоол тэжээл” аймгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх цогц арга хэмжээ авна.

2.6.1.15 Мандах сумын Цагаан цавын тариалалтыг өргөтгөх, малын тэжээл тариалах боломжийг судалж шийдвэрлэхэд нь туслалцаа үзүүлнэ.

**Гарах үр дүн:** Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн өсч, малын үүлдэр угсаа сайжран, орон нутгийн үйлдвэрлэл дэмжсэн бүтээгдэхүүний хэрэглээ өсч, өрхийн орлого нэмэгдэнэ. Бэлчээрийн усан хангамж нэмэгдэн, усыг хэмнэлттэй зарцуулах нөхцөл бүрдэж, га-аас авах ургацын хэмжээ, газар тариалан эрхлэх иргэдийн тоо нэмэгдэнэ.

### **Хоёрдугаар үе шат (2014-2016) он**

**2.6.2 Тэргүүлэх зорилт: Аймгийн ХАА-н салбарын ДНБ-ий жилийн дундаж өсөлтийг 30 %-д хүргэнэ.**

#### **Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

2.6.2.1 Малчдын үйлдвэрлэл, борлуулалт, фермер, хоршоодын үйл ажиллагааг хөхүүлэн дэмжинэ;

2.6.2.2 Мал аж ахуйн үйлдвэрлэлийн мэдээллийн оновчтой тогтолцоог бий болгоно;

2.6.2.3 Бэлчээр ашиглалтын менежментийг боловсронгуй болгоно;

2.6.2.4 Төв суурин газрын дэргэд мал аж ахуйн гаралтай хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэх эрчимжсэн фермерийн болон хагас суурин аж ахуй байгуулахыг дэмжинэ;

- 2.6.2.5 Махны чиглэлийн үүлдэр, омог, гойд ашиг шимтэй малыг биотехнологийн аргаар үржүүлэхэд онцгойлон анхаарахын зэрэгцээ ямааны ба адууны мах, махан бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлнэ;
- 2.6.2.6 Малын тэжээл үйлдвэрлэх, тээвэрлэх, хадгалах, мал аж ахуйн гаралтай хүнсний бүтээгдэхүүнийг борлуулах оновчтой тогтолцоог бүрдүүлнэ;
- 2.6.2.7 Ган, зудаас хамгаалах тэжээлийн нөөцийг бий болгож, улмаар өвс тэжээл экспортлох нөхцөлийг бүрдүүлнэ;
- 2.6.2.8 Мал аж ахуйн гаралтай түүхий эдийг эцсийн бүтээгдэхүүн болгох үйлдвэрлэлийг эрчимтэй хөгжүүлнэ;
- 2.6.2.9 Хүнс хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдэд мэдлэг олгох, мэдээлэл түгээх, дамжуулах, шинэ технологи эзэмшүүлэх, зуучлах үүрэг бүхий хөдөө аж ахуйн нэвтрүүлэх үйлчилгээ бий болгох нөхцөлийг бүрдүүлнэ;
- 2.6.2.10 Сумын мал эмнэлгүүдийн лабораторийн материаллаг бааз, багаж тоног төхөөрмжийн хангамж, оношлогооны чадавхийг сайжруулна;
- 2.6.2.11 Хүн амын сүү, махны хэрэгцээнд зориулан сүүний үүлдрийн ямааны гүн хөлдөөсөн үрээр хээлтүүлэх туршилтын ажлыг хэрэгжүүлнэ;
- 2.6.2.12 “Чацаргана амин эрдэнэ”, “Ногоон хувьсгал” хөтөлбөрийг хэрэгжүүлэн, “Агропарк” төслийг эрчимжүүлэн хүлэмжийн аж ахуйг хөгжүүлнэ.

### **2.6.3 Тэргүүлэх зорилт: Сумдын хэрэгцээ шаардлагад нийцүүлэн бэлчээр усжуулалтын түвшинг дээшлүүлнэ.**

#### **Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

- 2.6.3.1 Бүх төрлийн худаг засварлах, барих ажлыг гадаад, дотоодын төсөл хөтөлбөр, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар дэмжинэ;
- 2.6.3.2 Сум бүрт үерийн хөв, далан байгуулах ажлыг эрчимжүүлж, бэлчээр усжуулалтын түвшинг дээшлүүлнэ;
- 2.6.3.3 Эдийн засгийн урамшууллын хөшүүргүүдийг хэрэглэн бэлчээрт худаг гарган ашиглах үүсгэл санаачлагыг тууштай дэмжинэ;
- 2.6.3.4 Бэлчээр усжуулах ажилд гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг татах оновчтой арга механизмыг нэвтрүүлнэ;
- 2.6.3.5 Бэлчээрийн эрсдлийн болон гамшгийн менежментэд малчид, тариаланчид, жижиг үйлдвэрлэл эрхлэгчдийг сурган дадлагажуулна;

### **2.6.4 Тэргүүлэх зорилт: Малын үүлдэр угсааг сайжруулах, гойд ашиг шимт торгон мал сүргийг хамгаална.**

#### **Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

- 2.6.4.1 Сум дундын отрын бэлчээртэй болох, хамгаалах ажлыг дэмжинэ;
- 2.6.4.2 Зудаар малгүй болсон, цөөн малтай малчдыг малжуулах арга хэмжээ авна;
- 2.6.4.3 Мал эмнэлэг, үржлийн ажил үйлчилгээг мэргэжлийн удирдлагаар хангах, зохицуулах, хяналт тавих чиг үүрэг бүхий албыг бий болгоход анхаарна;
- 2.6.4.4 Малын үүлдэр угсааг сайжруулах, гойд ашиг шимт мал, торгон сүргийг хамгаалах, Дэлгэрэх омгийн ямаатай болно;
- 2.6.4.5 “Монгол мал” хөтөлбөрийг эрчимжүүлнэ;
- 2.6.4.6 Спортын аялал жуулчлалын зориулалтаар адууны үүлдэр угсааг сайжруулж, морин тойруулга байгуулна.

**Гарах үр дүн:** Хот суурин газрын орчим эрчимжсэн фермерийн аж ахуйн тогтолцоо бий болон, тариаланчид, малчдын амьдрал ахуй, хөдөлмөр зохион

байгуулалтанд чанарын дэвшил гарч, бэлчээрийн усан хангамжийн түвшин дээшлэн, мал сүргийг өсгөн үржүүлэх таатай нөхцөл бүрдэнэ. Сум дундын ортын бэлчээр боловсронгуй болж, малын чанар сайжирсан байна.

### **Гуравдугаар үе шат (2017-2021 он)**

**2.6.5 Тэргүүлэх зорилт: Нутгийн онцлогийг харгалзан бэлчээрийн болон орон нутгийн эрчимжсэн мал аж ахуйг хослуулан хөгжүүлж, халдварт өвчний гаралт, тархалтыг эрс бууруулан малыг эрүүлжүүлж, мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, боловсруулалтыг нэмэгдүүлнэ.**

#### **Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

2.6.5.1 Малыг халдварт болон шимигчин өвчнөөс хамгаалах өндөр технологийг нэвтрүүлж эхэлнэ;

2.6.5.2 Монгол малын тэсвэрт чанарыг бататган, цус ойртохоос урьдчилан сэргийлж, биологийн боломжийг бүрэн ашиглаж, байгалийн эрсдэл даах чадварыг бэхжүүлнэ;

2.6.5.3 Малын чанар, үржлийн ажлыг сайжруулна;

2.6.5.4 Бэлчээрийг зохистой ашиглах, сайжруулах, хамгаалах, талхлагдсан бэлчээрийг нөхөн сэргээх замаар багтаамж, даацыг нэмэгдүүлэн, мал аж ахуйн эрсдлийг бууруулах арга хэмжээ авна;

2.6.5.5 Бэлчээрийн газрыг ашиглах, эзэмших уламжлалт аргыг боловсронгуй болгож, бэлчээрийн даацад зэрлэг амьтны бэлчээр, тэжээлийн хэрэгцээг орлуулан тооцох зарчмыг баримтална;

2.6.5.6 Эрдэм шинжилгээ судалгааны ажлын хүрээнд биотехнологийн ололтыг нэвтрүүлэн мал үржүүлгийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг өргөжүүлнэ;

2.6.5.7 Малчдыг хөгжүүлэх, мал аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололтыг нэвтрүүлэх болон мал аж ахуй эрхлэх арга ухааны чиглэлээр малчдын дунд албан бус сургалт явуулах нөхцөлийг бүрдүүлнэ.

**2.6.6 Тэргүүлэх зорилт: Газар ашиглалтыг сайжруулж усалгаатай тариаланг хөгжүүлэн, биотехнологи нэвтрүүлж, газар тариалангийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.**

#### **Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

2.6.6.1 Газар тариалангийн болон эрчимжсэн фермерийн аж ахуйн зориулалтаар ашиглаж байгаа газрыг өмчлүүлэх нөхцлийг бүрдүүлэхэд анхаарна;

2.6.6.2 Эрчимжсэн газар тариалан эрхэлж буй хувь хүн, аж ахуйн нэгж, байгууллагыг дэмжинэ;

2.6.6.3 Услалтын оновчтой системийг бий болгон усалгаатай газар тариалангийн техник, тоног төхөөрөмжийг лизингээр олгох, усжуулалтын барилга байгууламжийн эзэмшилт, ашиглалтыг зах зээлийн зарчимд нийцүүлж сайжруулна;

2.6.6.4 Богино хугацаанд түргэн боловсордог чанартай үрийг өргөн хэрэглэж, таримал ургамлын нэр төрлийг олшруулах арга хэмжээ авна;

2.6.6.5 Өрхийн аж ахуйн үйл ажиллагааг хөнгөвчлөх орчин үеийн бага оврын техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг дотооддоо үйлдвэрлэж байгаа аж ахуйн нэгжийг дэмжинэ;

2.6.6.6 Жимс, жимсний мод үржүүлгийн газруудыг байгуулж, жимс, жимсгэний тариалалтыг нэмэгдүүлнэ;

2.6.6.7 Таримал ургамлын өвчин, хортонтой тэмцэх, сорт, сорилтын чанарыг сайжруулж, хүлэмжийн аж ахуйг хөгжүүлнэ;

2.6.6.8 Ганд тэсвэртэй үр, нутагшсан сортын үрийн талаар бодлого боловсруулж хэрэгжүүлнэ;

**2.6.7 Тэргүүлэх зорилт: Хүнсний үйлдвэрлэлд орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлж, бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг сайжруулна.**

**Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

2.6.7.1 Экологийн цэвэр хүнсний бүтээгдэхүүний болон импортыг орлох хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх арга хэмжээ авна;

2.6.7.2 Орчин үеийн техник, технологи нэвтрүүлсэн хүнсний үйлдвэрлэлийг хөгжүүлэн хүн амыг тэжээллэг, чанартай, аюулгүй хүнсээр жигд, хүртээмжтэй хангах нөхцөлийг бүрдүүлнэ;

**2.6.8 Тэргүүлэх зорилт: Газар тариалангийн болон бэлчээрийн усан хангамжийг сайжруулж, хөдөөгийн хүн амын ундны усны хэрэгцээ шаардлагад тохирсон усны нөөцийг нэмэгдүүлнэ.**

**Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

2.6.8.1 Ашиглагдахгүй байгаа бэлчээрийг худаг гаргах замаар хурын ус хуримтлуулж, булаг шандны усыг нэмэгдүүлнэ;

2.6.8.2 Малчдын ундны усны хүрэлцээг нэмэгдүүлж, чанарыг сайжруулна;

**2.6.9 Тэргүүлэх зорилт: Малын тэжээлийн үйлдвэрлэлийг сэргээн хөгжүүлж, тэжээлийн шимт чанар, тэжээллэг байдлыг сайжруулах, хангамж, хүртээмжийг нэмэгдүүлэх цогц арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.**

**Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

2.6.9.1 “Тэжээл” хөтөлбөр хэрэгжүүлж, малын тэжээл, үйлдвэрлэлийг бий болгоно;

2.6.9.2 Шимт чанар сайтай, ургац ихтэй тэжээлийн шинэ төрлийн таримал нутагшуулах, үр үйлдвэрлэлийг дэмжиж, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, фермерийн аж ахуйг тэжээлийн ургамлаар хангах нөхцөлийг бүрдүүлнэ;

2.6.9.3 Бэлчээрийн мал аж ахуйн эрсдэл даах чадавхийг нэмэгдүүлэх зорилгоор жилийн тодорхой хугацаанд малаа тэжээдэг малчдын арга ажиллагааг дэмжинэ;

**2.6.10 Тэргүүлэх зорилт: Хөрсийг эвдрэлээс хамгаалах, үржил шимийг хадгалах, чийгийн ууршилтыг багасгахад чиглэсэн дэвшилтэт технологийг газар тариаланд нэвтрүүлнэ.**

**Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

2.6.10.1 Химийн аргаар боловсруулах уриншийн хэмжээг нэмэгдүүлэхэд анхаарна;

2.6.10.2 Ногоон бордуурт болон цомхотгосон технологиор уринш бэлтгэх арга ажиллагааг нэвтрүүлнэ;

2.6.10.3 Дэвшилтэт технологи нэвтрүүлэхэд шаардлагатай хөдөө аж ахуйн машин, техникийг худалдан авахад аж ахуйн нэгж, фермерүүдэд дэмжлэг үзүүлнэ;

2.6.10.4 Тариалангийн талбайг сүрлэн хучлагатай болгож хашаалж, хамгаалах ажлыг дэмжинэ;

2.6.10.5 Хөрсний үржил шимийг хамгаалах талаар арга хэмжээ авна;

**2.6.11 Тэргүүлэх зорилт: Биотехнологийг нэвтрүүлж, малын үүлдэрлэг чанарыг сайжруулан, таримлын ургацыг нэмэгдүүлнэ.**

#### **Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

2.6.11.1 Биотехнологи ашиглаж малын эм, ариутгал, халдваргүйжүүлэгч бэлдмэлийг орон нутгийн лабораторыг түшиглэн хөгжүүлж, мал сүргийг эрүүлжүүлэн, “Малын чанар” хөтөлбөр хэрэгжүүлнэ;

2.6.11.2 Усалгаатай газар тариалангийн орчин үеийн технологийг өргөн нэвтрүүлж, га-гаас авах ургацын хэмжээг нэмэгдүүлнэ;

**Гарах үр дүн:** Малын халдварт өвчний дэгдэлт буурч, малын бэлчээрийн зохистой ашиглалтыг сайжруулан, малчдын мал аж ахуй эрхлэх мэдлэг чадвар дээшилж, мал үржүүлгийн үйдвэрлэл өргөжинө. Бэлчээрийн усан хангамж болон газар тариалангийн тоног төхөөрөмжийн шинэчлэл хийгдэж, бэлчээрийн усан хангамж нэмэгдэн, иргэдийн оролцоо идэвхижинэ. Бэлчээрийн талбайг бүрэн ашиглан, ундны усны нөөцийг нэмэгдүүлэн, малын тэжээлийн үйлдвэрлэл өргөжих нөхцөл бүрдэнэ. Газар тариалангийн хөрсний чийгийн алдагдал буурч үржил шим нэмэгдэнэ. Орон нутгийн лабораторын хүчин чадавхи сайжирч, усалгаатай газар тариалангийн үйлдвэрлэл хөгжин, хосолсон аж ахуйн тоо нэмэгдэж, малчдын амьжиргаа дээшилсэн байна.

## **2.7 Аялал жуулчлалын салбарын хөгжил**

**Үндэслэл буюу өнөөгийн байдал:** Дорноговь аймаг нь унаган төрхөөрөө байгаа говийн байгаль, нүүдлийн соёл, түүх дурсгалууд, эртний шим ертөнцийн үлдэгдэл, ховор ан амьтан, ноён хутагт Данзанравжаагийн шашин, түүх, бичиг, соёлын өв дурсгалыг хадгалж үлдсэн аймаг юм. Данзанравжаагийн үүсгэн байгуулсан Хамарын хийд, түүний орчмын дурсгалт газар, Ханбаянзүрх уул зэрэг гадаад, дотоодын жуулчдыг татах байгаль, түүх, шашин, соёлын дурсгалт газрууд олонтой.

Хамарын хийд –Шамбалын орныг зорих жуулчдын тоо нэмэгдэх хандлагатай байна. Нийт ирж буй жуулчдын 80 гаруй хувь нь дотоодын жуулчид зонхилдог.

Аймгийн хэмжээнд Сайншанд сумын “Говь санрайз” ХХК-ийн “Таван дохио”, “Тулгат говь” ХХК-ийн “Зээгийн өглөө”, “Ийс т говь” ХХК-ийн “Шанд”, Замын-Үүд, Эрдэнэ сумдад УБТЗ-ын аялал жуулчлалын төвийн харъяа “Дорнын говь-1”, “Дорнын говь-2” зэрэг 5 жуулчны бааз, Эрдэнэ сумын Бүрдэнэ булагийн бөөрний сувилал, Даланжарагалан сумын Далантүрүүгийн рашаан сувилал, Халзан уулын рашаан сувилал, Хамарын хийдийн элсний сувилал зэрэг 4 амралт, рашаан сувилалын газар, Сайншанд суманд Д.Равжаагийн музей, Орон нутаг судлах музей, бүх сумдад Орон нутаг судлах музей, 48 зочид буудал, 42 нийтийн хоолны газар, 19 гар урлалын бүтээгдэхүүн үйлдвэрлэгч аж ахуйн нэгж, 106 бусад үйлчилгээний газар аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулж байна.

Тус аймагт аялал жуулчлалын салбарыг амжилттай хөгжүүлэх нь нийгэм эдийн засгийн хөгжлийг түргэтгэх, төсвийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлж бие даан хөгжихөд чухал түлхэц болох юм. Иймд энэ салбарыг тодорхой чиглэл, бодлогоор хөгжүүлэх шаардлага чухлаар тавигдаж байна. Аялал жуулчлалын салбар нь байгалийн унаган төрхийг хадгалах, экологийн тэнцвэрт байдлыг хангах,

богино хугацаанд орлого олох, ажлын байр бий болгох боломжтой салбар билээ. Дорноговь аймгийн газар зүйн байршил, цаг агаар, байгалийн үзэсгэлэн, түүх соёлын дурсгалт зүйл, ан амьтан, уламжлалт ёс заншил зэрэг нь гадаад, дотоодын аялагчид, жуулчдын хүсэл сонирхлыг ихээр татдаг.

Аймгийн хэмжээнд 2007 онд 12000 гаруй гадаад дотоодын аялагч ирж байсан бол 2008 онд 39000 орчим аялагч ирж аялагчдын тоо өсөх хандлагатай байсан боловч 2009 онд дэлхий нийтээр эдийн засгийн хямралтай байсан нь тус аймгийг зорин ирэх аялагчдын тоонд нөлөөлж нилээдгүй буурсан үзүүлэлттэй гарсан. 2010 онд 26000 орчим аялагч ирсэн нь дээрх тоо нэмэгдэх хандлага ажиглагдаж байна.

Аймгийн аялал жуулчлалын үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгжүүдийг нийт 100 хувь гэж үзвэл зочид буудал 20%, жуулчны бааз 2%, нийтийн хоолны газар 18%, рашаан сувилал, амралтын газар 2%, музей, сүм хийд 5%, гар урлал, бэлэг дурсгалын зүйл үйлдвэрлэгчид 8%, бусад үйлчилгээний салбар 45%-ийг эзэлж байна.

Хувийн хэвшилд тулгуурласан аялал жуулчлалын салбар манай улсад хөгжсөн сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаа тогтвортой явагдах эрх зүйн орчин бүрдсэн гэж үздэг. 2000 онд Аялал жуулчлалын тухай хууль батлагдсанаас хойш хуульд нийцүүлэн аялал жуулчлалын байгууллага, жуулчны бааз, зочид буудал, хөтөч-тайлбарлагчийн ангилал, зэрэглэл тогтоох зэрэг 10 гаруй дүрэм журам, стандартууд батлагдсан.

**Давуу тал:** ЕвроАзийг холбосон төмөр зам дайран өнгөрдөг. Энэ замыг дагаад олон улс орны жуулчид аялах боломжтой юм. Мөн бурхан шашны томоохон Энергийн төв байдаг тул мөргөлийн аялал жуулчлал илүү хөгжих боломжтой.

БНХАУ-ын Эрээн хотыг жилд 1,0 сая орчим жуулчид ирж үзэж сонирхдог байна. Эдгээр жуулчдыг Замын-Үүд боомтоор оруулж аялуулах боломжтой юм.

**Сул тал:** Дорноговь аймгийн Хамарын-хийдийн чиглэлд аялал жуулчлал харьцангуй хөгжсөн боловч нийт сумдын хэмжээнд аялал жуулчлал тэргүүлэх чиглэл болж хөгжөөгүй. Мөн бусад сумдын үзэсгэлэнт газрууд хоорондоо хол зайтай, ойр орчимд нь жуулчны бааз, буудаллах газар байхгүй. Жуулчдын дамжин өнгөрөх газарт түр буудаллах байр байхгүй.

Жуулчны баазууд болон амралт сувиллын газрууд интернетэд бүрэн холбогдоогүй учраас мэдээлэл авахад бэрхшээлтэй.

Англи, Герман, Япон, Хятад, Солонгос, Франц зэрэг улсуудын хэл мэддэг, жуулчдын үйлчилгээний мэргэшсэн боловсон хүчин дутагдалтай. Ялангуяа хэлмэрч, хөтөч, тайлбарлагч, тогооч зэрэг хүмүүсийг сургах дадлагажуулах ажил хоцорч байна.

Аяллын бүтээгдэхүүн жуулчдын бааз хоорондын зам бартаа ихтэй, одоогийн тээврийн хэрэгсэл, жуулчдыг ая тухтай явах шаардлагыг бүрэн хангаж чадахгүй.

Зочид буудал, үйлчилгээний газруудын үйлчилгээний соёлын түвшин доогуур, жуулчдыг хүлээн авах байр /буудал, гэр байшин/-ны тохижилт тэр бүрчлэн ариун цэвэр, стандартын шаардлага хангахгүй байна.

Жуулчны баазуудад дэд бүтэц сул хөгжсөн, цахилгаан эрчим хүч, холбоо харилцааны эх үүсвэр муутай.

Жуулчны баазуудад жуулчин нийлүүлэх бие даасан сүлжээ, туроператор байхгүй.

Жуулчид хоол унд болон бусад үйлчилгээний төрөл дээр сонголт хийх боломж бүрдээгүй, жуулчны баазуудын ажилтнуудын мэргэжлийн ур чадвар тааруу, аялал жуулчлал эрхлэх менежмент хангалтгүй.

Жуулчдад үйлчлэх унааны асуудлыг бүрэн шийдэж чадаагүй.

**Учирч болох эрсдэл, түүнийг тооцох нь:**

Ургамал, ан амьтны нөөц багасаж байгаль орчин доройтож болзошгүй.

### Нэгдүгээр үе шат (2011-2013 он):

**2.7.1 Тэргүүлэх зорилт: Аялал жуулчлалын тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн бодлого боловсруулна.**

#### Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- 2.7.1.1 Аялал жуулчлалын бүсүүдийн зам, харилцаа холбоо, эрчим хүчний хангамжийг сайжруулна;
- 2.7.1.2 Аялал жуулчлалын брэнд бүтээгдэхүүн, үйлчилгээтэй болсон байна.
- 2.7.1.3 Аялал жуулчлалын мэдээллийн төв байгуулахад анхаарна;
- 2.7.1.4 Аялал жуулчлалын бүсчилсэн төлөвлөгөөтэй болсон байна;
- 2.7.1.5 Дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор амралт, рашаан сувилал, хүүхдийн зуслангийн үйлчилгээг сайжруулах арга хэмжээ авна;
- 2.7.1.6 Стандартад нийцсэн үйлчилгээ бий болгохыг дэмжинэ;
- 2.7.1.7 Өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлнэ;
- 2.7.1.8 Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвөөр дамжуулан жуулчны баазуудад ажиллах мэрэгжилтэй ажилчдыг бэлтгэнэ;

### Хоёрдугаар үе шат (2014-2016 он):

**2.7.2 Тэргүүлэх зорилт: Аялал жуулчлалын салбар дахь дотоод, гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, менежментийг сайжруулах замаар төвийн бүсийн болон улсын аялал жуулчлалын сүлжээнд хамруулан, стандартын шаардлага хангасан аялал жуулчлалын үйлчилгээ явуулах нөхцөлийг бүрдүүлнэ.**

#### Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- 2.7.2.1 Аялал жуулчлалын бүх төрлийн үйлчилгээний стандартыг боловсронгуй болгож, хяналтыг сайжруулна;
- 2.7.2.2 Төр- хувийн хэвшлийн түншлэл, хамтарсан хөрөнгө оруулалтаар аялал жуулчлалын бүсүүдийг хөгжүүлнэ;
- 2.7.2.3 Аялал жуулчлалын бааз, цогцолборуудын цэвэр, бохир ус, цахилгаан, дулааны асуудлыг байгаль орчинд ээлтэй техник, технологи ашиглан шийдвэрлэнэ;
- 2.7.2.4 Аймгийн аялал жуулчлалын үйлчилгээ эрхлэгчдийг бүсийн болон улсын аялал жуулчлал эрхлэгч байгууллагуудтай холбож, хамтын ажиллагааг сайжруулна;
- 2.7.2.5 Хил орчмын аялал жуулчлалыг шинэ шатанд гаргах нөхцөлийг бүрдүүлнэ;
- 2.7.2.6 Аялал жуулчлалын мэдээллийг олон нийтэд хүргэнэ;
- 2.7.2.7 Жуулчдад үйлчлэх соёл урлагийн үйл ажиллагааг сайжруулахад анхаарна;
- 2.7.2.8 Аялал жуулчлал хөгжих таатай нөхцөл, стратегийг хэрэгжүүлэхдээ шинжлэх ухааны үндэслэлтэй, оновчтой менежментийг судлан шийдвэр гаргадаг болно;

**Гарах үр дүн:** Экологийн тэнцвэрт байдал хадгалагдана. Аялал жуулчлалын үйлчилгээ эрхлэгч байгууллагуудын орлого нэмэгдэнэ.



**2.7.3 Тэргүүлэх чиглэл: Жуулчдын сонирхлыг татсан аяллын төрлүүдийг бүс нутгаар төрөлжүүлэн хөгжүүлнэ.**

**Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

2.7.3.1 Улирлын хамаарлыг багасгаж, аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрлийг олшруулахад анхаарна;

2.7.3.2 Орчин үеийн зочид буудал, жуулчны бааз шинээр барьж тохижуулан үйлчилгээний нэр төрлийг олшруулахад анхаарна;

2.7.3.3 Бүх сумдад аялал жуулчлалын үйлчилгээг бий болгоно;

2.7.3.4 Хөшөө дурсгал, түүх соёлын дурсгалуудыг нэмэгдүүлж, цогцолбор байгуулна.

**Гуравдугаар үе шат (2017-2021 он):**

**2.7.4 Тэргүүлэх зорилт: Аялал жуулчлалын бүх төрлийг хөгжүүлэн, аймгийн эдийн засагт эзлэх байр суурийг нэмэгдүүлж, үйлчилгээний чанар, менежментийг олон улсын түвшинд хүргэнэ.**

**Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

2.7.4.1 Аялал жуулчлалын бааз, үйлчилгээний төвүүдийн чанар хүртээмжийг олон улсын түвшинд хүргэж, гадаадын улс орнуудад сурталчлах замаар олон улсын аялал жуулчлалын сүлжээнд орох нөхцөлийг бүрдүүлнэ;

2.7.4.2 Аялал жуулчлалын салбарт ажиллагсдын боловсрол, сургалтын түвшинг олон улсын жишигт хүргэж, салбарын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгоно;

**Гарах үр дүн:** Аймгийн аялал жуулчлалын салбарын хөгжих нөхцөл бүрдсэн байна.

## **2.8 Дэд бүтцийн хөгжил**

### **2.8.1 Зам тээврийн хөгжил**

**Өнөөгийн байдал:** Бүс нутгийн автозамыг хөгжүүлэх төслийн хүрээнд Азийн хөгжлийн банк, БНСУ-ын Засгийн газрын хөнгөлөлттэй зээл, Мянганы сорилтын сангийн хөрөнгө оруулалт санхүүжилтээр Чойр-Сайншанд-Замын-Үүд чиглэл буюу АН-3 чиглэлийн улсын чанартай 423 км автозам баригдаж байна.

Улсын замаас Сайншандын төврүү 6.9 км, Өргөн, Эрдэнэ сум хүртлэх 37.8 км автозамыг барих ажлыг уг төслийн хүрээнд хийгдэж байна.

2004 онд БНХАУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжийн хүрээнд Замын-Үүд суманд Улсын хилээс сумын төв, төвийн доторхи автозам, замын байгууламжийг бүрэн шинэчилсэн.

Мөн Даланзадгадаас Зүүнбаян, Сайншандаар дамжин Чойбалсан хот хүрэх 1100 км төмөр замын трасс бэлэн болоод байна.

Цаашид бүс нутгийн хөгжлийн хүрээнд Сайншандаас Хамрын хийд-Зүүнбаян-Хөвсгөл-Ханги-мандал хүртэлх чиглэлд 260 км хатуу хучилттай хар зам, Сайншандаас Сүхбаатар аймгийн Баруун-Урт сум хүртэл сайжруулсан хайрган хучилттай автозамыг улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, уул уурхай компаниудын дэмжлэгтэйгээр тавихаар төлөвлөөд байна.

### Давуу тал:

Азийн замын сүлжээний АН-4, АН-3 чиглэлийн хатуу хучилттай авто зам баригдаж ОХУ, БНХАУ-ыг холбосон сайн чанарын транзит замтай болох эхлэл тавигдана.

**АН-3 хурдны замын ашиглалтанд оруулсанаар уг коридороор ОХУ ба БНХАУ-ын хооронд авто тээврийн харилцааг хөгжүүлэх нь эдийн засгийн өндөр үр ашигтай гэсэн тооцоо, судалгаа гарсан бөгөөд ачаа эргэлтийн хэмжээ жилд 30-40 сая тонн хүрэх хэтийн төлөв бий**

Дорноговь аймгийн автозам, төмөр зам, агаарын нисэхийн сүлжээг өргөтгөх давуу тал:

- Битумжсан чулуулаг
- Шохойн чулуу
- Зам цаг уурын тааламжтай бүс.
- Олон улсын иргэний нисэхийн 3 коридор
- Нислэгийн удирдах газар

### Сул тал:

Хөдөө орон нутгийг холбосон сайжруулсан зам байхгүй. Зам засвар арчлалтад зориулсан хөрөнгө хомсдолтой.

### Нэгдүгээр үе шат (2011-2013 он):

**2.8.1.1 Тэргүүлэх чиглэл: Мянганы замын Төвийн бүсийн нутаг дэвсгэр дэх босоо тэнхлэгийг бүрэн ашиглалтанд оруулж уул замаас салаалсан замыг барьж, авто замын ажлыг шат дараатай хийж эхэлнэ.**

#### Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

2.8.1.1.1 Чойр-Сайншанд-Замын үүд чиглэлийн 238 км хатуу хучилттай авто замын ажлыг үргэлжлүүлэн барина.

2.8.1.1.2 Чойр-Сайншанд-Замын үүд чиглэлийн 176 км хатуу хучилттай авто замын ажлыг үргэлжлүүлэн барина.

2.8.1.1.3 Зүүнбаян- Цагаансуврага-Тавантолгой-Оюу толгой чиглэлээр төмөр замыг барьж эхэлнэ;

2.8.1.1.4 Аймгийн төвийн зам талбай, гүүрийг шинэчлэн сайжруулна;

2.8.1.1.5 Автомашины засвар, техникийн үйлчилгээний орчин үеийн шаардлага хангасан төвийг аймгийн төвд байгуулна;

2.8.1.1.6 Даланзадгад-Сайншанд-Чойбалсан хот хүртэлх 1100 км төмөр замын ажилд аймгийн зүгээс дэмжлэг үзүүлнэ.

**2.8.1.2 Тэргүүлэх чиглэл: Аймгийн тээврийн үйлчилгээг өргөтгөн, авто замын сүлжээг сайжруулж гол замыг хатуу хучилттай болгох**

#### Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

2.8.1.2.1 Авто замын салбарыг хөгжүүлэхэд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөс гадна гадаадын хөрөнгө оруулагчид, хувийн хэвшлийн оролцоот хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд анхаарна;

2.8.1.2.2 Сайншанд-Зүүнбаян-Хамарын хийд-Хөвсгөл-Ханги-Хатанбулаг чиглэлийн авто замыг хатуу хучилттай болгоно;

2.8.1.2.3 Сайншанд-Баруун-Урт чиглэлийн хатуу хучилттай авто зам барина;

2.8.1.2.4 Оюу-толгой-Тавантолгой-Цагаансуврага чиглэлийн төмөр замыг барих асуудлыг дэмжинэ;

2.8.1.2.5 Хот хоорондын болон орон нутгийн тээврийн үйлчилгээ чанар хүртээмжийг дээшлүүлэх, үйл ажиллагааг тогтмол явуулах нөхцөлийг бүрдүүлнэ;

2.8.1.2.6 Хатуу хучилттай авто замаар ачаа тээвэрлэх горимд яаралтай шилжүүлэх арга хэмжээг авна;

**2.8.1.3 Тэргүүлэх чиглэл: Авто тээврийн үйлчилгээг бүсийн хэрэгцээ шаардлагад оновчтой нийцүүлнэ.**

**Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

2.8.1.3.1 Дотоодын ачаа, зорчигч тээвэрлэлтийн үйлчилгээний хамрах хүрээг өргөтгөхийг дэмжинэ;

2.8.1.3.2 Аймгийн төв, Замын-Үүд суманд зорчигч үйлчилгээний төвүүдийг шинээр байгуулна;

2.8.1.3.3 Аймгийн төвд ачааг хүлээн авах, сэлгэн ачих аж ахуйнуудыг байгуулахыг дэмжинэ;

**Гарах үр дүн:** Улсын чанартай авто замын сүлжээний 90 орчим хувь нь хатуу хучилттай болж, аймгийн төв Улаанбаатар хоттой хатуу хучилттай авто замаар бүрэн холбогдсоноор авто тээврийн хөгжилд томоохон ахиц гарна. Авто замын чанар дээшилснээр зам хэрэглэгчийн болон тээвэр ашиглалтын зардал ихээхэн хэмжээгээр буурч авто тээврээс аймгийн эдийн засгийн хөгжилд оруулах хувь нэмэр дээшилнэ. Авто тээврээр тээх зорчигч болон ачаа тээврийн хэмжээ нэмэгдснээр авто тээврийн салбар төмөр зам, иргэний агаарын тээвэр гэх мэт тээврийн бусад салбаруудтай өрсөлдөхүйц хэмжээнд хүрнэ. Бүсийн төрөл бүрийн замын сүлжээний хангамж сайжирсан байна. Босоо тэнхлэгийн авто зам ашиглалтанд орсноор зам дагуух хот суурин хөгжиж, ард иргэдийн амьжиргаа дээшилнэ. Бүсийн авто тээврийн үйлчилгээний орчин үеийн нэгдсэн сүлжээний үндэс суурь тавигдсан байна.

**Хоёрдугаар үе шат (2014-2016 он):**

**2.8.1.4 Тэргүүлэх зорилт: Мянганы замаас салаалсан чиглэлүүдийн авто замын зарим хэсгийг барьж ашиглалтанд оруулна.**

**Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

2.8.1.4.1 Мянганы замаас салбарласан зарим чиглэлийн авто замыг хатуу хучилттай болгоно;

**2.8.1.5 Тэргүүлэх чиглэл: Зам, тээврийн салбарын хөгжих нөхцөлийг бүрдүүлнэ.**

**Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

2.8.1.5.1 Авто замын барилга угсралт, засвар, арчлалтын норм болон дүрэм, стандартыг боловсронгуй болгоно;

2.8.1.5.2 Авто зам, тээвэр, иргэний нисэх, төмөр замын тээврийн тухай хуулиуд, холбогдох стандартууд, дүрэм журмуудад өөрчлөлт оруулах саналыг боловсруулна.

2.8.1.5.3 Олон улсын конвенци, стандарт, шаардлага, хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн тээврийн гэрээ, хэлэлцээрүүдийг шинэчилж, олон улсад нийтээр дагаж мөрдөх гэрээ, хэлэлцээрт нэгдэн орох бэлтгэлийг хангах;

2.8.1.5.4 Аймгийн нисэх онгоцны буудлыг өргөтгөж, олон улсын зорчигч болон ачаа тээврийн онгоц хүлээн авах нөхцөлийг бүрдүүлэн хүнд даацын ачаа тээврийн аэродром байгуулах.

2.8.1.5.5 Бусад аймгийн төвүүд болон хилийн боомт, уул уурхайн томоохон ордуудыг даган бий болох суурьшлын төвүүдтэй холбосон хатуу хучилттай автозам тавих нөхцөлийг бүрдүүлнэ;

**2.8.1.6 Тэргүүлэх чиглэл: Авто замын салбарт дэвшилтэт техник технологи нэвтрүүлж, авто зам, замын байгууламжийн чанарыг дээшлүүлэн, ашиглалт, үйлчилгээг сайжруулна.**

**Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

2.8.1.6.1 Монгол орны байгаль, цаг уурын нөхцөлд тохирсон авто зам барих технологи нэвтрүүлж, техник, технологийн шинэчлэл хийнэ;

2.8.1.6.2 Авто замын туршилт, сорилт судалгааны ажлыг сайжруулна;

**2.8.1.7 Тэргүүлэх чиглэл: Авто тээврийн хэрэгслээс хүрээлэн байгаа орчин, хүн ам, замын хөдөлгөөнд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулна.**

**Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

2.8.1.7.1 Тээврийн хэрэгслийг шингэрүүлсэн шатдаг хийн түлшинд шилжүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ;

2.8.1.7.2 Тээврийн хэрэгслийн татварыг байгаль орчинд үзүүлж буй нөлөөллийг нь тооцон боловсронгуй болгоход анхаарна;

**Гарах үр дүн:** Бүсийн авто замын нэгдсэн сүлжээ бий болсон байна. Авто замын салбарт дэвшилтэт техник, технологи нэвтэрч, авто зам, замын байгууламжийн ашиглалт, үйлчилгээ сайжирсан байна. Олон улсын стандартад нийцсэн шинэ технологи нэвтрүүлсэн байна.

**Гуравдугаар үе шат (2017-2021 он):**

**2.8.1.8 Тэргүүлэх зорилт: Төмөр замын өрсөлдөх чадварыг дээшлүүлж, хөдөлгөөний аюулгүй байдлыг сайжруулна.**

**Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

2.8.1.8.1 Хөрш орнуудыг холбосон хоёр дахь төмөр замыг барихад дэмжлэг үзүүлнэ;

2.8.1.8.2 Говийн болон зүүн бүсэд төмөр замын сүлжээг өргөтгөх нөхцөлийг бүрдүүлнэ;

2.8.1.8.3 Төмөр замын дотоодын нэгдсэн сүлжээ байгуулах асуудлыг ашигт малтмалын орд газруудыг ашиглалтад оруулахтай холбон оновчтой төлөвлөж, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ;

**2.8.1.9 Тэргүүлэх чиглэл: Авто зам болон төмөр замын сүлжээг өргөтгөн, агаарын тээврийг хөгжүүлэх, хөрш аймгын төвүүдтэй хатуу хучилттай авто замаар холбогдох нөхцөлийг бүрдүүлнэ.**

**Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

- 2.8.1.9.1 Дэд бүтцийн босоо тэнхлэгүүдийн дагуух хатуу хучилттай авто замыг барьж дуусгана;
- 2.8.1.9.2 Авто зам ашиглалтын үр ашигтай шинэ тогтолцоог бий болгон ажиллуулна;
- 2.8.1.9.3 Төмөр замын сүлжээг барьж дуусгахад анхаарч ажиллана;
- 2.8.1.9.4 Агаарын тээврийн үйлчилгээг өргөжүүлэн, хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.
- 2.8.1.9.5 Олон улсын авто замын сүлжээнд нэгдсэн чиглэлүүдийн дагуух авто замыг тэргүүн ээлжинд барихад анхаарна;
- 2.8.1.9.6 “Мянганы зам”-ын босоо тэнхлэгүүдийг барьж дуусгана;
- 2.8.1.9.7 Дэд бүтцийн зарим босоо тэнхлэгийн дагуух хатуу хучилттай авто замыг барьж дуусгана;
- 2.8.1.9.8 Хөрш аймгууд хооронд хатуу хучилттай автозамаар холбогдох нөхцөлийг бүрдүүлэхэд анхаарна;

**Гарах үр дүн:** Азийн авто замын сүлжээний АН-32 чиглэлийн 2520 км авто замын ашиглалтын нөхцөл сайжирч хатуу хучилттай болсон байна. Хоёр дахь төмөр зам барих ажлыг дуусгаж, ашиглалтад оруулсан байна. Сайншанд-Чойбалсан чиглэлийн төмөр замын сүлжээ бий болж, Чойбалсан-Бичигт чиглэлийн төмөр замын сүлжээ бий болох ажил эхэлсэн байна. Говийн болон Зүүн бүсийн төмөр замын шугамууд ашиглалтад орж, тээвэрлэлтийн үйл ажиллагаа хэвийн явагдаж эхэлсэн байна. Авто замын ашиглалтын байдлыг сайжруулахын тулд засвар арчлалтын ажлыг шинэ түвшинд хүргэнэ.

**2.8.2 Эрчим хүчний салбарын хөгжил**

**Үндэслэл буюу өнөөгийн байдал:** Дорноговь аймгийн 14 сумаас 2 сум нар салхины сэргээгдэх эрчим хүчээр хангагдсан. Бусад сумд цахилгаанаар бүрэн хангагдсан байна. Цаашдаа байгалийн шавхагдашгүй нөөцийг ашиглан эрчим хүч үүсгэх ажлыг судалж зарим нэг үр дүнд хүрээд байна. Манай аймаг нэлээд хэдэн нүүрсний ордуудтай түүндээ тулгуурлан нүүрснээс шингэн түлш боловсруулах, бусад шинэ технологийг судлан бусад үйлдвэрүүдийг байгуулахаар судалгаа хийгдэж байна.

Даланжаргалан, Айраг, Иххэт сумдыг Чойрын ЦТСС, Эрдэнэ сум, Сайншандын 4-р баг, Замын-Үүдийн төвийн хэсгийг УБ ТЗ ЭХУХ 2-р анги, Сайншанд сумын 1.2.3-р баг, Алтанширээ, Дэлгэрэх, Өргөн, Зүүнбаян, Замын-Үүдийн гэр хорлоолол, Улаанбадрах, Хөвсгөл, Сайхандулаан сумдыг Дорноговь ЦТССалбар тус тус хариуцан үйлчилж байна.

Мөн 2007-2010 онд Дорноговь аймгийн Хатанбулаг сум салхин станц, Мандах суманд нар, салхи хосолсон станц баригдан ашиглалтанд орсон.

Дорноговь ЦТСС-ын ашиглалтад байгаа 6-35 кВ-ын ЦДАШ, трансформатор болон хүчний тоноглолууд нь олон жил ашиглагдсан насжилт өндөр болсон /1938 оны трансформатор хүртэл ашиглалтанд байгаа/ тул цаашид тоног төхөөрөмжүүдийг шинэчлэх, орчин үеийн алдагдал багатай, найдвартай ажиллагаа сайтай тоног төхөөрөмжөөр солих шаардлагатай болж байна.

### **Бүх үе шат (2010-2021 он):**

**2.8.2.1 Тэргүүлэх зорилт: Эрчим хүчний салбарын үйлдвэрлэлийг жилд дундажаар 20-30 хувиар өсгөнө.**

#### **Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

2.8.2.1.1 Дулааны болон цахилгааны эрчим хүчний хэрэглээний үнийг үе шаттайгаар бууруулах төсөл тооцооллыг гаргаж бүс нутгийг үйлдвэрлэл үйлчилгээ, амьдрах орчны ая тухтай нөхцөлийг бүрдүүлэхэд анхаарна;

2.8.2.1.2 Шинэ суурьшлын бүсүүдэд дулааны эх үүсвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, шинэ технологийг нэвтрүүлэх асуудлыг судалж төсөл боловсруулан хэрэгжүүлнэ;

2.8.2.1.3 Хөрөнгө оруулалтын өгөөжийг тооцоолсны үндсэн дээр эрчим хүчний салбарын шинэчлэл, хөрөнгө оруулалтын төслүүдийг хэрэгжүүлж сумдын халаалтын тогоонуудад шинэ дэвшилтэт техник технологи нэвтрүүлж, техникийн шинэчлэл хийнэ;

2.8.2.1.4 Цахилгаан эрчим хүчний өртөгийг бууруулах замаар хэрэглээг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ;

**2.8.2.2 Тэргүүлэх зорилт: Эрчим хүчний менежментийг боловсронгуй болгож, байгаль орчинд халгүй тэргүүний техник технологи нэвтрүүлэхийг бодлогоор дэмжих, үйлдвэрлэл, хэрэглээний үр ашгийг сайжруулах**

#### **Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

2.8.2.2.1 Сумдын түвшинд бага оврын халаалтын зуухтай хэрэглэгчдийг дулаан хангамжийн төвлөрсөн системд холбож, хэрэглээг нэмэгдүүлэх;

2.8.2.2.2 Хөдөөгийн малчин айл өрхийг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээр хангах нөхцөлийг бүрдүүлэх;

2.8.2.2.3 Нүүрснээс утаагүй түлш үйлдвэрлэх бага оврын үйлдвэрүүд байгуулж ажиллуулах;

2.8.2.2.4 Эрчим хүчний байгууллагын үйл ажиллагааг өргөтгөх, мэргэжилтэй ажилтныг бэлтгэх, сургаж дадлагажуулах.

2.8.2.2.5 Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг нэмэгдүүлэх, нар салхины цахилгаан станц байгуулахад дэмжлэг үзүүлнэ.

### **2.8.2.3 Тэргүүлэх зорилт: Тоног төхөөрөмжийн хэвийн найдвартай ажиллагааг хангах, хэрэглэгчдийг аюулгүй, найдвартай, стандартын цахилгаан эрчим хүчээр хангах**

2.8.2.3.1 Шугам сүлжээ /0.4-35 кВ/-ний схемийг аймгийн хот байгуулалтын төлөвлөгөө, газар олголттой холбогдуулан хамгийн оновчтой хувилбараар өөрчлөн, сүүлийн үеийн дэвшилтэт тоног төхөөрөмжөөр сольж шинэчлэх;

2.8.2.3.2 Зүүнбаян тосгоны 0.4 кВ-ын ЦДАШ-ыг шинэчлэх ажлыг улсын төсвийн хөрөнгөөр хийх ажлыг зохион байгуулах;

2.8.2.3.3 Сайншанд сумын 0.4 кВ-ын ЦДАШ, Замын-Үүдийн 0.4 кВ-ын ЦДАШ-ыг бүрэн орчин үеийн евростандартад шилжүүлэх

2.8.2.3.4 Хатанбулаг сумыг Цагаансуврагаас 10-15 кВ-ын ЦДАШ-аар ТЭХ-ний системд холбох;

### **2.8.2.4 Тэргүүлэх зорилт: Сайншандад Хүнд аж үйлдвэрийн цогцолбор төв байгуулахтай холбогдуулан хэрэглэгчдийг цахилгаан, эрчим хүчээр хүртээмжтэй хангах нөхцөлийг бүрдүүлэх**

#### **Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:**

2.8.2.4.1 Сайншанд 110 кВ-ын ЦДАШ, дэд станцыг 220 кВ-ын ЦДАШ руу шилжүүлэх, Зүүнбаян 35 кВ-ын шугам, дэд станцыг 110 кВ-ын шугам дэд станц руу шилжүүлэх.

2.8.2.4.2 Сайншанд суманд Аж үйлдвэрлэлийн цогцолбор байгуулагдах хот төлөвлөлттэй уялдуулан 6-10 кВ-ын хувиарлах сүлжээг өргөтгөн барих

**Гарах үр дүн:** Хэрэглэгчдэд хүрэх эрчим хүчний хүчдлийн чанар сайжран, галын аюулгүй байдал бүрэн хангагдаж, байгаль цаг агаараас /хүчтэй шороон цасан шуурга, бороо уснаас/ шалтгаалах цахилгааны тасалдал байхгүй болох нөхцлийг бүрдүүлнэ. Хатанбулаг сумыг төвийн эрчим хүчний системд холбосноор аймгийн бүх сумд цахилгаан эрчим хүчээр бүрэн хангагдана.

### **2.8.3 Мэдээлэл харилцаа холбоо, технологийн хөгжил**

**Үндэслэл буюу өнөөгийн байдал:** Бүх сумд үүрэн холбооны сүлжээтэй болсон. Шилэн кабелиар интернетэд холбогдсон. Олон сувгийн кабелийн телевизтэй. Үүрэн телефоны оператор 5 компаний салбар ажиллаж байгаагаас мобикомын 10, скайтелийн 9, юнителийн 11, F-Zon-2, G-Mobile -9 нийт 51 салбар сум суурин газруудад Скайтел 5500 хэрэглэгч, Мобиком 13000 хэрэглэгч, юнител 19500 хэрэглэгч, G-mobile 2300 хэрэглэгчтэй болоод байна. Нийт 30.0 мянган хэрэглэгчдэд үйлчилгээ үзүүлж нийт 2046.2 сая төгрөгийн орлоготой ажилласан нь өнгөрсөн оноос 86.1 сая төгрөгөөр илүү байна.

**Давуу тал:** Дэлхийн улс оронтой мэдээлэл солилцох бүрэн боломж хангагдаж, ард иргэдийн мэдээ, мэдээлэл хүлээн авах, өөрийгөө хөгжүүлэх өргөн бололцоо нээгдсэн.

**Сул тал:** Хүний уураг тархи хэт их ачаалалд орж, эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлнэ.

#### **Нэгдүгээр үе шат (2011-2013 он):**

**2.8.3.1 Тэргүүлэх чиглэл: Мэдээлэл, холбооны технологийг хөгжүүлэх хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх**

#### **Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

- 2.8.3.1.1 Мэдээллийн технологийн сургалтын төв байгуулан, мэдээлэл холбооны технологид тулгуурласан бүх төрлийн үйлчилгээг дэмжин хөгжүүлнэ;
- 2.8.3.1.2 Төрийн албан хаагчийн ажлын байрны автоматжуулалтын түвшинг нэмэгдүүлэн төрийн байгууллага хоорондын үр өгөөжтэй мэдээллийн харилцааг хөгжүүлж, е-засаглал, е-оффисыг нэвтрүүлж эхэлнэ;
- 2.8.3.1.3 Мэдээллийн нэгдсэн сан, сүлжээ байгуулан, яам, агентлагуудтай сүлжээгээр мэдээлэл солилцох нөхцлийг бүрдүүлнэ;
- 2.8.3.1.4 Мэдээллийн санг интернетийн сүлжээгээр тархаах, Онлайн үйлчилгээ бий болгон, интернетийн сулжээг ашиглан дэлхийн улс орнуудтай мэдээллийг чөлөөтэй солилцох нөхцлийг бүрдүүлнэ;
- 2.8.3.1.5 Хэрэглэгчдэд сүлжээгээр дамжуулан мэдээллийн санд харьцаж мэдээлэл олж авах боломжийг бүрдүүлнэ;
- 2.8.3.1.7 Мэдээлэл тархаалт үйлчилгээний боловсон хүчнийг сургаж бэлтгэн, дадлагажуулна;
- 2.8.3.1.8 Орон нутгийн байгууллагын хүрээнд мэдээлэл тархаалтын стандартыг бий болгох, мэдээллийн төрөл хэлбэр, техник хэрэгслэлийг ижил түвшинд хүргэх нөхцлийг бүрдүүлнэ;
- 2.8.3.1.9 Орон нутгийн байгууллагууд, бүх сумдтай электрон шуудангаар харилцаж мэдээлэл авах нөхцөлийг бүрдүүлнэ;
- 2.8.3.1.10 Электрон үйлчилгээг иргэдэд хүргэх боломжийг бүрдүүлнэ;
- 2.8.3.1.11 Номын сангийн захиалга, эрэлт, хайлтын үйлчилгээг электрон хэлбэрт оруулах бэлтгэлийг хангана;
- 2.8.3.1.12 Web-д суурилсан зайны сургалт, чөлөөт цагийн үйлчилгээ /Номын сан, музей, тоглоомын төв/-нд электрон үйлчилгээг нэвтрүүлнэ;
- 2.8.3.1.13 Радио телевизийн сүлжээг шинэчилж, тоон технологит шилжүүлнэ;
- 2.8.3.1.14 Сайншанд-Замын-Үүд-Улаанбадрах-Зүүнбаянг шилэн кабелиар холбож сүлжээний битүү цагираг үүсгэхэд анхаарна;
- 2.8.3.1.15 IP суурьтай мэдээллийн багцыг Замын-үүдээр дайруулан Олон Улсын гарцтай болгох нөхцлийг бүрдүүлнэ;
- 2.8.3.1.16 Мандах, Сайхандулаан, Дэлгэрэх сумдыг агаарын шугамаас чөлөөлж шилэн кабелийн сүлжээгээр тухайн сумдад мэдээллийн үйлчилгээ үзүүлэх нөхцлийг бүрдүүлнэ;

**Гарах үр дүн:** Бүх салбарын үйл ажиллагааг электрон хэлбэрт шилжүүлж, бүх нийтийн мэдээллийн нэгдсэн сүлжээ байгуулан, интернет, мэдээллийн технологийн хэрэглээг бий болгосноор мэдээлэл холбооны технологийн салбарыг жинхэнэ ёсоор бүрдүүлж эдийн засаг, нийгмийн салбарын хөгжлийн хурдасгуур болгосон байна.

#### **Хоёрдугаар үе шат (2014-2016 он):**

**2.8.3.2 Тэргүүлэх зорилт:** Хиймэл дагуулын болон бага багтаамжийн радио релейний шугам, хөдөлгөөнт холбоог ашиглан хот айл, малчдыг бүрэн холбоожуулна.

#### **Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

- 2.8.3.2.1 Алслагдсан сумдад утасгүй холбооны технологийг нэвтрүүлэхэд анхаарна;



- 2.8.3.2.2 Бүсийн үүрэн телефоны хэрэгцээг хангах нөхцлийг бүрдүүлнэ;
- 2.8.3.2.3 Интернетийн сүлжээг сумын түвшинд өргөтгөж, компьютер, интернет хэрэглэгчдийн хэрэгцээг бүрэн хангах нөхцлийг бүрдүүлнэ;

**2.8.3.3 Тэргүүлэх зорилт: Мэдээлэл харилцааны технологийн салбарын программ хангамж, технологи, бүтэц, зохион байгуулалт, санхүү, эдийн засгийн болон хүний нөөцийн нэн таатай орчинг бүрдүүлнэ**

**Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

2.8.3.3.1 Мэдээлэл, харилцаа холбооны газрын суурь сүлжээг тоон технологид бүрэн шилжүүлж 3G-ийн үелзлэлд оруулж, газар, сансрын хосолсон өндөр хурдны, өргөн зурвасын сүлжээ, интернэтийн дамжлага гарц 2-ыг бий болгохыг дэмжинэ.

**2.8.3.4 Тэргүүлэх зорилт: Шилэн кабелиар сумд хоорондыг холбох замаар мэдээлэл харилцааны шуурхай, найдвартай байдлыг дээшлүүлнэ**

**Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

2.8.3.4.1 “Цахим Монгол” хөтөлбөрийн зорилт, арга хэмжээг үе шаттайгаар аймаг, сумдад хэрэгжүүлнэ;

2.8.3.4.2 Бүх сумдын төвд интернет цэг, интернет кафе байгуулж үйлчлэх нөхцлийг бүрдүүлнэ;

2.8.3.4.3 Бүсчлэлийн нэгдсэн (ZIP) кодыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, энгийн хэрэглээ болгоход анхаарна;

2.8.3.4.4 Орон нутгийн телевизийг аймгийн нутаг дэвсгэрийг хамран цацагдах боломжийг судлан үзэж, холбогдох тооцооллуудыг хийн мэргэжлийн телевиз болгон хөгжүүлэхэд анхаарна.

**2.8.3.5 Тэргүүлэх зорилт: Сумдын мэдээлэл, харилцаа холбооны дамжуулах сүлжээг шилэн кабель, сансрын холбоо, радио холбооны технологиор шинэчлэнэ.**

**Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

2.8.3.5.1 Бүх сумдын иргэд, малчдад утасгүй холбоо, үүрэн телефоны үйлчилгээг хүргэх нөхцлийг бүрдүүлнэ;

2.8.3.5.2 Шуудан холбооны сүлжээг ашиглан орчин үеийн шинэ төрлийн электрон үйлчилгээ болон хэрэглээг нэвтрүүлэх, багийн шуудан хүргэлтийн давтамжийг нэмэгдүүлнэ;

2.8.3.5.3 Аймгийн төвийн болон сумдын дамжуулах болон холбох байгууламжийг тоон технологид бүрэн шилжүүлэхэд анхаарна.

**2.8.3.6 Тэргүүлэх зорилт 5. Мэдээлэл, харилцаа холбооны шинэ үйлчилгээ хэрэглээг төр, аж ахуйн болон үйлчилгээний бүх байгууллагуудад өргөн нэвтрүүлнэ.**

**Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

2.8.3.6.1 Аймгийн төвийн төр, захиргаа, аж ахуйн нэгж байгууллагыг нэгдсэн сүлжээнд холбож, мэдээллийн санг бүрдүүлнэ;

2.8.3.6.2 Шинээр үүсэх суурингуудын эмнэлэг, сургуулийг мэдээлэл, харилцаа холбооны нэгдсэн сүлжээнд холбоход анхаарна.

**Гарах үр дүн:** Мэдээлэл, харилцаа холбооны орчин үеийн оновчтой сүлжээ бий болсон байна. Суурь сүлжээг бүх сумдын түвшинд тоон технологид шилжүүлсэн байна. 3G технологийг хүн амын 60 хувьд нэвтрүүлсэн байна.

#### **Гуравдугаар үе шат (2017-2021 он):**

**2.8.3.7 Тэргүүлэх зорилт: Мэдээлэл харилцааны технологийн ололтыг нийгэм, эдийн засгийн бүх салбарт өргөн нэвтрүүлнэ.**

#### **Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

2.8.3.7.1 Зайн эмчилгээ, оношлогооны анхдагч тусламж, үйлчилгээг үзүүлдэг болгож, нарийн мэргэжлийн эмч нар зайнаас зөвлөгөө өгөх, мэргэжлийн тусламж үзүүлэх боломжийг бүрдүүлэхэд анхаарна;

2.8.3.7.2 Зайн банкны үйлчилгээ, зайн төлбөр тооцоо, зайн худалдаа, арилжаа, бэлэн бус мөнгөний эргэлт, нийгмийн халамжийн зайн үйлчилгээг нэвтрүүлэхэд анхаарна;

2.8.3.7.3 Хөдөө, орон нутагт утасгүй холбооны системийг эрчимтэй хөгжүүлж, 2015 он гэхэд үүрэн телефоны шинэ үеийн үйлчилгээг газрын суурь сүлжээг ашиглан хүн амын 60 хүртэл хувьд хүргэж, газар нутгийн 50 хүртэл хувийг зөвхөн газрын суурь сүлжээний тусламжтайгаар хамруулна.

**2.8.3.8 Тэргүүлэх чиглэл: Мэдээлэл, харилцааны технологийн салбарын программ-техник, мэдээлэл хангамж, технологи, бүтэц, зохион байгуулалт, санхүү, эдийн засаг, хүний нөөцийг боловсронгуй болгож, шинэчлэн сайжруулна.**

#### **Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

2.8.3.8.1 Нийт сум, сууринг шилэн кабелийн болон бага оврын тоон радиорелейн сүлжээгээр холбож, төрийн болон арилжааны цахим үйлчилгээг хүлээн авах боломжийг хөдөөгийн хүн амын 70 хүртэл хувьд хүргэнэ;

2.8.3.8.2 Гео байнгын байршилтай зайнаас тандах оптикийн буюу радиолокацийн бага оврын, хямд төсөр хиймэл дагуулын систем бий болгож, геодези, зураг зүй, цаг уур, байгаль орчны хяналт, хөдөө аж ахуй, гамшгийн аюулгүй байдал, батлан хамгаалах болон онц байдлын нөхцөлд сансрын зураглалыг ашиглана;

2.8.3.8.3 Суурин болон хөдөлгөөнт хэлбэрээр мэдээлэл, харилцааны технологийн үйлчилгээг хүн бүр хүлээн авах боломжийг бүрдүүлнэ;

2.8.3.8.4 Программ хангамжийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд анхаарна;

**Гарах үр дүн:** "E-Health", "E-Banking" төсөл хэрэгжиж дууссан байна. Хөдөө орон нутагт байгаа нийт хүн амын 60 -аас доошгүй хувь нь тус үйлчилгээнд хамрагдсан байна.

## 2.9 Хот байгуулалт, барилга, бүтээн байгуулалтын хөгжил

**Үндэслэл буюу өнөөгийн байдал:** Аймгийн нутаг дэвсгэр дэх Сайншанд, Замын-Үүд сумдаас бусад 12 сумын ерөнхий төлөвлөгөөг 1974-1986 онуудын хооронд боловсруулсан бөгөөд одоогоор тухайн хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө нь мөрдөгдөхгүй болж, нийгэм эдийн засгийн хөгжлийн нийтлэг шаардлага, эрэлт хэрэгцээний дагуу зайлшгүй шинэчлэн боловсруулах шаардлага тулгарч байна.

Монгол Улсын Шадар сайдын 2009 оны 90-р захирамжаар Замын-Үүд сумын хот төлөвлөлтийн ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах ажлын хэсгийг байгуулан, Замын-Үүд сумын ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын гүйцэтгэгчээр “Ти энд жи” ХХК ажилласан бөгөөд 330.0 сая төгрөгийн өртөгөөр 12 төлөвлөлтийн хэсэгтэй, 1:2000 масштабын макеттай хот байгуулалтын иж бүрэн ерөнхий төлөвлөгөө боловсруулагдаж дууссан.

Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 140 дүгээр тогтоолоор аж үйлдвэрийн цогцолбор болон орд газрыг түшиглэн байгуулагдах хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын хүрээнд “Сайншанд” аж үйлдвэрийн цогцолбор байгуулахтай холбогдон суурьшлын бүсийн асуудлыг шийдвэрлэхээр аймгийн удирдлагууд Япон улсын Никити группээр “Эко таун”-ы суурьшлын төлөвлөлт хийлгэхээр гэрээнд гарын үсэг зураад байна.

Сайншанд сумыг орон нутгийн зэрэглэлтэй хот болгох саналыг аймгийн ГХБХБГ-аас боловсруулан, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийн 2010.05.07-ны өдрийн 43 тоот тогтоолоор батлагдаж, Газрын харилцаа, барилга, геодези зураг зүйн газарт хүргэгдээд байна.

Хатанбулаг сумын нутаг дэвсгэрт орших “Ханги мандал” хилийн боомтын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах зургийн даалгаварт орон нутгийн саналыг тусган ЗТБХБЯамны Хот байгуулалт, газрын харилцааны бодлого зохицуулалтын газарт хүргүүлээд байна.

Говийн болон хилийн ойролцоо хотуудын хот байгуулалтыг хөгжүүлэх зорилгоор “Өмнөговь болон Дорноговь аймгийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжил төсөл”-ийг Сангийн яам, ЗТБХБЯ болон Азийн хөгжлийн банктэй хамтран боловсруулан 2010.06.07-ны өдөр аймгийн Засаг дарга П.Ганхуяг төслийн гэрээнд гарын үсэг зураад байна. Энэ төслийн хүрээнд Сайншанд суманд цэвэр усны 16.3 км, бохир усны 23.1 км, халаалтын 4 зуух, дулааны шугам 11.5 км, цэвэрлэх байгууламжийг шинэчлэх, автозам 2 км, хогийн төвлөрсөн цэг байгуулах ажлууд хамрагдахаар төлөвлөгдөж байна.

Замын-Үүд суманд дулааны станц, инженерийн шугам сүлжээ шинээр байгуулах ажлыг БНХАУ-ын 58.0 сая долларын зээлийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэхээр шийдвэрлэж ЗТБХБЯ-ны ССХОБЗА-наас гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтыг явуулж “CHINA CAMC ENGINEERING” компани шалгарсан. 90 МВт-ын Дулааны станц, дулаан дамжуулах шугам, цэвэр, бохир усны шугам, гүний худгууд гэх мэт ажлыг 3 жилийн хугацаанд гүйцэтгэхээр гэрээ байгуулан судалгааны ажил хийгдэж байна.

Аймгийн Засаг дарга П.Ганхуягийн урилгаар ОМӨЗО-ны Эрээн хотын дарга дагалдах зочид төлөөлөгчдийн хамт 06 дугаар сарын 19-20-ны өдрүүдэд

Сайншанд хотод ажлын айлчлал хийж хот байгуулалтын чиглэлээр хамтран ажиллахаар гэрээ хэлэлцээр хийгдсэн.

Дорноговь аймагт барилга угсралтын чиглэлээр “Хулшанд” ХХК, “Нэгдсэн монгол” ХХК, “Эвийн гэрээ” ХХК, “Барган” ХХК, “Эибол” ХХК, “Говьбаяннуур” ХХК, “Чандмань-Илч” ХХК, “Миний Сайншанд” ХХК, “ДДСЦ” ХХК-нууд тусгай зөвшөөрөл эзэмшин үйл ажиллагаа явуулж байна.

Орон нутгийн барилгын компаниудын хүчин чадлыг нэмэгдүүлэх, боловсон хүчний чадавхийг сайжруулах, нэгдэж хоршин ажиллах нөхцөл боломжийг хангахад аймгийн төр захиргааны байгууллагаас тусгайлан бодлого боловсруулан ажиллаж байна. Үүний үр дүнд 2010 онд барилга үйлдвэрлэлийн “Эвийн гэрээ” ХХК, “Нэгдсэн монгол” ХХК, “Монголт” ХХК-ууд нэгдэж “Дорнын барилга концерциум”-ыг үүсгэн байгуулаад байна. “Дорнын барилга концерциум” нь Сайншанд сумын 2 дугаар багт “Нарлаг шанд-1” бичил хорооллын 94 айлын орон сууц /нэг айлын хаус-2, таван айлын хаус-4, арван найман айлын орон сууц-4/-ны барилга барихаар гэрээ байгуулан, зураг төсөл боловсруулах, хөрсний инженер геологийн судалгаа хийлгэх ажлууд явагдаж байна.

2010 онд “Саруул цонх” ХХК нь 100 гаруй м<sup>2</sup> цонх, “Тээлийн шонхор” ХХК нь 300 тн цемент, “Говь санрайсэ” ХХК нь 25 мянга гаруй блок, туршилтаар өнгөтэй өнгөгүй элсэн тоосго, явган замын хашлага үйлдвэрлэсэн байна.

Орон нутгийн барилга үйлдвэрлэлийн “Эвийн гэрээ” ХХК нь 2010 онд ОХУ-аас пенобетоны жижиг үйлдвэрийн тоног төхөөрөмжийг оруулж ирсэн бөгөөд туршилт тохируулгын ажил хийгдэж байна.

Барилга хот байгуулалтын Сайдын 2007 оны 165 дугаар тушаалаар батлагдсан “Барилгын материалын үйлдвэрийг хөгжүүлэх мастер төлөвлөгөө”-нд тусгагдсан зорилтуудыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд тус аймгийн Даланжаргалан сумын Билүүтийн шохойн чулуун ордыг түшиглэн “МАК” ХХК-ний цемент, шохойн үйлдвэр, Өргөн сумын Сөгдөхийн шохойн чулууны ордыг түшиглэн “Ялгуун интернейшнл” ХХК, “Монполимент” ХХК-ний цемент, шохойн үйлдвэрүүд байгуулагдаж байна. Мөн Өргөн сумын нутагт Хонины аав ордыг түшиглэн “Цагаан говь” ХХК-ний шохойн үйлдвэр байгуулах ажлын техник эдийн засгийн үндэслэл боловсруулагдаад байна.

Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 140 дүгээр тогтоолын дагуу “Сайншанд” аж үйлдвэрийн цогцолбор байгуулахтай холбогдон суурьшлын бүсийн асуудлыг шийдвэрлэхээр аймгийн удирдлагууд Япон улсын Никити группээр “Эко таун”-ы суурьшлын төлөвлөлт хийлгэхээр гэрээнд гарын үсэг зураад байна.

Уг суурьшлын бүс нь цахилгаан эрчим хүч сэргээгдэх эрчим хүчээр хангагдах бөгөөд байгальд ээлтэй ямар нэгэн хор нөлөөгүй цэвэр орчин бүрдсэн цоо шинэ суурьшлын бүсийг төлөвлөж байгаа юм.

### **Нэгдүгээр үе шат (2011-2013 он):**

**2.9.1 Тэргүүлэх зорилт: Хүн амын нутагшилт, суурьшлын зохистой тогтолцоог хөгжүүлж, хот суурингийн оршин суугчдад таатай орчин бүрдүүлнэ.**

#### **Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

2.9.1.1 Орон сууцны хангамжийг сайжруулан, өрх бүрийг эрүүл ахуйн шаардлага хангасан тохилог орон сууцаар хангах нөхцөлийг бүрдүүлнэ.

2.9.1.2 Орон сууцны зээл төсөлд хамруулах, орон сууцны хангажийг үе шаттай нэмэгдүүлэх, одоо байгаа орон сууцны чанарыг сайжруулах.

2.9.1.3 Орон сууцыг барих, төлөвлөх үйл ажиллагаанд хот байгуулалт, архитектур, байгалийн эрүүл ахуй, экологи, аюулгүй байдал оршин суугчдын эрх ашгийг харгалзах.

2.9.1.4 Аймаг, сумын төвийн гэр хорооллын инженерийн шугам сүлжээг холбох ажлыг үе шаттай эхлүүлэх.

2.9.1.5 Төвлөрсөн системд холбогдсон бүх орон сууцыг хэрэглээний халуун устай болгох.

2.9.1.6 Барилга байгууламж, объектуудын өнгө үзэмжийг сайжруулах хотын өнгө үзэмжид эерэгээр нөлөөлөхүйц өнгө төрхтэй болгох арга хэмжээг үе шаттайгаар авах

2.9.1.7 Аймгийн төв болон сум суурин газруудын хүн амын төвлөрөлд тааруулан олон нийтийн үйлчилгээний барилга байгууламж болон сургууль, цэцэрлэг, эмнэлгийн хангамжийг нэмэгдүүлнэ.

2.9.1.8 “Сайншанд” аж үйлдвэрийн цогцолбор байгуулагдахтай холбогдон байгаль орчинд хор нөлөөгүй сэргээгдэх эрчим хүчээр хангагдсан шинэ “Эко таун” суурьшлын бүсийг бий болгоно.

## **2.9.2 Тэргүүлэх чиглэл: “Орон сууц” хөтөлбөрийг хэрэгжүүлэх.**

### **Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

2.9.2.1 Төрийн албан хаагчдын орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх.

2.9.2.2 Хүн амд орон сууцны зориулалтаар газар олгож, барилга барих шинэ технологид сургах замаар амьдралаа дээшлүүлэхэд нь туслах.

2.9.2.3 Орон сууцны хорооллыг нягтруулж, төв суурин газрын дэд бүтцийн үр ашгийг дээшлүүлэх бодлого барих.

2.9.2.4 Орон сууцны бодит хөгжлийг дэмжих санхүүгийн нөөц бололцоог нэмэгдүүлэх.

Гарах үр дүн: Аймаг орон нутгийн орон сууцны хангамж нэмэгдсэн байна.

### **Хоёрдугаар үе шат (2014-2016 он):**

**2.9.3 Тэргүүлэх зорилт: Хотыг орон сууцжуулах замаар хүн амын орон сууцны нөхцөлийг сайжруулж, хангамжийг нэмэгдүүлэх**

### **Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

2.9.3.1 Төлөвлөгөөний дагуу орон сууцны зориулалтаар тусгагдсан газруудад дэд бүтцийг байгуулах, орон сууц барих чиглэлээр хувийн хөрөнгө оруулалтыг дэмжиж, төсөл хөтөлбөрт хамруулахыг дэмжих;

2.9.3.2 Орон нутагт барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлж, барилгын ханын материалын үйлдвэрлэлийг түлхүү дэмжих;

2.9.3.3 Инженерийн шугам сүлжээнд холбогдоогүй орон сууцыг шугам сүлжээнд холбох, нөхцөлийг сайжруулах;

2.9.3.4 Хот төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дэд бүтцийг хот төлөвлөлтөд тусгах;

## **2.9.4 Тэргүүлэх зорилт: Гэр хорооллыг хөгжүүлэх**

### **Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

2.9.4.1 Гэр хорооллын байнгын суурьших хэсгээс түр суурьшлыг ялгаж, барилгажих цаг хугацааг оновчтой төлөвлөн, барилгажилтын бүсэд шилжүүлэх ажлыг ерөнхий төлөвлөгөөний дагуу зохион байгуулах;

2.9.4.2 Гэр хорооллын төлөвлөлтийг иргэдийн оролцоо, санаачлагын дагуу боловсронгуй болгох ажлыг зохион байгуулах;

2.9.4.3 Гэр хорооллыг цэвэр, бохир усны шугам сүлжээнд холбож, амины орон сууцнуудын нөхцөлийг сайжруулах;

2.9.4.4 Гэр хороололд агаар, ус, хөрсийг бага бохирдуулах халаалтын зуухыг бүрэн нэвтрүүлэх;

2.9.4.5 Ерөнхий төлөвлөгөөний дагуу зураг төслөөр баригдсан орон сууцны хороолол болон урьдчилан төлөвлөлтгүйгээр баригдсан гэр хорооллын хоорондын ялгааг багасгаж, орчин үеийн амины орон сууцны хотхон болгож хөгжүүлэх;

2.9.4.6 Урт хугацаанд гэр хороололыг сайжруулах чиглэлээр төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлж, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх;

**Гарах үр дүн:** Гэр хорооллыг орчин үеийн амины орон сууцны хотхон болгох.

**2.9.5 Тэргүүлэх зорилт: Дорноговь аймгийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлж, эдийн засаг, нийгмийн хөгжлийн томоохон төв болгох.**

**Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

2.9.5.1 Зах зээлийн нөхцөлд нийцүүлэн шинэчлэн боловсруулсан хот суурингуудын ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлэх;

2.9.5.2 Аймгийн төвийн цэвэрлэх байгууламжид техник, технологийн шинэчлэлт хийж, цэвэрлэгээний түвшинг сайжруулах, бага оврын цэвэрлэх байгууламжийг хэрэглэх арга хэмжээ авах;

2.9.5.3 Аймгийн төв талбай залуучуудын цэцэрлэгийн тохижилтыг сайжруулах;

2.9.5.4 Хотын гэрэлтүүлэг, гоёл чимэглэлийг өөрчлөн сайжруулах;

2.9.5.5 Нэрэмжит гудамж цэцэрлэг бий болгон тохижуулах;

2.9.5.6 Хотын ногоон байгууламжийг нэмэгдүүлж, төв гудамжинд гоёлын ургамлаар бүрэн цэцэгжүүлэн тарималжуулах;

2.9.5.7 Ногоон байгууламжийн услалтын систем, бохирын усыг эргүүлэн ашиглах технологи бий болгох;

2.9.5.8 Дорноговь аймгийн дурсгалт газруудыг сэргээх;

2.9.5.9 Хүн амын суурьшлын шинэ хорооллууд байгуулах арга хэмжээ авах;

2.9.5.10 Аймгийн үйлдвэрлэл, хэрэглээ, хүн амын өсөлттэй уялдуулан инженерийн дэд бүтцийн шувам сүлжээг өргөтгөн хөгжүүлэх зорилгоор тодорхой төслүүдийг боловсруулан хэрэгжүүлэх;

2.9.5.11 Бичил бүсийн төв, сумд, багийн төвүүдийг шинэчлэн тохижуулах хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж эхлэх;

2.9.5.12 Загвар суурин байгуулж, тохижуулах арга хэмжээ авах;

2.9.5.13 Гадна дотноос зорин ирэх жуулчид, аялагчдад зориулсан орон нутгийн онцлогийг харуулсан амралт, зугаалгын цогцолбор бүхий цэцэрлэгт хүрээлэн байгуулах

**Гарах үр дүн:** Аймгийн хүн ам тав тухтай ажиллаж амьдрах нөхцөл бололцоог хангасан, экологид ээлтэй, эдийн засгийн хувьд биеэ даасан, гадаад, дотоод харилцаа сайтай орчин үеийн хот байгуулалт хөгжинө.

**2.9.6 Тэргүүлэх зорилт: Газар ашиглалтыг сайжруулан, хот төлөвлөлтийн оновчтой бодлогыг хэрэгжүүлэх**

#### **Хэрэгжүүлэх үйл ажиллагаа**

2.9.6.1 Аймгийн холбогдох бодлогын бичиг баримтууд болон уул уурхайн ашиглалт,

экосистемийн өнөөгийн нөхцөл, цаашдын хандлага, бэлчээр ашиглалт, хүн амын суурьшилтай уялдуулан газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах;

2.9.6.2 Бүсийн сумдын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, бүсийн тулгуур хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх явцад тодотголыг оновчтой хийж, хэрэгжилтийг зохион байгуулах;

2.9.6.3 Тулгуур төвүүдийн кадастрын зураглалыг сайжруулах, газар өмчлөлийн бүртгэлийг сайжруулан үл хөдлөх хөрөнгийн бүртгэлд хамруулах;

2.9.6.4 Хотын оршин суугчдыг үерийн усны аюулаас хамгаалах зорилгоор үерийн даланг барьж байгуулах;

2.9.6.5 Аймгийн түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөцийг тогтоох, түүнийг ашиглах

Техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулахад хувийн хэвшлийн оролцоог чиглүүлэх;

2.9.6.6 Хот орчмын газар нутагт бэлчээрийн болон оршуулгын тусгай хэрэгцээний газрын

хуваарилалтыг хэтийн бодлоготой уялдуулан хийх;

**2.9.7 Тэргүүлэх зорилт: Хот байгуулалтын төлөвлөгөөний дагуу газар доорхи инженерийн байгууламж, автозамыг барих ажлыг хэрэгжүүлэх**

#### **Хэрэгжүүлэх үйл ажиллагаа**

2.9.7.1 Хот төлөвлөлтийн төлөвлөгөөний дагуу газар доорхи инженерийн байгууламжийг барьж байгуулах чиглэлээр төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх;

2.9.7.2 Хотын оршин суугчдын ахуйн болон ундны усны эх үүсвэрийг нэмэгдүүлэх, цэвэрлэх байгууламжийг шинэ технологи нэвтрүүлэн, барьж байгуулах;

2.9.7.3 Хотын төв доторхи автозамыг шинээр барих болон засвар шинэчлэлтийг хийж, хотын төв доторхи тоосжилтыг багасгах.

**2.9.8 Тэргүүлэх зорилт: Хотыг орон сууцжуулах замаар хүн амын орон сууцны нөхцөлийг сайжруулж, 2016 онд аймгийн хэмжээний хүн амын 20%-ийг, 2021 онд 60%-ийг орон сууцаар хангана.**

#### **Хэрэгжүүлэх үйл ажиллагаа**

2.9.8.1 Төвөлөгөөний дагуу орон сууцны зориулалтаар тусгагдсан газруудад дэд бүтцийг

байгуулах, орон сууц барих чиглэлээр хувийн хөрөнгө оруулалтыг дэмжиж, төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх;

2.9.8.2 Инженерийн шугам сүлжээнд холбогдоогүй орон сууцыг шугам сүлжээнд холбож,

нөхцөлийг сайжруулах;

2.9.8.3 Хот төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дэд бүтцийг хотын төлөвлөлтөд тусгах;

### **2.9.9 Тэргүүлэх зорилт: Нийтийн аж ахуйг хөгжүүлэх**

#### **Хэрэгжүүлэх үйл ажиллагаа**

2.9.9.1 Цэвэр ус, дулааны үнийг тэдгээрийг түгээх, үйлдвэрлэн гаргахад гарах зардлыг

санхүүжүүлж чадахуйц байлгахын тулд суурь үнийг чөлөөлөх;

2.9.9.2 Нийтийн аж ахуйн газрыг хувийн хэвшилд шилжүүлж, эдийн засгийн үр ашигтай, бие даасан өөрийгөө санхүүжүүлэх, ашгийн байгууллага болгох, сумдад салбарыг байгуулан өргөжүүлэх.

### **2.9.10 Тэргүүлэх зорилт: Хотын ногоон байгууламжийг бий болгож, хот орчмын эко системийг хамгаалах**

#### **Хэрэгжүүлэх үйл ажиллагаа**

2.9.10.1 Хотын ногоон байгууламжийг өргөтгөж, ойн зурвасуудыг байгуулах;

2.9.10.2 Бүсийн тулгуур төв болон бүсийн сумдад ойжуулалт, цэцэрлэгжүүлэлтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах аж ахуй нэгж, байгууллагын үйл ажиллагааг дэмжинэ;

2.9.10.3 Ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтийг хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр мэргэжлийн байгуулагыг ажиллуулна;

2.9.10.4 Хотын ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтийн услалтын системийг шинэчлэн засварлаж, өргөтгөн ашиглалт хамгаалалтыг сайжруулна;

### **2.9.11 Тэргүүлэх зорилт: Хотын хог хаягдлын менежментийг боловсронгуй болгох**

#### **Хэрэгжүүлэх үйл ажиллагаа**

2.9.11.1 Сумдад хог хаягдлыг ангилах, устгах үйл ажиллагааг явуулах аж ахуй нэгжийг дэмжинэ;

2.9.11.2 Хотын доторхи ил задгай хог хаягдыг бий болгосон аж ахуй нэгжид авах арга хэмжээг боловсруулан, мөрдөж хариуцлагыг тооцож ажиллана;

2.9.11.3 Хог хаягдлын хүний эрүүл мэндэд учруулах хор хөнөөлийг сурталчлах, иргэдийн мэдлэгийг дээшлүүлэх;

2.9.11.4 Төхижилт үйлчилгээний компаниудад хог хаягдлыг дахин боловсруулахад дэмжлэг үзүүлэх, хоёрдогч түүхий эд ашиглан үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний зах зээлийг идэвхижүүлэхэд дэмжлэг үзүүлнэ;



2.9.11.5 Хот суурин газарт байрлах үйлдвэр, уурхай, аж ахуйн нэгж байгууллагуудын гаргаж байгаа хог хаягдалд үнэлгээ өгч шаардлагатай тохиолдолд ахуйн хаягдлаас ялгаатай үнэ тогтооно.

#### **Гуравдугаар үе шат (2017-2021 он):**

**2.9.12 Тэргүүлэх чиглэл: Хот суурингийн газар ашиглалтыг сайжруулж, эд хөрөнгийн бүртгэлийн тогтолцоо, үйл ажиллагааг боловсронгуй болгоно**

##### **Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

2.9.12.1 Газрын шинэтгэлийг эрчимжүүлэх, эдийн засгийн эргэлтэд оруулах нөхцөлийг бүрдүүлнэ;

2.9.12.2 Газрын мониторингийн сүлжээ бий болгож, доройтолд орж эвдэрч, талхлагдсан газрыг нөхөн сэргээж сайжруулах хөтөлбөр, төслүүдийг боловсруулан хэрэгжүүлнэ;

**Гарах үр дүн:** 2013 онд нийт иргэдийн 40 хувь нь газар өмчлөн авсан байна. Газрын мониторингийн сүлжээ байгуулагдсан байна

**2.9.13 Тэргүүлэх чиглэл: Хот байгуулалтыг улам боловсронгуй болгож, барилгын шинэ нэр төрлийн бараа, хийцийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ**

##### **Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

2.9.13.1 Эдийн засаг, худалдааны чөлөөт бүсүүд, томоохон орд газрыг түшиглэн дэлхийн жишигт нийцсэн орчин үеийн хот, тосгодыг бий болгоно;

2.9.13.2 Чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, шинэ хот, тосгодын ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлнэ;

**Гарах үр дүн:** Бүсийн хөгжлийн тулгуур төв хотуудын ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний биелэлт 70 хувьд хүрсэн байна.

## **2.10 Сумдын бүсчилсэн хөгжил**

### **Үндэслэл буюу өнөөгийн байдал:**

#### **Сумдын бүсчилсэн хөгжил:**

Газар нутгийн байршил, байгалийн баялаг, ашигт малтмалын нөөц, эдийн засгийн тэргүүлэх чиглэлийн хөгжлийн ирээдүйн төлөв, хандлага, зам харилцаа, эрчим хүчний хангамж, одоогийн хоорондын харилцан уялдаа зэргийг харгалзан сумдыг дараахи бүсчлэлд хамааруулна.

<b>Бүсийн дугаар</b>	<b>Бүсийн төв</b>	<b>Бүсэд хамрагдах сумдын нэр</b>	<b>Бүсийн хөгжлийн тэргүүлэх чиглэлүүд</b>
<b>Нэгдүгээр бүс</b>	Сайншанд	Сайншанд, Өргөн, Мандах, Сайхандулаан, Алтанширээ, Дэлгэрэх	Аж үйлдвэр, боловсруулах үйлдвэр, тээвэр ложистик, аялал жуулчлал, шилмэл омгийн мал үржүүлэг, хүнс, газар тариалангийн бүс
<b>Хоёрдугаар бүс</b>	Айраг	Айраг, Даланжаргалан, Иххэт	Уул уурхайн олборлох, боловсруулах үйлдвэрлэл, тээвэр ложистик
<b>Гуравдугаар бүс</b>	Хөвсгөл	Хөвсгөл, Улаанбадрах, Хатанбулаг	Мал аж ахуй, Мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэл, тээвэр ложистик
<b>Дөрөвдүгээр бүс</b>	Замын-үүд	Замын-үүд, Эрдэнэ	Эдийн засгийн чөлөөт бүс, тээвэр ложистик

**Нэгдүгээр бүс:** Сайншанд хот нь Улаанбаатар хотоос 460 км, Замын-Үүд боомтоос 230 км, Ханги мандал боомтоос 250 км зайд оршдог, Олон улсын төмөр зам, агаарын шугам, төвийн эрчим хүчний системийн шугам, Монгол Улсын автозамын сүлжээний босоо тэнхлэг дайран өнгөрдөг аймгийн засаг захиргаа, үйлдвэрлэл, соёл гэгээрлийн төв хот юм. Монгол Улсын хөгжлийн ирээдүйн төлөв хандлага, газарзүйн байршил, дэд бүтцийн давуу талын хувьд томоохон байр суурь эзэлж, стратегийн томоохон ордуудын зангилаа хот болж байгааг нь үндэслэн Сайншанд аж үйлдвэрийн цогцолборын ажлын эхлэл тавигдаад байна. Цаашид аж үйлдвэрийн цогцолборыг түшиглэсэн хүн амын төвлөрөл бий болж, том хот бий болох, жижиг дунд үйлдвэрлэл хөгжих боломж бүрдээд байгаа юм. Мөн аймгийн Аялал жуулчлалын онцгой бүсийн үүрэг гүйцэтгэдгээрээ томоохон байр суурь эзэлнэ.

Энэ бүсэд хамрагдаж байгаа Өргөн сум нь дэд бүтцийн хувьд нэг тэнхлэг дээр оршиж, аж үйлдвэр, боловсруулах үйлдвэрлэлийн гол төв болж хөгжих боломжтой учир цаашид үйлдвэрлэлийн чиглэлээр харилцан уялдаатай хөгжүүлнэ.

Сайхандулаан, Мандах сумд нь барилгын материалын түүхий эдээр баялаг, Төмөр замын тээврийн талаар төрөөс баримтлах бодлогын “Шинэ төмөр” зам төслийн хүрээнд баригдах төмөр зам нь эдгээр сумын нутаг дэвсгэрийг дайран өнгөрч, бүтээн байгуулалтын ажлын гол түүхий эдийг хангах бааз суурь болж хөгжих боломжтой. Мөн энэ бүсэд орших Цагаан суваргын зэс молебдины орд үйлдвэрлэлээ эхлүүлж, бүсийн хөгжлийг дэмжиж ажиллах юм. Алтанширээ, Дэлгэрэх сумд нь шилмэл омгийн мал сүргийн тоо болон малын тоо толгой, бэлчээрийн нөөц, уур амьсгалын таатай байдлаар аймагтаа дээгүүр байр эзэлдэг

сумд юм. Иймд эдгээр сумдыг шилмэл омгийн мал сүргийн үржүүлэг, мал аж ахуйн бүтээгдэхүүн, хүнс газар тариалангийн салбарт хөгжүүлж, энэ төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл боловсруулалтын бүс нутаг болгон хөгжүүлэхэд тохиромжтой юм.

**Хоёрдугаар бүс:** Энэ бүсэд Айраг, Даланжаргалан, Иххэт сумд хамрагдах бөгөөд эдгээр сумдад аймгийн хэмжээний уул уурхайн олборлох үйлдвэрлэл, хайгуул ашиглалтын лицензийн тоо хэмжээгээр тэргүүлдэг бүс нутаг юм. Жонш, барилгын материалын түүхий эдийн нөөц, үйлдвэрлэлээр томоохон байр эзэлдэг учир олборлох, боловсруулах үйлдвэрлэл, тэр дундаа барилгын материалын үйлдвэрлэл хөгжүүлэх боломжтой. Энэ бүсэд байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэлийн технологийг дэмжиж, байгаль орчныг хамгаалахад онцгой анхаарах шаардлагатай. Монгол улсын босоо тэнхлэгийн авто зам, олон улсын төмөр зам зэрэг нь эдгээр сумдаар дайран өнгөрдөг нь томоохон давуу тал болж байгаа юм.

**Гуравдугаар бүс:** Хөвсгөл, Улаанбадрах, Хатанбулаг сумд нь малын тоо толгой, бэлчээрийн нөөц, байгаль цаг уурын харьцангуй таатай бүс нутагт оршдог учир малын гаралтай түүхий эдийн үйлдвэрлэл, аймгийн хүнсний бүтээгдэхүүний хангамжийг бүрдүүлэх гол бүс нутаг байна. Бүсийн төв нь Хөвсгөл сум байх бөгөөд Сайншанд- Ханги боомт, Хатанбулаг сум хүртэлх автозам Хөвсгөл сумаар дайрч өнгөрдөг учраас бүсийн төв болгон хөгжүүлэх боломжтой юм.

**Дөрөвдүгээр бүс:** Замын-үүд сум нь хилийн боомт хот бөгөөд Эдийн засгийн чөлөөт бүс байгуулах, тээвэр ложистикийн цогцолбор төв болон хөгжих боломжтой. Эрдэнэ сум нь автозамын босоо тэнхлэг дээр оршдог, Замын –үүд сумын эдийн засаг, жижиг дунд үйлдвэрлэлийн хэрэгцээг нөхөж, хамтдаа хөгжих боломж бүхий нутаг юм.

Аймгийн өрсөлдөх чадварыг сайжруулах бодлогын хүрээнд дотоодын эдийн засгийг бэхжүүлэх, олон тулгуурт эдийн засгийг хөгжүүлэх бодлогын хүрээнд сумдын бүсчлэлийн хөгжлийн тэргүүлэх чиглэлийг хэрэгжүүлэн ажиллах бөгөөд бүсийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээр эхний ээлжинд бусад бүсүүдийн хэрэгцээг хангаж, цаашид дотоод болон гадаадад экспортлох боломжийг эрэлхийлж ажиллана. Сумдын бүсчлэлийн бүсийн зөвлөл нь төвийн сумын Засаг даргын ажлын алба байхаар зохицуулагдана.

## **ГУРАВ. ХҮНИЙ БОЛОН НИЙГМИЙН ХӨГЖИЛ**

### **Бодлогын зорилго**

Хүн ам зүй, нийгмийн хөгжлийг хангах нь аймгийн иргэд, оршин суугчдын ажиллаж амьдрах, сурч боловсрох, эрүүл, таатай орчин нөхцөлийг бүрдүүлэх, ядуурал болон ажилгүйдлийг бууруулан, нийгэм эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангана.

### **3.1 Хүн амын өсөлтийг түргэтгэх, хүний хөгжлийг хангахад чиглэсэн бодлого**

**Өнөөгийн байдал:** 2010 оны жилийн эцэст 59.8 мянган байнгын оршин суугчтай болж 2009 оныхоос 3.6 хувиар, 2000 оны хүн амын тооллогоос 18.2 хувь буюу 9.2 мянган хүнээр өсөв. Аймгийн хүн амын тоо 2000 оны тооллогоос хойш жилд дундажаар 1,87 хувиар өсчээ.

Энэ нь 2008 оныхоос 3.8 хувиар, 2000 оны хүн амын тооллогоос 14.1 хувь буюу 7.1 мянган хүнээр өсч, аймгийн хүн амын тоо 2000 оны тооллогоос хойш

жилд дунджаар 1.48 хувиар өссөн. Төрөлтийн ерөнхий коэффициент улсын дундаж **25.1** байгаа бол манай аймагт 25.4 хувьтай, нас баралтын коэффициент улсын дундаж **5.7** байгаа бол манай аймагт 5.1 хувьтай байна.

2009 онд 1438 шинэ хүн мэндэлж, 289 хүн нас баржээ. Өмнөх онтой харьцуулбал төрсөн хүүхдийн тоо 12,4 хувь өсч, нас барсан хүний тоо 7,0 хувиар буурлаа. Төрсөн хүүхдийн хүйсийн харьцаа 107.2, нас барсан хүний хүйсийн харьцаа 127,6 байна. 1000 хүнд ногдох төрөлтөөрөө улсын дунджаас дээгүүр, нас баралтаараа улсын дунджаас доогуур эерэг үзүүлэлттэй байна.

Хүн амын тоогоороо эхний 5-д Сайншанд ( 20480), Замын-Үүд ( 12823), Айраг (3598), Хатанбулаг (2985), Даланжаргалан (2554) тус тус орж байна.

Хүн амын жилийн дундаж өсөлт Замын-Үүд суманд хамгийн өндөр байна. Тус сумын хүн амын тооны өсөлт 1995 оноос эрчимжиж 2000 оноос хойш жилд дунджаар 9.89 хувиар өсч 2009 оны эцэст 12.8 мянган байнгын оршин суугчтай болжээ. Алтанширээ, Иххэт, Мандах, Хатанбулаг сумаас бусад 10 сумын хүн амын тоо өссөн дүн гарч байна. 2008 оны эцэст 10 сумын хүн амын тоо өмнөх оноос буурч байсан бол 2009 оны эцэст 10 сумын хүн амын тоо өссөн эерэг дүн гарч байна.

### **3.1.1 Тэргүүлэх зорилт: Хүнийг бүх талаар хөгжүүлэхэд чиглэсэн орчинг бүрдүүлж, ахуйн таатай нөхцөлийг хангах бодлого**

#### **Хэрэгжүүлэх үйл ажиллагаа**

3.1.1.1 Их дээд сургууль төгссөн залуу боловсон хүчнийг ажлын байраар хангах, оршин амьдрах таатай нөхцлийг бүрдүүлэх;

3.1.1.2 Аймгийн хүн амын дундаж наслалтыг улсын дунджаас нэмэгдүүлэх;

3.1.1.3 Ажилгүй иргэдийг мэргэжил олгох, мэргэшүүлэх сургалтанд хамруулан мэргэжилтэй иргэдийн тоог нэмэгдүүлэх;

3.1.1.4 Нийгмийн эмзэг хэсгийн хүн амд хүргэх нийгмийн халамж, үйлчилгээний чанарыг сайжруулах;

3.1.1.5 “БИЗНЕС ИНКУБАТОР” төвөөр дамжуулан бизнес эрхлэгчдэд жижиг болон бичил бизнесийн тогтвортой үйл ажиллагаа эрхлэхэд нь дэмжлэг үзүүлж бойжуулах, маркетинг, менежмент, технологийн сургалтуудыг явуулах;

3.1.1.6 Соёл, боловсролын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, бүсийн тулгуур төвүүдэд мэдээллийн төв, номын сан, музейн үйл ажиллагааг тогтворжуулах;

3.1.1.7 Мэдээллийг хурдан шуурхай авах олон арга замуудыг нэвтрүүлж, иргэдийг цаг үетэйгээ зэрэгцэн амьдрахад дэмжлэг үзүүлэх;

3.1.1.8 Гэр бүл болон иргэд хамтран нийгэмд хорших маягаар хөдөлмөрлөх, өөрийгөө хөгжүүлэх санал санаачлагыг дэмжих;

3.1.1.9 Бие тамир, спортын нэгдсэн арга хэмжээг өргөн хүрээнд явуулж, бүх нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх бодлого баримтлах;

### **3.1.2 Тэргүүлэх зорилт: Хүн амын механик өсөлтийг тогтворжуулж, ердийн цэвэр өсөлтийг нэмэгдүүлэх бодлого**

#### **Хэрэгжүүлэх үйл ажиллагаа**

3.1.2.1 Төрөлтийг дэмжиж, нас баралтыг бууруулах замаар хүн амын ердийн цэвэр өсөлтийг нэмэгдүүлэн, аймгийн хүн амын жилийн дундаж өсөлтийг тодорхой хувиар нэмэгдүүлэх;

3.1.2.2 Үр хөндөлтийн эрсдэлийн талаарх мэдээллийг олон нийтэд хүргэж, сургалт сурталчилгааг өргөн хүрээнд зохион явуулах;

## 3.2 Жендерийн тэгш байдлыг хангах бодлого

**Өнөөгийн байдал:** 2000 оны хүн ам, орон сууцны тооллогоос хойш хүйсийн харьцаа 100 эмэгтэйд ногдох эрэгтэйчүүдийн тоо буурч байснаа 2007 оноос эхлэн нэмэгдэж, өмнөх оноосоо 0.8 пунктээр, 2008 онд 1,3 пунктээр, 2009 онд 0.4 пунктээр тус тус өсч 2009 онд 97.1 болжээ. Хүйсийн харьцааг насны бүлгээр аймгийн ерөнхий дүнгийн дундажтай харьцуулж үзвэл 15-24 насанд буурч, 25-аас дээш насанд өссөнөө 60 наснаас дээшлэх тутам буурч байна.

Эдгээр нь 15-24 насны бүлэгт цэргийн албанд татагддаг болон 60-аас дээш насны эрэгтэйчүүдийн нас баралт эмэгтэй хүйсийнхээс илүү байдгийг илэрхийлж байна. Нас барсан хүмүүсийн дотор эрэгтэйчүүдийн эзлэх хувь өмнөх оноос 7.2 пунктээр буурчээ. 2009 оны байдлаар 57733 хүн амын 28435 нь эрэгтэй, 29298 эмэгтэй байгаагаас 0-14 насанд 16678 хүүхдийн 8379 эрэгтэй, 8299 эмэгтэй байна. 15-64 насанд 39088 хүн амын 19291 эрэгтэй, 19797 эмэгтэй байна. 65-аас дээш насанд 1967 хүний 765 эрэгтэй, 1202 эмэгтэй байна. 2009 онд шинээр төрсөн хүүхэд 1438 байсны 744 эрэгтэй, 694 эмэгтэй байгаа бол нас баралтын 162 нь эрэгтэй, 127 эмэгтэй байна. Аймгийн хэмжээнд 100 хүн тутмын 49,2 нь эрэгтэй, 50.8 нь эмэгтэй байна.

### 3.2.1 Тэргүүлэх зорилт: Аймгийн хэмжээнд хүн амын хүйсийн харьцааг тэнцвэржүүлэх бодлого

#### Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

3.2.1.1 Гэр бүлийг хөгжүүлэхэд энэ чиглэлээр ажиллаж буй төрийн бус байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх;

3.2.1.2 Бүсийн хэмжээнд ажиллаж буй хувийн хэвшилтэй хамтран, иргэдийг ажилд авахад хүйсийн хувьд ялгаварлахгүй байх бодлогыг хэрэгжүүлэх;

3.2.1.3 Хүн амын хүйсийн харьцааг тэнцвэржүүлэх, тогтвортой харилцааг дэмжсэн бодлогыг хэрэгжүүлэх;

## 3.3 Гэр бүлийн хөгжлийн бодлого

**Өнөөгийн байдал:** Өрхийн тоо жил бүр нэмэгдэж байна. 2010 оны эцэст 17796 өрхтэй болж өмнөх оныхоос 3.6 хувиар буюу 626 өрхөөр нэмэгдэж, нэг өрхөд ногдох хүний тоо 3.4 болж урд онтой адил хэмжээнд байна.

Өрхүүдийг байршлаар нь авч үзвэл 2000 оны тооллогоор нийт өрхийн 49.4 хувь нь хотод 50.6 хувь нь хөдөөд амьдарч байсан бол 2010 онд 60.0 хувь нь аймгийн төвд, 40.0 хувь нь сумын төв, хөдөөд амьдарч байна. Тус аймгийн хот, хөдөөгийн өрх, хүн 60:40 харьцаатай байгааг хотжилттой холбон үзэх ёстой. Энэ үүднээс авч үзвэл Дорноговь аймаг хотожсон аймагт багтах онцлогтой байна.

Дорноговь аймагт 16 хүртэлх насны 4-өөс дээш хүүхэдтэй өрхийн тоо, 8-аас дээш ам бүлтэй өрхийн тоо 13.3-17.7 хувиар буурч, харин өндөр настай, ганц бие өрхийн тоо, өрх толгойлсон эмэгтэйчүүд (нөхөргүй), эрэгтэйчүүдийн (эхнэргүй) тоо 1.3-10.3 хувиар өсжээ.

2010 оны байдлаар аймгийн хэмжээнд 7828 хүн амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой байгаа нь нийт хүн амын 13 хувь эзэлж байгаа бөгөөд өмнөх онтой харьцуулахад 4 пунктаар буурсан үзүүлэлттэй байна.

### **3.3.1 Тэргүүлэх зорилт: Аймгийн хэмжээнд гэр бүлийн тогтвортой байдал, гэр бүлийн хөгжлийг нэмэгдүүлэх бодлого**

3.3.1.1 Өрх бүр тодорхой орлоготой байх эдийн засгийн орчныг бүрдүүлж, өрхийн сарын дундаж орлогыг 1.0 сая төгрөгөөс багагүй болгох бодлогыг хэрэгжүүлэх

3.3.1.2 Шинээр гэр бүл бологсад, нийт болон шинэ төрсөн хүүхэд, шинээр гурав дахь хүүхдээ төрүүлсэн гэр бүл, “Эхийн алдар” одонтой эх зэрэг нийгмийн тодорхой хэсэг, бүлэгт зориулсан хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх

3.3.1.3 Гэр бүлийн тогтвортой байдлын талаар залуу гэр бүлүүдэд хандсан сургалт сурталчилгаа явуулах

3.3.1.4 “Шинэ төмөр” зам барих, “Сайншанд” аж үйлдвэрийн цогцолбор байгуулах бүтээн байгуулалтын чиглэлээр ажиллахаар шилжин ирэгсдийг гэр бүлээрээ ажиллаж, амьдрах таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

## **3.4 Ядуурал, ажилгүйдлийг бууруулах бодлого**

### **Өнөөгийн байдал:**

Дорноговь аймаг 2010 оны эцэст 17796 өрхтэй болсон бөгөөд энэ нь өмнөх оныхоос 3.6 хувиар буюу 626 өрхөөр нэмэгдсэн ч нэг өрхөд ногдох хүний тоо өмнөх оны хэмжээнд буюу 3.36 байна.

Дорноговь аймагт 8-аас дээш ам бүлтэй өрхийн тоо, 16 хүртлэх насны 4-өөс дээш хүүхэдтэй өрхийн тоо буурч, харин өрх толгойлсон эмэгтэйчүүдийн, өндөр настай, ганц бие өрхийн тоо өсөх хандлагатай байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо 2023 болж өмнөх оныхоос 1.84 хувиар буурсан байна. Нийт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 10.4 хувийг 0-5 насны хүүхэд эзэлж байна. Өнчин хүүхдийн тоо 2010 онд 787 болж өнгөрсөн оноос 5.8 хувиар буурсан бөгөөд нийт өнчин хүүхдийн 6.5 хувь буюу 51 нь бүтэн өнчин, 93.5 хувь буюу 736 нь хагас өнчин хүүхдүүд байна.

Нийгмийн халамжийн сангаас ахмад настан, ХБИ-д үзүүлэх хөнгөлөлт болон халамжийн бусад үйлчилгээнд зориулан 925.8 сая төгрөг зарцуулсан байна. 2008 онтой харьцуулахад “Гэр бүлийн тухай” хуулийн 25-ын 5-д заасан хүүхдийн гэр бүлдээ авч асран хамгаалж байгаа иргэнд олгосон тэтгэмжийн хэмжээ 3.8 дахин, бүтэн өнчин хүүхэд асран хамгаалж харгалзан дэмжигчдэд олгосон тэтгэмжийн хэмжээ 2.7 дахин нэмэгдсэн байна. 2009 онд нийт 8924.3 сая төгрөгийг тэтгэвэр, тэтгэмжинд олгосон ба үүний дотор тэтгэврийн даатгалын сангаас 6222.4 сая төгрөг, тэтгэмжийн даатгалын сангаас 878.7 сая төгрөг, ҮОМШӨ-ний даатгалын сангаас 467.3 сая төгрөг, ажилгүйчүүдийн тэтгэмжийн сангаас 300.8 сая төгрөгийн тэтгэмж тус тус олгожээ.

Аймгийн хэмжээнд ажилгүйдэл, ядуурлыг бууруулахад чиглэсэн олон арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаа боловч ядуурал төдийлөн дорвитой буурахгүй байна. Ажилгүйдэл, ядуурлыг багасгахад аймгийн хөгжлийн давуу тал, нөөц боломжийг бүрэн ашиглаж, үйлдвэрлэл, үйлчилгээг бүх талаар дэмжин, ажлын байрыг олноор бий болгох, эдийн засгийн өсөлт, тэргүүлэх салбаруудын хөгжил, хөрөнгө оруулалтын арга хэмжээтэй нягт уялдсан хөдөлмөр эрхлэлтийн оновчтой бодлогыг

хэрэгжүүлж, байгалийн хүндрэл бэрхшээлээс үүсэн малгүй болсон иргэдийг малжуулах талаар шат, шатны байгууллагууд дорвитой арга хэмжээ хэрэгжүүлэх шаардлагатай байна.

2009 онд хөдөлмөрийн насны хүн амын тоо 37144, эдийн засгийн идэвхитэй хүн амын тоо 20722 болж, өмнөх онтой харьцуулбал хөдөлмөрийн насны хүн амын тоо 3.8 хувиар өссөн боловч эдийн засгийн идэвхитэй хүн амын тоо 0.3 хувиар буурсан үзүүлэлт гарчээ.

Ажиллагсадын 32.1 хувь нь хөдөө аж ахуйн салбарт ажиллагсад байгаа бол 11.0 хувь нь төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын даатгалын салбарт ажиллаж байна.

Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэст бүртгүүлсэн, ажил идэвхитэй хайж байгаа иргэдийн тоо 2009 оны жилийн эцэст 532 байгаа нь 2008 оны жилийн эцсийнхээс 65.2 хувь өсчээ. 2009 онд 1322 хүн шинээр бүртгүүлсэн ба бүртгэлтэй ажилгүй иргэдээс 956 хүн ажилд зуучлагдан орж, ажилгүй иргэний бүртгэлээс хасагджээ. Ажилд зуучлагдан орсон хүний тоо өнгөрсөн оноос 27,6 хувиар өссөн байна.

2009 онд аймгийн дүнгээр нийт 1043 ажлын байр шинээр бий болгосны 60.2 хувь нь байнгын ажлын байр байлаа. Шинээр бий болсон ажлын байрыг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар үзвэл уул уурхай олборлох аж үйлдвэрийн салбарт 35.7 бий болсон ажлын байр байна.

2008 онд шинээр бий болсон ажлын байрны бараг 4-ны 1 нь барилгын салбарт ноогдож байсан бол 2009 онд дийлэнхи нь аж үйлдвэрийн салбарт ногдож байна. МУ-ын хэмжээнд ажилгүйдлийн түвшин 2009 оны жилийн эцсийн байдлаар 11.6 хувьтай, үүний дотор Дорноговь аймагт 20.7 хувьтай байгаа нь улсын дунджаас 9.1 пунктээр дээгүүр байна.

Аймгийн хөдөлмөрийн насны нийт хүн амын 54.3 хувь нь ажиллагчид, 4.9 хувь хөдөлмөрийн чадаргүй хүн ам, 15.4 хувь өдрийн ангид суралцагчид, 23.9 хувь нь ажил эрхлээгүй хүн ам байна. 2009 оны байдлаар нийт ажиллагсадын 49.6 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, 22.5 хувь нь төрийн төсөвт байгууллагад, 15.2 хувь нь төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газарт, 12.0 хувь нь ХК, ХХК-д, 0.5 хувь нь хоршоонд, 0.3 хувь нь төрийн бус байгууллагад тус тус ажиллаж байна.

## **Ажилгүйдэл . ядуурлыг бууруулах стратегийн зорилтууд**

**3.4.1 Тэргүүлэх зорилт: Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх замаар ажилгүйдэл ядуурлыг бууруулж, нийгмийн хамгааллыг сайжруулах бодлого**

### **Хэрэгжүүлэх үйл ажиллагаа**

3.4.1.1 Бүсийн хөгжлийн давуу тал, нөөц боломжийг бүрэн ашиглаж, жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээг бүх талаар дэмжин ажлыг байрыг бий болгох

3.4.1.2 Ажилгүйдлийг бууруулах зорилтын хүрээнд 3500-аас доошгүй иргэдийг хөдөлмөрийн биржээр дамжуулан сул, чөлөөтэй ажлын байранд зуучлах

3.4.1.3 “Хувь хүнийг чадваржуулах” хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж, ажилгүй хүмүүсийг хэрэгцээт ажлын байранд дадлага хийлгэх замаар ирээдүйн чадварлаг боловсон хүчинг бэлтгэн, ажилгүйдлийг бууруулах

3.4.1.4 Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих болон аялал жуулчлалын нутгийн онцлогт бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх зорилгоор өрхийн гар урлалыг дэмжих хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ.

3.4.1.5 Аж үйлдвэрийн цогцолбор, түүнийг дагасан бизнесийг орон нутагт хөгжүүлэхэд хувийн хэвшлийг зохистой бодлогоор дэмжих

3.4.1.6 Эдийн засгийн өсөлт, тэргүүлэх салбаруудын хөгжил, хөрөнгө оруулалтын арга хэмжээтэй нягт уялдсан хөдөлмөр эрхлэлтийн оновчтой бодлогыг хэрэгжүүлэх замаар ядуурлыг бууруулах

### **3.4.2 Тэргүүлэх зорилт: Ядуу, нэн ядуу бүлэгт хамрагдах өрхийн тоог бууруулах бодлого**

#### **Хэрэгжүүлэх үйл ажиллагаа**

3.4.2.1 Зах зээлд эрэлт хэрэгцээ ихтэй мэргэжил эзэмшүүлэх сургалтуудыг зохион байгуулж, эдгээр сургалтуудад ядуу, нэн ядуу өрхүүдийг түлхүү хамруулна;

3.4.2.2 Суурь боловсролыг нөхөн эзэмшүүлэх замаар иргэдийг чадваржуулна;

3.4.2.3 Нийгмийн халамжийн тэтгэмж олгох шалгуурыг сайжруулж, халамж хүртэгсдийг илүү оновчтой тодорхойлох замаар зорилтот хэсэгт хүргэнэ;

3.4.2.4 Нийгмийн даатгал болон халамжийн сангаас олгох бүх төрлийн тэтгэвэр, тэтгэмжийг хугацаанд нь чирэгдэлгүй, бүрэн олгоно.

3.4.2.5 Ядуурлыг бууруулах чиглэлээр цогц, эрчимтэй арга хэмжээ авч хэрэгжүүлэн амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой айл өрхийн тоог бууруулна

3.4.2.6 Малгүй буюу цөөн малтай ядуу өрхийг малжуулах арга хэмжээ авна.

3.4.2.7 Нийтийг хамарсан ажил зохион байгуулж, давхардсан тоогоор нийгмийн эмзэг бүлгийн 1500 иргэнийг түр ажлын байраар хангана.

3.4.2.8 Ажилд зуулчлах үйлчилгээг эрчимжүүлж, ажилгүйчүүдийг бүртгэх бүртгэлийн нэгдсэн системийг аймгийн хэмжээнд боловсруулна;

3.4.2.9 “Төрөөс албан бус хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого”-ын хэрэгжилтийг эрчимжүүлж, албан бус хөдөлмөр эрхлэгчдийн нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн нөхцлийг сайжруулна;

3.4.2.10 Аймгийн хэмжээний нэн ядуу өрхүүдэд зориулан, өрхийн амьжиргааг дээшлүүлэх бизнес сургалтыг төрийн бус байгууллага болон мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулна;

3.4.2.11 Өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих зорилгоор “Өрхийг Чадавхижуулах” хөтөлбөр хэрэгжүүлж, банк болон санхүүгийн байгууллагаар дамжуулан хөнгөлттэй бичил зээлийг олгоно;

### **3.5 Боловсрол, соёлын хөгжлийн бодлого**

**Өнөөгийн байдал:** 2010-2011 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын 20 сургуульд 10940 сурагч, 23 цэцэрлэгт 2350 хүүхэд, МСҮТ-д 12 мэргэжлээр 401 оюутан шинээр элсүүлж нийт 843 оюутан сурагчтай, ЭМШУИС-д 5 мэргэжлээр 200 оюутан шинээр элсүүлж, нийт 950 оюутантайгаар хичээллэж байна.

Тус хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуулийн 12 жилийн сургалтын төлөвлөгөөгөөр 1-3-р анги, 11 жилийн сургалтын төлөвлөгөөгөөр 2-5-р анги, 7-11-р анги, шилжилтийн төлөвлөгөөгөөр 7-р ангийн сурагчид хичээллэж байна. Аймгийн хэмжээнд ЕБС-ийн 20 сургуульд 211 бага бүлгийн , 229 дунд



бүлгийн, 83 ахлах бүлгийн, 15 албан бус боловсролын нийтдээ 538 багш ажиллаж байна. Багшлах боловсон хүчний хангалт 99.2 хувьд хүрлээ.

Аймгийн соёл урлагийн байгууллагууд 2010 онд 12.1 мянган хүнд үйлчилж, 11.6 сая төгрөгийн орлого төвлөрүүлсэн. “Саран хөхөө” театр 114 удаагийн тоглолтоор 15.0 мянган хүнд үйлчилжээ. Музей сургалт судалгааны төв нь дотоод гадаадын 7023 иргэнд үзвэрийн үйлчилгээ үзүүлж 1571.3 мянган төгрөгийн орлого олсон байна.

Суралцагсадын тоо жил дараалан нэмэгдэж байгаа бөгөөд их дээд сургуульд суралцагсад, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд суралцагсад тогтмол өсч байгаа нь манай иргэд боловсролдоо илүү анхаарах болсон нь ажиглагдаж байна. 2010 оны байдлаар аймгийн хэмжээнд нийт ажиллагсдын 21.5 хувь нь дээд боловсролтой, 9.3 хувь нь тусгай мэргэжлийн бүрэн бус дээд, 12.4 хувь нь техник мэргэжлийн анхан шатны дээд, 20.7 хувь нь бүрэн дунд, 20.2 хувь нь бүрэн бус дунд, 10.7 хувь нь бага боловсролтой, 1.4 хувь нь боловсролгүй иргэд байна.

### **Боловсрол, соёлын түвшинг дээшлүүлэх стратегийн зорилтууд**

#### **3.5.1 Тэргүүлэх зорилт: Цэцэрлэг болон ерөнхий боловсролын сургуулиудын сургалтын орчныг сайжруулж, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх**

##### **Хэрэгжүүлэх үйл ажиллагаа**

3.5.1.1 Цэцэрлэгийн хамран сургалтыг өргөжүүлэх

3.5.1.2 Хөдөөгийн малчин айл өрхийн хүүхдэд зориулсан бусад хэлбэрийн сургалтын үйлчилгээг сайжруулах

3.5.1.3 Амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой нэн ядуу өрхийн бага насны хүүхдийн хамрагдалтыг нэмэгдүүлэх.

3.5.1.4 Хөгжлийн бэрхшээлтэй бага насны хүүхдийн нийгмийн үйлчилгээг өргөжүүлэх

3.5.1.5 Суурь боловсролын хамран сургалтын хүрээг нэмэгдүүлэх

3.5.1.6 Бага ангийн сурагчид, малчдын хүүхдэд боловсролын чанартай үйлчилгээ авах тэгш боломжийг нэмэгдүүлэх

3.5.1.7 Цэцэрлэгийн барилгын болон сургалтын материаллаг орчныг сайжруулах.

3.5.1.8 Сургуулийн өмнөх боловсролын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх.

3.5.1.9 Хувийн хэвшил, бусад сонирхлын бүлгүүдийг бага насны хүүхдийн сургалт хүмүүжлийн үйл ажиллагаа эрхлэхийг бодлогоор дэмжих

3.5.1.10 Багшлах боловсон хүчний чадавхийг бэхжүүлэх, хүүхдийн сурах эрмэлзлийг дээшлүүлэх замаар өрсөлдөх чадвар бүхий төгсөгчдийг бэлтгэх

3.5.1.11 Сургууль завсардалтыг бууруулах, эмзэг бүлгийн сурагчдыг завсардалтгүй сурахад нь дэмжлэг үзүүлэх

3.5.1.12 Ерөнхий боловсролын сургуулиудад “Үдийн цай” хөтөлбөрийг үргэлжлүүлэн “Өдрийн хоол” хөтөлбөр болгон өргөжүүлэх.

3.5.1.13 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд үзүүлэх боловсролын үйлчилгээг өргөжүүлж, боловсролд бүрэн хамруулах

#### **3.5.2 Тэргүүлэх зорилт: Боловсролын үйлчилгээг чанартай хүртээмжтэй хүргэн, соёл урлагийн байгууллагуудыг орчин үеийн стандартад нийцүүлэн өөрчлөн зохион байгуулах**

### **Хэрэгжүүлэх үйл ажиллагаа**

3.5.2.1 Сурган хүмүүжүүлэгч багш нарыг мэргэжил дээшлүүлэх сургалтанд тасралтгүй хамруулах бодлогыг орон нутагт хэрэгжүүлж ажиллах

3.5.2.2 Багшлах боловсон хүчний нийгмийн асуудлыг шийдвэрлэх, орон нутагт дутагдалтай орон тооноос шилжин ирж байгаа мэргэжлийн багш нарыг урамшуулах бодлого баримтлах

3.5.2.3 Сумын төвийн болон бичил бүсийн соёл урлагийн салбарын шинэчлэлийг өргөн хүрээнд хэрэгжүүлэх

3.5.2.4 Соёл урлагийг хөгжүүлж, соёлын өв уламжлалыг залгамжлагч авъяас билэгтнүүдийг дэмжиж өсвөр залуу үед өвлүүлэх бодлогыг хэрэгжүүлж ажиллах

3.5.2.5 Аймгийн төв номын санг орчин үеийн техник хэрэгслээр хангах, иргэдийн эрэлт хэрэгцээ шаардлагад нийцсэн шинэ номоор фондыг баяжуулах

3.5.2.6 Түүх соёлын дурсгалт зүйлс, музейн сан хөмрөгийг баяжуулж, түүхэн дурсгалт газрууд, археологи, палентологийн олдворуудыг бүртгэлжүүлэх, хадгалалт, хамгаалалтанд хяналт тавьж ажиллах

**3.5.3 Тэргүүлэх зорилт: Мэргэжлийн Сургалт Үйлдвэрлэлийн Төв, ЭМШУИС-ийн салбар сургуулийн сургалтын орчныг сайжруулан өргөтгөж, чухал шаардлагатай мэргэжлийн боловсон хүчинг бэлтгэх бодлого баримтлах**

### **Хэрэгжүүлэх үйл ажиллагаа**

3.5.3.1 Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн үйл ажиллагааг өргөжүүлж, үндэсний ажиллах хүчний эрэлтэд нийцсэн анги нээн, мэргэжилтэй ажиллах хүчнийг бэлтгэх

3.5.3.2 Таван толгой-Сайншандын төмөр зам шинээр баригдахтай холбогдуулан Төмөр замын мэргэжлийн ажилтан бэлтгэх, сургалт үйлдвэрлэлийн төв байгуулах үйл ажиллагааг дэмжих

3.5.3.3 Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн сургалтын чанарыг сайжруулах, хөдөлмөрийн зах зээл дэх мэргэжилтэй ажиллах хүчний хэрэгцээг хангах

3.5.3.4 Гадаад харилцааг хөгжүүлж, нийгмийн түншлэл бий болгох.

3.5.3.5 ЭМШУИС-ийн салбар сургуулийн материаллаг баазыг нэмэгдүүлж, өргөжүүлэх, багшлах боловсон хүчнийг мэргэжил боловсролоо дээшлүүлэхэд дэмжиж ажиллах.

3.5.3.6 ЭМШУИС-ын салбарыг түшиглэн судалгаа эрдэмж шинжилгээний төв бий болгох.

**3.5.4 Тэргүүлэх зорилт: Албан бус боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх бодлого**

### **Хэрэгжүүлэх үйл ажиллагаа**

3.5.4.1 Бичиг үсэг үл мэдэгч, шинээр бичиг үсэг тайлагдагсдад зориулсан албан бус боловсролын чанарыг сайжруулж, хамрагдагсдыг нэмэгдүүлэх

3.5.4.2 Насанд хүрэгчдэд амьдрах ухааны чиглэлээр тодорхой сургалтуудыг тасралтгүй явуулж, хамрах хүрээг өргөжүүлэх

3.5.4.3 Албан бус боловсролын болон насанд хүрэгчдийн боловсролын салбарын сургалтын агуулга, аргыг боловсронгуй болгож, сургалтын хэрэглэгдэхүүний хангамж, хүртээмжийг сайжруулах

## 3.6 Эрүүл мэндийн хөгжлийн бодлого

### Өнөөгийн байдал:

### Эмнэлгийн тусламж үйлчилгээ:

Дорноговь аймагт хоёрдогч шатлалын тусламж үйлчилгээг 2, эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг 16, уламжлалт анагаах ухааны чиглэлээр 1, эм ханган нийлүүлэх, эм зүйн тусламж үйлчилгээг 25, амбулаторийн үйлчилгээтэй 8 хувийн эмнэлэг, хилийн болон дотоодын цэргийн 3, төмөр замын 2 эмнэлэг, эмчлэх, сувилах, эм барих зөвшөөрөл бүхий 204 их эмч, эмч зүйч, 326 сувилагч тусгай мэргэжилтэн, 290 туслах ажилтан эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлж байна.

**Хүн ам зүйн зарим үзүүлэлт:** Дорноговь аймаг нь эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх хүрээний 17170 өрхийн 57733 хүн амтай ба үүнээс 0-1 насны хүүхэд 2.3% (1303), 1-15 насны хүүхэд 26.6% (15375), төрөх насны эмэгтэйчүүд 30.1% (17358), ахмад настан 4.6% -ыг тус тус эзэлж байна.

Нийт хүн амыг эрүүл мэндийн бүлгээр нь ангилан авч үзвэл:

- 1-р бүлгийн хүн ам 35760 буюу 61.9%
- 2-р бүлгийн хүн ам 12895 буюу 22.3%
- 3-р бүлгийн хүн ам 6181 буюу 10.7%
- 4-р бүлгийн хүн ам 1439 буюу 2.5%
- 5-р бүлгийн хүн ам 222 буюу 0.4%

Эндээс харахад нийт хүн амын 84.2% нь цоо эрүүл буюу эрүүл, 13.6% нь ээнэгшил бүхий, хагас ээнэгшилтэй, ээнэгшлээ алдсан архаг өвчтэй байна.

2010 онд нийт 1288 эх төрж, 1296 хүүхэд эсэн мэнд бойжиж байна. Сүүлийн 3 жилд аймгийн хүн амын төрөлтийн түвшин 1,19-2,34 пунктээр, цэвэр өсөлт 2,2-2,45 пунктээр тус тус өсч, хүн амын нас баралт 0,05-1,02 пунктээр буурсан байна.

Сүүлийн 5 жилийн байдлаас харахад тус аймагт 2005, 2007, 2009 онуудад эхийн эндэгдэл гараагүй боловч 100 000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдэл 2006 онд 104,5, 2008 онд 80,5 байгаа нь эндэгдэл тогтвортой буурахгүй байна гэсэн дүгнэлтэнд хүргэж байна.

1000 амьд төрөлтөнд ногдох нялхсын эндэгдэл 2005 онд 19.9 болж улсын дунджаас буурсан боловч 2006-2009 онуудад өсч, улсын дунджаас 1.6 промилоор өндөр байна. Нялхсын эндэгдлийн 70%-ийг 0-оос эхний 7 хоногтой нярайн эндэгдэл эзэлж байна.

### Хүн амын өвчлөлийн тэргүүлэх шалтгаан / 10 000 хүн амд /

1. амьсгалын тогтолцооны өвчин
2. шээс, бэлэгсийн тогтолцооны өвчин
3. хоол боловсруулах эрхтэний өвчин
4. цусны эрхтэн тогтолцооны өвчин
5. арьс, халимны өвчин

Хүн амын өвчлөл, эндэгдэлд ядуурал, ажилгүйдэл, иргэдийн эрүүл мэндээ хамгаалах мэдлэг, боловсрол хангалтгүй, эрүүл зан үйл төлөвшөөгүй, эрүүл мэнддээ анхаарал муу тавьдаг, архи тамхи, зохисгүй хооллолт, хүнсний аюулгүй

байдал, хөдөлгөөний хомсдол, нийгмийн бухимдал зэрэг хүчин зүйлүүд нөлөөлж байна. Цаашид бүх шатны эрүүл мэндийн байгууллагын материаллаг баазыг бэхжүүлж, хүний нөөцийн хангалт, багаж, тоног төхөөрөмжийн хангамжийг сайжруулж, зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнийг бууруулахад салбар хоорондын хамтын ажиллагааг бий болгож, хүн амын дунд эрүүл зан үйлийг төлөвшүүлэх мэдээлэл сургалт, сурталчилгааг шинэ шатанд гаргах шаардлага тавигдаж байна.

### **Нийгмийн эрүүл мэндийн үйл ажиллагааны өнөөгийн байдал**

Монгол Улс зах зээлийн эдийн засагт шилжсэн үеэс эхлэн эрүүл мэндийн салбарт нэгэн адил өөрчлөлт шинэчлэлт хийгдэж хүн амыг өвчилсний дараа эмчлэх бодлогоос илүү өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийг дэмжих чиглэлийн бодлогыг баримтлан, 2001 оны УИХ-ын 81 дүгээр тогтоолоор нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлогыг батлан гаргасныг хэрэгжүүлж ажиллаж байна.

Уг бодлогыг хэрэгжүүлэх чиглэлээр Монгол Улсын Засгийн газар болон ЭМЯ-аас батлан гаргасан 20 гаруй хөтөлбөр, стратегиудын хүрээнд аймгийн дэд хөтөлбөр, төлөвлөгөө, стратегиудийг боловсруулан, амжилттай хэрэгжүүлж байгаа.

Засгийн газрын 2002 оны 149 дугаар тогтоолоор НЭМ-ийн үндэсний зөвлөл, орон нутагт аймаг, суманд салбар зөвлөл байгуулагдснаар нийгмийн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах байгууллага, хамт олны оролцоог хангаж ажиллах болсон билээ. Мөн сумдын нийгмийн эрүүл мэндийн салбар зөвлөлүүдийг шинэчлэн, жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөтэй болгон үйл ажиллагааг тогтмолжуулж, хамтран ажиллаж байна. 2008 оноос эхлэн сум, өрхийн эмнэлэгт нийгмийн эрүүл мэндийн ажилтныг бие даасан орон тоогоор ажиллуулан, нийгмийн эрүүл мэндийн үйл ажиллагааг зохицуулан ажиллаж байна.

### **Халдварт өвчин ба орчны эрүүл мэнд:**

Халдварт өвчнийг эрт сэрэмжлүүлэх, хариу арга хэмжээний тогтолцоог нэвтрүүлж, нийгмийн эрүүл мэндийн томоохон арга хэмжээнүүдийг шат дараалан төлөвлөн хэрэгжүүлж байна. Орчны эрүүл мэнд үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг аймаг, орон нутгийн хэмжээнд зохион байгуулан мэргэжлийн боловсон хүчин ажиллаж байна.

Сүүлийн 5 жилд 10000 хүн амд ногдох халдварт өвчин улсын дундаж 33.8 байхад Дорноговь аймагт 49.7 байгаа ба тогтмол улсын дунджаас өндөр үзүүлэлттэй байгаа нь анхаарал татаж байна.

Нийт халдварт өвчний эхний 3 байранд

2. Бэлгийн замаар дамжих халдвар- 33%
3. Гэдэсний халдварт өвчин -31%
4. Амьсгалын цочмог халдвар -28%

### **Халдварт бус өвчин, биеийн тамир, чийрэгжилт:**

Халдварт бус өвчин тэдгээрийн эрсдэлт хүчин зүйлсийн хяналт тандалтыг сайжруулах, эрүүл мэндийг дэмжих замаар хүн амын дунд зонхилон тохиолдох халдварт бус өвчнөөс шалтгаалсан нас баралтыг бууруулах явдал юм.

Халдварт бус өвчин /зүрх судасны өвчин, чихрийн шижин, хорт хавдар, осол гэмтэл/ -өөс үүдэлтэй өвчлөлүүд дэлхий нийтийн хэмжээнд, манай улс аймгийн хэмжээнд ч өвчлөл нас баралтын тэргүүлэх шалтгаан болж байна.

## Халдварт бус өвчин 10000 хүн амд Дорноговь аймагт:

	Өвчний ангилалаар	Дорноговь аймагт	
		Өвчлөл	Нас баралт
1	Амьсгалын тогтолцооны эмгэг	841.3	34.1
2	Хоол шингээх тогтолцооны өвчин	555.9	6.3
3	Шээс бэлэгсийн тогтолцооны эмгэг Хорт хавдар	520.6	1.7
4	Цусны эргэлтийн тогтолцооны эмгэг	273.8	19.7
5	осол гэмтэл	147.3	11.2
6	Хавдар	14.4	10.0

Халдварт бус өвчнийг үүсгэгч эрсдэлт хүчин зүйлс болох зохисгүй хооллолт, хөдөлгөөний хомсдол, архи хэтрүүлэн хэрэглэх болон тамхины хэрэглээний тархалт хүн амын дунд буурахгүй байна. Иймд халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлс болох буруу хооллолт, хөдөлгөөний хомсдолыг бууруулах, суугаа ажил эрхэлдэг таргалалт илүүдэл жинтэй хүмүүсийг зөв зохистой хооллох, байнгын дасгал хөдөлгөөн хийж, эрүүл мэндээ хамгаалах арга зүйд сургах шаардлага байна.

Нийт сумдын 42.8 % нь чийрэгжилтийн өрөө тасалгаа, тоног төхөөрөмжгүй, 57.2 % нь тусгай чийрэгжилтийн өрөө тасалгаатай боловч тоног төхөөрөмж дутуу, үйл ажиллагаа тогтмолжоогүй байна.

2009 онд аймгийн хэмжээнд Бие бялдарын түвшин тогтоох сорил судалгаанд 7-64 насны 45171 хүн хамрагдах ёстойгоос 35716 хүн буюу 79% нь хамрагдсан байна. Үүнээс хангалттай 81.4 %, хангалтгүй 18.5 %-тай үнэлэгджээ.

Цаашид орон нутгийн хөгжил, хотжилт, хүн амын өсөлт, өвчлөлийн байдалтай уялдуулан бүх шатны эрүүл мэндийн байгууллагын бүтэц, зохион байгуулалт, удирдлага, мэдээллийн технологийг боловсронгуй болгох, эмнэлгийн тусламж үйлчилгээнд шинэ технологи, дэвшилтэт аргуудыг нэвтрүүлэх, орчин үеийн эмнэлгийн нэн шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах, үйлчлүүлэгчдэд ээлтэй орчин бүрдүүлж, эмнэлгүүдийн материаллаг баазыг бэхжүүлж, эмч мэргэжилтнүүдийн харилцаа хандлагыг сайжруулах, чадварлаг, мэргэшсэн боловсон хүчнээр хангах, санхүүжилтийг нэмэгдүүлэх, төсвийн зарцуулалт, үр ашгийг дээшлүүлэх, хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл зан үйл, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх, зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнийг бууруулахад улс, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх, салбар хоорондын уялдаа холбоо, хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилт тавьж байна.

### Эм зүй ба дэмжих үйлчилгээ

Өнөөгийн байдлаар эм хангамж, эмийн сангийн үйлчилгээг 25 байгууллага, 49 эм зүйч, эм найруулагч нар улсын бүртгэлд бүртгэгдсэн чанарын баталгаатай, аюулгүй эм, эмнэлгийн хэрэгслээр үйлчилж байна. Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах журмын тухай хууль болон бусад эрх зүйн орчны дагуу нэгдсэн эмнэлгүүд эмийн нээлттэй тендер зарлан явуулж хэрэгцээт эм эмнэлгийн хэрэгслээ тасралтгүй ханган ажиллаж байна.

Сумдад ажиллаж байсан эм эргэлтийн сангуудын үндсэн хөрөнгийг Төрийн өмчийн хороо, аймгийн ИТХ-ын тогтоол, шийдвэрээр орон нутгийн өмчид бүртгэж, сумдад салбар эмийн сантай “Эм эргэлтийн сан” ОНӨААТҮГ болгон байгуулж, хөдөөгийн хүн ам, эмнэлгүүдэд шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийг хууль, эрх зүйн орчны дагуу нээлттэй тендер зарлан, ханган нийлүүлэлт хийж байна. Энэ

нь хөдөөгийн хүн амыг зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслээр тасралтгүй хангаад зогсохгүй, эдийн засгийн үр өгөөжтэй байх юм.

### **Хүний нөөцийн хөгжил**

5. **Сум болон сум дундын эмнэлэгт:** Их эмч -35 /нийт эмчийн 19.6 %, бага эмч 12, багийн бага эмч -29, сувилагч -58, үүнээс бакалавр - 36, тусгай дунд мэргэжилтэн 18 ажиллаж байна.1 их эмчид дунджаар 747.5 хүн ноогдож байна.
6. **Өрхийн эмнэлэгт:** Их эмч –9, сувилагч –9 ажиллаж, 1 их эмчид дунджаар 1523 хүн ноогдож байна.
7. **Аймгийн нэгдсэн эмнэлэгт:** Их эмч – 40, эм зүйч – 1, бага эмч- 8 сувилагч – 50, тусгай дунд мэргэжилтэн-9, бусад ажилтан-65, 2 дахь шатны тусламж үйлчилгээг үзүүлж байна.
8. **Уламжлалт анагаах ухааны төв : их эмч -3, сувилагч-5, бусад дунд мэргэжилтэн-2 төрөлжсөн нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээг үзүүлж байна**
9. **Рашаан сувилал: их эмч2, сувилагч - 1**
10. **Хувийн эмнэлэгт** Их эмч – 12, сувилагч-5, тусгай дунд мэргэжилтэн-3 тус тус ажиллаж байна.
11. **Эм ханган нийлэх байгууллага, эмийн сан :** эмч зүйч -13, дунд мэргэжилтэн -36 эм ханган нийлүүлэх, эм зүйн тусламж үзүүлж байна.

Тус салбараас Монгол Улсын Хөдөлмөрийн баатар-1, Хүний гавьяат эмч 5 төрсөн ба одоо орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудад Хүний гавьяат эмч 2, анагаах ухааны доктор, профессор 1, анагаах ухааны магистр 7, клиникийн профессор 7, тэргүүлэх зэрэгтэй их эмч 8, ахлах зэрэгтэй их эмч 20, тэргүүлэх зэрэгтэй сувилагч, тусгай мэргэжилтэн 2, ахлах зэрэгтэй сувилагч, тусгай мэргэжилтэн 22 ажиллаж байгаа нь манай салбарын нэг чухал давуу тал болж байна. Цаашид мэргэжлийн зэргийг ахиулах, багаар ажиллах чадавхийг нэмэгдүүлэх, магистр, докторын зэрэг хамгаалах мэргэжилтэнд дэмжлэг үзүүлэх хэрэгцээ шаардлага байна.

**Эрүүл мэндийн санхүүжилт:** Аймгийн Эрүүл мэндийн салбарын хэмжээнд улсын төсвөөс 74%, ЭМД-ын сангаас 23%, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 2%-ийн санхүүжилт тус тус авдаг. Нийт төсвийн 65% нь цалин, урамшуулалд, 10.5% нь тогтмол зардалд, 7.6% нь эмийн зардалд, 3.9% нь хоолны зардалд, 2% нь НЭМ-ийн үйл ажиллагааны зардалд, 10% нь бусад зардалд тус тус ногдож байгаа нь эмчилгээ үйлчилгээний чанарыг сайжруулах, ялангуяа нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хөгжүүлж, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг өргөтгөх бололцоо хангалтгүй, тулгамдсан асуудлыг нэг болж байна.

2008 - 2010 онд улсын төсвөөр 1 927.8 сая төгрөг, орон нутгийн төсвөөр 190.1 сая төгрөг, төсөл хөтөлбөрүүдийн шугамаар 385.8 сая төгрөг, хандив тусламжаар 96.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалт тус тус хийгдэж, нэн шардлагатай тоног төхөөрөмжийн хангалт нэгдсэн эмнэлгүүдэд –97.5%, сум, сум дунд, өрхийн эмнэлгүүдэд – 80.5 %-д хүрсэн байна

Мөн ЭМД-ын санхүүжилт өсөн нэмэгдэж, хоёрдогч шатлалын эмнэлгийг өртөг ойролцоо оношийн бүлгээр санхүүжүүлж байна. Гэвч гэрийн болон өдрийн стационарийг анхан шатны эмнэлгүүдэд ажиллуулахгүй, түүнд зориулсан санхүүжилтийг тооцохгүй байгаа нь хоёрдогч шатлалын тусламж үйлчилгээний ачааллыг нэмэгдүүлэх, эмзэг, ядуу бүлгийн иргэдэд тусламж үйлчилгээг жигд хүртээмжтэй үзүүлэхэд сөргөөр нөлөөлж байна. Түүнчлэн өрхийн эмнэлгийн 1

иргэнд ногдох санхүүжилтийн хэмжээг өсгөхгүй байгаагаас өрхийн эмнэлгүүд нийт төсвийнхөө 80%-ийг цалин шимтгэлд, 10 хувийг тогтмол зардалд, үлдсэн 10 хувийг нийгмийн болон эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээндээ зарцуулж байна. Энэ нь өрхийн эмнэлгийг хэвийн үйл ажиллагааг хангахгүй төдийгүй, тэнд ажиллах эмч мэргэжилтнүүдийн дутагдал үүсэх, иргэдийн дунд нэр хүнд нь буурах нөхцөл болсоор байна

### **Эрүүл мэндийн салбарын дотоод гадаад орчны шинжилгээ**

#### **Давуу тал:**

- Эмнэлгүүд 100% магадлан итгэмжлэлд хамрагдаж, мэргэжлийн боловсон хүчнээр хангагдаж, хөдөөгийн багийн түвшинд их эмчийн тусламжийг үзүүлж эхэлсэн .
- Эхийн эндэгдлийг бууруулах стратеги, ХӨЦМ хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүлж, аймгийн болон Замын үүдийн нэгдсэн эмнэлгүүдийн эх барих эмэгтэйчүүдийн эмчийн орон тоог нэмэгдүүлж, хөдөөгийн эмнэлгүүдийн 46,8% нь хүүхдийн нарийн мэргэжлийн эмчтэй болж эх, нялхсын эндэгдэл буурч байна.
- Сумдын эмнэлгийн 92.8% нь эрчим хүчний эх үүсвэртэй болж, 35.7% нь төвлөрсөн ус, дулааны хангамжид холбогдож, эмнэлгүүд 100% зориулалтын байртай болж, 88.9 хувьд нь их засвар хийгдсэн.
- Түргэн тусламжийн автомашины парк шинэчлэлт 81.3 хувьд хүрсэн.
- Бүх сумд цахилгаан холбооны болон үүрэн телефоны сүлжээнд холбогдож, эмнэлгүүд компьютер, техник хэрэгслээр бүрэн хангагдсан ба 52,6 % нь интернет ашигладаг болсон .
- Аймгийн Нэгдсэн эмнэлгийн тоног төхөөрөмжийн хангалт 97.5%-д хүрсэн
- Төсөл хөтөлбөрт хамрагдан олон улсын хамтрагч талуудын зүгээс үзүүлэх санхүүгийн болон аргагүйн зохистой дэмжлэг бий болсон.
- Дархлаажуулалтын үйл ажиллагаа тогтмолжиж, хамралт сайжирснаар дархлаажуулалттай халдварт өвчин бүртгэгдээгүй, халдварт өвчнийг эрт сэрэмжлүүлэх хариу арга хэмжээний тогтолцоог шинээр нэвтрүүлж, үйл ажиллагаа нь тогтмолжсон.
- Замын-Үүдийн нэгдсэн эмнэлгийн халдвартын тусламж, үйлчилгээг бэхжүүлж, мэргэжлийн эмч, лабораторийн эмч, лаборанттай болгож, 10 ортой халдвартын эмнэлгийг барилгыг бариулж байна
- Хөдөөгийн эмнэлгүүд лабораторийн багаж хэрэгсэл, лаборантаар 100% хангагдаж, 61,5% нь ЭХО оношлогоо хийх боломжтой болсон
- Явуулын амбулаторийн үзлэгийг жил бүр зохион байгуулж, хүн амын дундах өвчлөлийг эрт илрүүлэн, эмчлэн эрүүлжүүлэх ажлыг зохион байгуулж хэвшсэн.

#### **Сул тал:**

- Эрүүл мэндийн анхан шатны, нарийн мэргэжлийн зарим тусламжийн чанар хүртээмж шаардлагын хэмжээнд хүрэхгүй байна
- Хүн амын тоо жилээс жилд нэмэгдэж байгаа хэдий ч эрүүл мэндийн байгууллагуудын бүтэц, орон тоо нэмэгдэхгүй байгаа нь эмч, эмнэлгийн мэргэжилтний ачааллыг ихэсгэж байна
- Эмч, эмнэлгийн мэргэжилтний нас залуужиж, мэргэжлийн дадлага, туршлагатай эмч нарын тоо цөөрсөн
- Эмнэлгүүдийн төсөв хүрэлцээгүй, нийгмийн эрүүл мэндийн үйл ажиллагааны санхүүжилт хангалтгүй
- Халдвар өвчин тууштай буурахгүй, халдвар өвчинтэй тэмцэх байгууллага, тасаг нэгж, эмч мэргэжилтний тоо цөөн

- Эрсдэлт бүлгийн жирэмсэн эхчүүдийг эрүүлжүүлэх үйл ажиллагаа тогтмолжоогүй
- Сум, өрхийн түвшинд Нөхөн үржихүйн эрүүл мэндийн сургалт сурталчилгааны чанар тааруу, зорилтод бүлэгт чиглэгдсэн хэрэгцээт мэдээлэл хангалтгүй, хүн амын дунд эрүүл аж төрөх зан үйл төлөвшөөгүй
- Сум, өрхийн эмнэлгийн түвшинд нийгмийн эрүүл мэндийн ажилтнуудад халдварт бус өвчний эрсдэлийг тодорхойлох багаж хэрэгсэл хангалтгүй /сахар тодорхойлогч, жин хэмжүүр/
- Хөдөлгөөн биеийн тамир, нөхөн сэргээх эмчилгээ хангалттай бус, биеийн тамир чийрэгжүүлэлтийн тоног төхөөрөмжийн хангалт дутмаг
- Хүн амын дунд архи, тамхины хэрэглээ өндөр
- Эрүүл мэндийн үйл ажиллагаанд бусад байгууллага, хамт олны оролцоо, дэмжлэг, хамтын ажиллагаа жигдрээгүй

#### **Боломж:**

- Хууль эрхзүйн орчин бүрдсэн
- Дэд бүтэц сайн хөгжсөн, зах зээлд ойр байрладаг
- Өмнөд бүсийн төмөр зам, хүнд үйлдвэрийн парк байгуулагдснаар гадаад, дотоод хандивлагчдын хөрөнгө оруулалт нэмэгдэнэ
- Ядуурал, ажилгүйдэл улс, аймгийн түвшингээс доогуур
- Төрийн болон ТББ, олон улсын төсөл хөтөлбөр хэрэгжүүлэгч байгууллагуудад санал тавьж, хамтран ажиллах боломжтой.
- ЭМШУИС-ийн салбар сургуультай бөгөөд энэ нь их эмч, баклавр зэрэгтэй сувилагч, бага эмч бэлтгэдэг
- Уул уурхай сайн хөгжсөн, өмнөд бүсийн төмөр зам, хүнд үйлдвэрлэл байгуулагдах болсон нь хүн амын тоо өсч, ажилгүйдэл ядуурал буурах, эрүүл мэндийн салбарт үзүүлэх дэмжлэг туслалцаа хамтын ажиллагаа нэмэгдэнэ
- Хөдөө орон нутгууд үүрэн телефоны бүх сүлжээтэй болсон, интернетд холбогдон мэдээллийг хурдан солилцох бололцоо бүрдсэн

#### **Эрсдэл /Бэрхшээл/:**

- Өмнөд бүсийн төмөр зам, хүнд үйлдвэрийн парк байгуулагдснаар хүн амын тоо өсч, эмнэлгийн тусламж үйлчилгээний хэрэгцээ нэмэгдэнэ
- Аймгийн хэмжээний нийт төрөлтийн 80% нь аймгийн нэгдсэн эмнэлэгт явагдаж байгаатай холбоотой төрөх тасгийн ачаалал ихэсч, байрны хүрэлцээ муудаж, эмнэлгээс шалтгаалсан халдвар гарах эрсдлийг үүсгэж байна
- Аймгийн нэгдсэн эмнэлгийн орчимд орон сууц, үйлдвэрлэл үйлчилгээний газрууд нэмэгдсэн нь эмнэлгийн бохир ус зайлуулах төхөөрөмжийн ачааллыг ихэсгэж, халдварт өвчин гарах эрсдэлийг бий болгож байна
- Замын-Үүдийн нэгдсэн эмнэлгийн халдварт өвчний үед үзүүлэх тусламж үйлчилгээний чанар, хүрэлцээ хангалтгүй байгаа нь шинэ болон дахин сэргэж байгаа халдварт өвчин импортлогдох эрсдлийг үүсгэж болзошгүй
- Чанарын баталгаагүй хүнсний бүтээгдэхүүн хилээр нэвтрэх боломжтой байгаагаас хоолны хордлого, гэдэсний халдварт өвчин гарах магадлал өндөртэй, ундны усны чанар, эрүүл ахуйн байдал хангалтгүй
- Эрүүл ахуйн мэргэжлийн боловсон хүчний хангалт сул, эрүүл зүйн лаборатори байхгүй
- Байнгын болон улирлын ажиллагаатай хилийн боомтууд ажилладаг нь хүн амын шилжилт, хөдөлгөөнийг нэмэгдүүлж, бүртгэл хяналтгүй хүн ам, хувиараа жонш олборлогчид олширч байгаа нь халдварт өвчин гарах, эмнэлгийн ачааллыг нэмэгдүүлэх эрсдлийг үүсгэж байна



- Чойр, Замын Үүдийн хатуу хучилттай зам тавигдаж эхэлснээр хүн амын хөдөлгөөн ихэсч, БЗДХ/ХДХВ/ДОХ, осол гэмтлийн шалтгаант өвчлөл, эндэгдэл ихсэх магадлалтай
- Өмнөд бүсийн төмөр зам Сайншанд хотоор дайран өнгөрч, хүнд үйлдвэрлэлийн бүс байгуулах нь орон нутгийн хүн ам нэмэгдэх, улмаар эмнэлгийн хүчин чадал хүрэлцэхгүй байх нөхцлийг үүсгэнэ

## Бүх үе шат (2011-2021 онд)

**3.6.1 Тэргүүлэх зорилт: Хүн ам ялангуяа эх хүүхэд, ядуу эмзэг бүлгийн иргэдэд хүрэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж хамралт ашиглалтыг нэмэгдүүлэх бодлого**

### **Хэрэгжүүлэх үйл ажиллагаа**

3.6.1.1 Хот суурин газрын хүн амд түргэн тусламжийн үр дүнтэй үйлчилгээг өвчтөн шилжүүлэх тогтолцоо болон эмнэлгийн яаралтай тусламжтай уялдуулан хүргэх;

3.6.1.2 Алслагдсан хөдөө орон нутгийн хүн амд түргэн тусламжийн үр дүнтэй чанартай үйлчилгээг яаралтай тусламж болон лавлагаат, өвчтөн шилжүүлэх тогтолцоотой уялдуулан цаг алдалгүй хүргэх;

3.6.1.3 Үйлчлүүлэгчид ээлтэй хөтөч үйлчилгээний тогтолцоог бий болгож нэвтрүүлэх;

3.6.1.4 Тусламж үйлчилгээний нэн шаардлагатай болон нэмэлт багц ба үндэсний хөтөлбөрүүдэд тулгуурлан өвчтөнг эмнэлэгт хэвтүүлэлгүйгээр, үйлчлүүлэгчид хүрч үйлчлэх тасралтгүй тогтвортой тогтолцоог олон нийт, өрхийн түвшинд бүрдүүлэх;

3.6.1.5 Нийгмийн эрүүл мэндийн болон анхан шатны эрүүл мэндийн үйл ажиллагаанд сайн дурын ажилтныг оролцуулан, олон нийтийн үүсгэл санаачлагыг өрнүүлж, оролцоог дэмжиж тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх;

**3.6.2 Тэргүүлэх зорилт: Тусламж үйлчилгээний нэн шаардлагатай болон нэмэлт багцын дагуу сум, өрхийн эрүүл мэндийн байгууллагаар хүргэх анхан шатны болон ерөнхий мэргэжлийн чанартай тусламж үйлчилгээг бэхжүүлэх бодлого**

### **Хэрэгжүүлэх үйл ажиллагаа**

3.6.2.1 Хүн амд Тусламж үйлчилгээний нэн шаардлагатай болон нэмэлт багцыг /ТҮНШБ/ тогтвортой хүргэх зорилгоор сум өрхийн эмнэлгийн тусламж үйлчилгээг өөрчлөн зохион байгуулах, үйл ажиллагааг тогтворжуулах

3.6.2.2 Өрх гэр бүл, хамт олон, сайн дурын ажилтны оролцоотойгоор хүн ам, ялангуяа ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүргэх сум, өрхийн эмнэлгийн нийтийн биеийн тамирын үйл ажиллагааг дэмжиж ажиллах

3.6.2.3 Сум, өрхийн эмнэлгийн тусламж үйлчилгээнд үндэсний хөтөлбөрийн холбогдох үйл ажиллагааг уялдуулах

**3.6.3 Тэргүүлэх зорилт: Тусламж үйлчилгээний нэмэлт багцын дагуу хоёрдогч шатлалын эрүүл мэндийн байгууллагын чанартай, төрөлжсөн нарийн мэргэжлийн болон яаралтай тусламж үйлчилгээг бэхжүүлэх бодлого**

### **Хэрэгжүүлэх үйл ажиллагаа**

3.6.3.1 Аймгийн Нэгдсэн эмнэлгийг өндөр технологи бүхий оношлогоо, эмчилгээний жишиг төв болгон өргөжүүлж, үйл ажиллагааг нь жигдрүүлэх;

3.6.3.2 Аймгийн Нэгдсэн эмнэлэгт тусламж үйлчилгээний нэмэлт багцыг нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээтэй уялдуулан хэрэгжүүлж, үр дүнг нь тооцон ажиллах;

3.6.3.3 Яаралтай тусламжийн тогтолцоог түргэн тусламжийн үр дүнтэй үйлчилгээ болон өвчтөн шилжүүлэх шинэчлэгдсэн тогтолцоотой уялдуулан эрүүл мэндийн тусламж үйлчилгээний бүх шатлалд шинэчлэн зохион байгуулах;

3.6.3.4 Хоёрдогч шатлалын эрүүл мэндийн байгууллагаар тусламж үйлчилгээний батлагдсан бүрдлийг тогтвортой хүргүүлэх, Эмнэлгийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх;

3.6.3.5 Олон нийтийн ба төрийн бус байгууллагын албан ёсны харилцаа болон олон нийтийн хүлээн зөвшөөрөгдөхүйц төлөөллөөр эмнэлгийн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг бэхжүүлэх;

3.6.3.6 Хоёрдогч шатлалын болон хувийн хэвшлийн эмнэлгүүдээр үзүүлэх тусламж үйлчилгээнд Нийгмийн эрүүл мэндийн үндэсний хөтөлбөрүүдийн холбогдох үйл ажиллагааг нэгтгэн уялдуулах;

3.6.3.7 Уламжлалт анагаах ухаан болон хөнгөвчлөх тусламж үйлчилгээний хамралт хүртээмжийг нэмэгдүүлэх;

3.6.3.8 Өдрийн болон гэрээр үзүүлэх, хөнгөвчлөх тусламж үйлчилгээг шинэчлэн хөгжүүлэх;

**3.6.4 Тэргүүлэх зорилт: Хүн амыг зайлшгүй шаардлагатай эм биобэлдмэлээр жигд, хүртээмжтэй, тасралтгүй хангах, зохистой хэрэглээг төлөвшүүлэх, эм биобэлдмэл, цус, цусан бүтээгдэхүүний чанарын батлагааг хангах бодлогыг хэрэгжүүлэх**

#### **Хэрэгжүүлэх үйл ажиллагаа**

3.6.4.1 Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль тогтоомжийг сурталчлан хэрэгжүүлэх;

3.6.4.2 Улсын бүртгэлд бүртгэгдсэн чанарын баталгаатай эм, эмнэлгийн хэрэгслээр бүх шатны эмнэлгүүд, хүн амыг тасралтгүй хангах;

3.6.4.3 Эм биобэлдмэл, цус цусан бүтээгдэхүүний чанарын баталгааг хангах тогтолцоо бий болгох;

3.6.4.4 Эм, биобэлдмэлийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх;

3.6.4.5 Салбарын хэмжээнд эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх, эмийн гаж нөлөөг, бүртгэх мэдээлэх

**3.6.5 Тэргүүлэх зорилт: Эмнэлгийн шаардлагатай тоног төхөөрөмжийн байнгын нийлүүлэлт, засвар үйлчилгээг хангах тогтолцоо бий болгох замаар оношлогооны чадавхийг сайжруулах бодлого**

3.6.5.1 Эмнэлгийн багаж, тоног төхөөрөмжийн хангалт, ашиглалтыг нэмэгдүүлж, шинэ техник технологийг нэвтрүүлэн үйл ажиллагааг чанаржуулах

3.6.5.2 Инженер, техникийн ажилтныг мэргэшүүлэн сургах, шинэ техник, технологийн талаарх мэдлэг, чадвартай боловсон хүчнийг бэлтгэх;

3.6.5.3 Аймгийн нэгдсэн эмнэлгийг оношлогоо, эмчилгээний жишиг төв болгон өргөжүүлж, компьютерын томографи, өндөр технологи бүхий ЭХО

аппарат зэрэг орчин үеийн өндөр технологи бүхий оношлогооны техник, хэрэгслэлээр хангах;

### **3.6.6 Тэргүүлэх зорилт: Эрүүл мэндийн салбарын хэмжээнд дэд бүтэц, барилгын засвар үйлчилгээ, тээвэр харилцаа холбооны үйл ажиллагааг тогтмолжуулах бодлого**

3.6.6.1 Эрүүл мэндийн байгууллагуудын тээврийн хэрэгсэл, дэд бүтэц, барилга байгууламжийг шинэчлэх, засварлах үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулах;

3.6.6.2 Эрүүл мэндийн байгууллагуудын хог хаягдлын менежментийг сайжруулах;

3.6.6.3 Цахим эмнэлгийг хөгжүүлэх, интернетийн ашиглалтыг нэмэгдүүлэх;

### **3.6.7 Тэргүүлэх зорилт: Хүн амын зан үйлийг өөрчлөх, эрүүл аж төрөх ёсыг хэвшүүлэх, улмаар зонхилон тохиолдох халдварт, халдварт бус өвчлөлийг бууруулахад чиглэсэн мэдээлэл сургалт сурталчилгааны үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангах бодлого**

#### **Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

3.6.7.1 Мэдээлэл, сургалт сурталчилгааны үйл ажиллагааг Нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого болон мэдээлэл сургалт сурталчилгааны стратегитай уялдуулах;

3.6.7.2 Мэдээлэл, сургалт сурталчилгааны үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг нэмэгдүүлэх, зарцуулалтын үр ашгийг сайжруулах;

3.6.7.3 Мэдээлэл, сургалт сурталчилгааны мэдээний санг ашиглан оролцогч талуудын сүлжээ бий болгох замаар мэдээллийг цуглуулах, уялдуулах, түгээх үйл ажиллагааг хэрэгжүүлэх;

3.6.7.4 Төрийн ба төрийн бус байгууллагын зүгээс хэрэгжүүлж буй хүн амын эрүүл бус эрсдэлтэй зан үйлийг өөрчлөх үйл ажиллагаанд олон нийтийн мэдээллийн хэрэгслийн ашиглалтыг нэмэгдүүлэх үр дүнтэй механизмыг бий болгож хэрэгжүүлэх;

### **3.6.8 Тэргүүлэх зорилт: Үйлчлүүлэгчдэд ээлтэй, эрүүл мэндийг дэмжсэн тусламж үйлчилгээ бий болгох бодлого**

#### **Хэрэгжүүлэх үйл ажиллагаа**

3.6.8.1 Эмнэлгийн тусламж хайх, эрүүл мэндийг хамгаалах мэдлэг олгох боломж бүрдүүлэн, Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх ээлтэй, дэмжлэгт орчин бүрдүүлэх;

3.6.8.2 Эрүүл мэндийн байгууллагын түвшинд үйлчилгээ үзүүлэгчийн хандлага, ур чадварыг сайжруулах тогтмол хяналтын механизмыг бүрдүүлэх;

### **3.6.9 Тэргүүлэх зорилт: Олон нийтийн оролцоо, салбар хоорондын хамтын ажиллагааг сайжруулах замаар эрүүл мэндийг дэмжих орчин бий болох зорилтууд:**

#### **Хэрэгжүүлэх үйл ажиллагаа**

3.6.9.1 Эрүүл хот, сум, баг, ажлын байр, сургууль болох болзлыг хэрэгжүүлэх;

3.6.9.2 Орчны эрүүл мэндийн чиглэлээр төсөл, хөтөлбөрүүд боловсруулж, салбар дундын хамтын ажиллагаа, олон нийтийн оролцоог ханган хэрэгжилтийг зохион байгуулах, үр дүнг нь тооцох;

**3.6.10 Тэргүүлэх зорилт: Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарыг орон нутгийн хэмжээнд тасралтгүй сайжруулах бодлого**

#### **Хэрэгжүүлэх үйл ажиллагаа**

3.6.10.1 Тусламж үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулах шинэчлэгдсэн хууль эрх зүйн актуудыг эрүүл мэндийн байгууллагуудад мөрдүүлэх

3.6.10.2 Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын удирдлага, хяналтын тогтолцоог салбарын хэмжээнд тасралтгүй бэхжүүлэх

3.6.10.3 Чанарын баталгааг хангасан үйлчилгээг нэвтрүүлэх дэмжлэгт орчин бүрдүүлэх

**3.6.11 Тэргүүлэх зорилт: Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний стандарт, шалгуур үзүүлэлтийг оновчтой болгох бодлого**

#### **Хэрэгжүүлэх үйл ажиллагаа**

3.6.11.1 Тусламж үйлчилгээний стандарт, эмнэлзүйн удирдамж, чанарын болон гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүдийг боловсронгуй болгож мөрдүүлэх

**3.6.12 Тэргүүлэх зорилт: Хүний нөөцийн хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлж, хүний нөөцийн менежментийг боловсронгуй болгох, мэргэжлийн ур чадвар, ёс зүйн харилцаа хандлагыг хэрэгжүүлэх бодлого**

#### **Хэрэгжүүлэх үйл ажиллагаа**

3.6.12.1 Эрүүл мэндийн байгууллагуудыг мэргэжлийн боловсон хүчнээр хангах бодлого хэрэгжүүлж ажиллах;

3.6.12.2 Мэргэжлийн өндөр ур чадвартай үүрэг хариуцлагаа ухамсарласан, ёс зүйг дээдэлсэн эмнэлгийн мэргэжилтнүүдийг төлөвшүүлэх, чадавхижуулах;

3.6.12.3 Салбарын хэмжээнд үйлчлүүлэгч төвтэй, үйлчлүүлэгчид ээлтэй тусламж үйлчилгээ бий болгох үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу эрүүл мэндийн банкуудад өргөдөл гомдлын ил, тод хяналтын тогтолцоог хэрэгжүүлэх;

3.6.12.4 Нэгдсэн эмнэлгүүдийн орон тоо, хүний нөөцийн хангамжийг нэмэгдүүлж, шаардлагатай мэргэжлийн эмч, мэргэжилтнүүдээр тасралтгүй хангах

**3.6.13 Тэргүүлэх зорилт: Эрүүл мэндийн байгууллагуудын мэргэжлийн боловсон хүчнийг мэргэжил олгох, дээшлүүлэх сургалтанд үе шаттай хамруулах, эмчлэх, сувилах, эм барих үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийн хэрэгжилт, эмнэлгийн ажилтан албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх бодлого**

#### **Хэрэгжүүлэх үйл ажиллагаа**

3.6.13.1 Төгсөлтийн дараах болон ажлын байрны тасралтгүй сургалтын тогтолцоог бий болгох, мэргэжлийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх

3.6.13.2 Нэгдсэн эмнэлгүүдийн эмч, мэргэжилтнүүдийг гадаад, дотоодын сургалтанд хамруулах, туршлага судлуулах, мэргэшүүлэх

**3.6.14 Тэргүүлэх зорилт: Эрүүл мэндийн салбарт ажиллагсдын нийгмийн баталгааг сайжруулах, урамшууллын тогтолцоог боловсронгуй болгох бодлого**

#### **Хэрэгжүүлэх үйл ажиллагаа**

3.6.14.1 Орон нутгийн дэмжлэг бүхий урамшууллын тогтолцоог нэвтрүүлж, эмнэлгийн ажилтан, албан хаагчдын шилжилт хөдөлгөөнийг хянаж, нийгмийн асуудлыг шийдвэрлэх арга хэмжээ авах

3.6.14.2 Эрүүл мэндийн ажилтныг хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн хүлээн зөвшөөрөгдсөн тохиромжтой нөхцөлөөр хангах

**3.6.15 Тэргүүлэх зорилт: Эрүүл мэндийн салбарт чиглэсэн санхүүгийн урсгалын тогтвортой байдлыг хангах, санхүүгийн удирдлагыг бэхжүүлэн, даатгалын тогтолцоог шинэчлэх бодлого**

#### **Хэрэгжүүлэх үйл ажиллагаа**

3.6.15.1 Улсын төсвөөс санхүүжүүлж буй анхан, хоёрдогч шатлалын тусламж үйлчилгээг оновчтой зохион байгуулж, санхүүжилтийн зөв хуваарилалтын нөхцөлийг бүрдүүлж ажиллах

3.6.15.2 Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагаар зарим тусламж үйлчилгээг гүйцэтгүүлэх замаар төрийн эрүүл мэндийн байгууллагын төсвийг нэмэгдүүлэх

3.6.15.3 Оношлогоо, эмчилгээний жишиг төв байгуулагдахтай холбогдуулж нэгдсэн эмнэлгийн төсөв, санхүүг нэмэгдүүлэх

3.6.15.4 Өндөр технологи бүхий багаж тоног төхөөрөмжтэй, өндөр түвшний мэргэшсэн боловсон хүчин бүхий хувийн хэвшлийн эмнэлэг, оношлогоо, эмчилгээний төвүүдийг дэмжих замаар санхүү, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх

3.6.15.5 Эрүүл мэндийн салбарын санхүүгийн болон холбогдох нөөцийн ашиглалтын үр дүн, үр ашгийг сайжруулах зорилгоор санхүүгийн удирдлагын тогтолцоог бэхжүүлэх

3.6.15.6 Орон нутагт хуваарилагдсан эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтийг оновчтой хуваарилах, зарцуулах

**3.6.16 Тэргүүлэх зорилт: Байгалийн гамшиг, нийтийг хамарсан өвчлөл, гэнэтийн аюул, ослын асуудлыг шийдвэрлэх эрсдэлийн менежментийн чадавхийг бэхжүүлэх бодлого**

#### **Хэрэгжүүлэх үйл ажиллагаа**

3.6.16.1 Шинэ болон дахин сэргэж буй халдварт өвчнөөс эрт сэрэмжлүүлэх, хариу арга хэмжээ авах өнөөгийн тогтолцоог бэхжүүлэх, өргөжүүлэх

3.6.16.2 Хөдөлмөрийн чадвар алдалтыг бууруулах болон ажлын нөхцлийн аюулгүй байдал, эрүүл ахуйг онцлон анхаарсан хөдөлмөрийн эрүүл мэндийн чиглэлээр судалгаа хийх

**3.6.17 Тэргүүлэх зорилт: Аймгийн эрүүл мэндийн салбарын хөгжил, бүтэц, зохион байгуулалтын удирдлагад шинэчлэл хийх, байгууллагын хөгжлийг дэмжих, эрүүл мэндийн салбарын хяналт шинжилгээ, үнэлгээг сайжруулах бодлого**

### **Хэрэгжүүлэх үйл ажиллагаа**

3.6.17.1 Эрүүл мэндийн улсын салбарт байгууллагын зохистой бүтэц бий болгох

3.6.17.2 Салбар дундын хамтын ажиллагааны өнөөгийн механизмыг боловсронгуй болгож үр дүнг сайжруулах

3.6.17.3 Удирдлагын хариуцлага, үр дүнг сайжруулахад байгууллагын соёлын гүйцэтгэх үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх

3.6.17.4 Орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудын удирдах ажилтны мэдлэгийг сайжруулах, удирдлагын чадавхийг бэхжүүлэх

3.6.17.5 Эрүүл мэндийн удирдлагын мэдээллийн тогтолцооны удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлж, чанар агуулгыг сайжруулах

3.6.17.6 Дотоодын байнгын хяналт шинжилгээ болон хөндлөнгийн үечилсэн хяналтыг тогтмолжуулах

## **ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ САЛБАРЫН БОДЛОГО**

### **Үндэслэл буюу өнөөгийн байдал:**

#### Тулгамдсан асуудлууд

Байгаль орчныг хамгаалах, байгаль орчны удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох, биологийн олон янз байдлыг хамгаалах, экологийн тэнцвэрийг хадгалах зэрэг чиглэлд 30 гаруй хууль, 14 олон улсын протокол, конвенци, гэрээ болон УИХ, Засгийн газраас батлан гаргаж даган мөрдөж буй 27 тогтоол, төсөл, хөтөлбөрүүд байгаа нь чамлахааргүй тоо боловч бодит байдалд тэдгээрийн хэрэгжилт сул, орон нутгийн идэвхи оролцоо хангалтгүй байсан хэвээр байна.

#### Уур амьсгалын өөрчлөлт

Говийн бүс, Дорноговь аймгийн хэмжээнд жилийн дундаж температур олон жилийн дунджаас илүү нэмэгдэж, хуурай болон хагас хуурай цаг агаар зонхилох болсон.

#### Цөлжилт, элсний нүүдэл, шар шороон шуурга

Говь, цөлийн бүсийн эко-систем нь эмзэг, нөхөн сэргээгдэх хугацаа урт, ургамалын нөмрөг ядмаг байхаас гадна цөлжилт, элсний нүүдэл ихсэж, шар шороон шуурга, ган зудын давтамж нэмэгдсэн. Цөлжилтөд уур, амьсгалын өөрчлөлт, ургамлын нөмрөгийн хомсдол, бэлчээрийн даац хэтрэх, хүний буруутай үйл ажиллагаа, уул уурхайн олборлолт, тээвэрлэлт, үйлдвэрлэл зонхилон нөлөөлж байна. Монгол орны хуурай голдуу бүс нутгийн 228,750 мянган га талбай цөлжсөн байна. Бэлчээрийн 13 орчим хувь нь талхлагдаж, ямар нэг хэмжээгээр цөлжилтөд өртсөн. Дорноговь аймагт 857.6 мян.га бэлчээрийн ургамлийн зүйлийн

бүрэлдэхүүнд хүчтэй өөрчлөлт орж талхлагдсан байгаа нь хамгийн их тоо бөгөөд тус аймагт жилд тохиолдох шороон шуургатай өдрийн тоо дунджаар 70 байгаа юм.

#### Ногоон байгууламжийн хүрээ, хил хязгаарыг нэмэгдүүлэх

Уур амьсгалын өөрчлөлт, хүний зохисгүй үйл ажиллагаанаас шалтгаалж тоорой, хайлаасны төгөл, заган ой хомсдох, цөлжилт, элсний нүүлт, шар шороон шуурга улам эрчимжиж байгаа өнөөгийн экологийн сөрөг нөлөөллийг багасгаж, цөлжилт, элсний нүүлтийг сааруулах ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх нэн шаардлагатай байна.

#### Усан хангамжийн эх үүсвэрийн нөөц, хомсдол, түүний ашиглалт

Гадаргуугийн урсацгүй, агаарын хур тундас маш бага унадаг энэ бүс нутгийн ус хангамжийн ганц эх үүсвэр нь газар доорхи ус. Монголын говийн бүсийн газар доорхи усны нөөцийг бүрэн судлаагүй байна. Газар доорхи усны нөөц, тэжээлийн горим, авч ашиглах зохистой хэмжээ зэргийг нарийвчилсан хайгуул судалгааны ажил хийх шаардлагатай.

#### Хөрсний бохирдол, эвдрэл, тоосжилт

Уул уурхайн үйл ажиллагаанаас шалтгаалан Айраг, Даланжаргалан, Иххэт, Сайхандулаан, Хатанбулаг зэрэг сумын нутагт тоосжилт өндөр, газрын эвдрэл их болсон байна. Бүрэн бус тооцоогоор уул уурхайн хөрс хуулалт, малталтанд 700 гаруй мянган шоо метр газрын хэвлий, ашигт малтмал эрж, хайх явцад 180 гаруй мянган га газар, ЗХУ /хуучин нэрээр/-ын цэргийн ангиуд байрлаж байсан нутгуудад 6000 орчим га газрын хөрс эвдэрсэн боловч нөхөн сэргээлтийн ажил төдийлөн хийгдээгүй байна.

#### Биологийн төрөл зүйлийн хамгаалал

##### Ургамалын аймаг

Говийн бүс, Дорноговь аймгийн нутаг дэвсгэрт хүний буруутай үйл ажиллагаа, уул уурхайн олборлолт, тээвэрлэлт, үйлдвэрлэл болон бэлчээрийн даац 8 суманд хэтэрсэн зэрэг нь ургамалын нөмрөг хомсдох үндсэн шалтгаан болж байна. Заг, сондуул, харгана, буйлс зэрэг олон наст ургамлуудыг түлшинд ихээр хэрэглэдэг.

##### Амьтны аймаг

Дорноговь аймгийн нутаг дэвсгэрт ховордсон 11 зүйл, агнуурын болон жижиг 32 зүйл, нийт 43 зүйл хөхтөн амьтан, 11 зүйл мөлхөгч, ховор ба агнуурын 9 зүйл, махан идэшт 10 зүйл, түгээмэл тохиолдох 21 зүйл, нийт 40 зүйл шувуу бий.

Монгол орны бусад бүс нутгуудад нүүдлийн болон суурин шувууд, тэр дундаа махчин шувууд олноороо цахилгаан дамжуулах агаарын шугам дээр сууж цахилгаанд цохиулан үхдэг.

#### **Давуу тал:**

• БНХАУ-тай хиллэдэг учир зарим хилийн сумд хийн халаагуур болон цахилгаан халаагуурыг өргөн ашиглах болсон.

- Агаарыг зориулалтын багаж хэрэгсэлээр байнга хянаж дээж авч байна.
- Үйлдвэрлэлийн зориулалтаар гарч буй аюултай хог хаягдал бага
- Ойн сан бүхий газрыг улсын болон орон нутгийн тусгай хамгаалалтад авсан

#### **Султал:**

- Говийн нөхцөлд ургадаг, ургах боломжтой мод, бутыг хамгаалах, нөхөн сэргээх нэгдсэн бодлого, хөтөлбөр байхгүй.

- Шахмал түлшний байнгын үйлдвэрлэл байхгүй, иргэд шахмал түлшийг хэрэглэж заншаагүй.

- Түр хогийн цэгт хог шатааж агаарыг бохирдуулдаг.
- Газрын гүний усны нөөц хэмжээг бүрэн тооцоолоогүй

- Гүний усны чанар муу

- Хог хаягдал гаргасны төлбөрийг бүрэн авах тогтолцоо бүрдээгүй.
- Хог хаягдлыг ангилах, эргүүлэн ашиглах үйлдвэрлэл хөгжөөгүй.
- Ойн мод тарих, үржүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг мэргэжлийн боловсон хүчнээр хангагдсан томоохон аж ахуйн нэгж байдаггүй.

- Аймгийн нутаг дэвсгэрийн 45 орчим хувьд нь ашигт малтмалын эрэх, хайх, олборлох үйл ажиллагаа явуулж байна

- Олон салаа авто зам

- Худаг усны дутмаг байдал

- Ямар нэг бодлогогүй газар ашиглалт, бэлчээрийн хуваарилалтгүй.

- Мод тарих хөтөлбөрт тусгагддаг хөрөнгө бага

#### **Учирч болох эрсдэл, түүнийг тооцох нь:**

2015 он хүртэл Монголын говийн бүс нутагт хүн амын эрчимтэй төвлөрөл бий болж, уул уурхайн томоохон төслүүдийн бүтээн байгуулалтын ажлууд хийгдэж, хот суурин газруудын тэлэлт явагдана.

Уул уурхайн салбарын хөгжил аймгийн эдийн засгийн бүтэцэд үнэмэлэхүй хувийг эзлэх боловч говь цөлийн бүсийн экологийн тэнцвэр алдагдуулах, хүний хүрээлэн буй орчны эрүүл аюулгүй байдлыг хязгаарлахаас гадна тогтвортой аялал жуулчлалын хөгжлийг сааруулахуйц хүндрэлүүд үүсч болно.

Байгаль орчны асуудлууд нь аймгийн болон улсын хил хязгаараас үл хамаарах нийтлэг шинж чанартай. Энэ нь Монголын говийн бүс нутгийн байгаль хамгааллын асуудалд хөрш зэргэлдээ аймгууд, хөрш зэргэлдээ орнуудын анхаарлыг хандуулахад онцгой чухал ач холбогдолтой.

Говийн бүсийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх чиглэлд өнөөдрийн хэрэгжүүлж буй системгүй, хоорондоо уялдаа муутай санаачилга, төсөл хөтөлбөрүүдийн уялдааг хангаж, говийн бүсэд багтаж буй аймгуудын хүчин чармайлтыг нэгтгэх асуудал тулгамдаж байна.

### **4.1. Байгаль орчны салбарын хөгжлийн бодлого**

#### **Бүх үе шат (2011-2021 он)**

**4.1.1 Тэргүүлэх зорилт:** Байгаль орчны бохирдол, доройтлыг хязгаарлан зогсооно.

#### **Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**



- 4.1.1.1 Уул уурхай болон цэргийн зориулалтаар ашигласан талбай, хот тосгодын балгас зэргийг цэвэрлэх, нөхөн сэргээх бодлого хэрэгжүүлэх;
- 4.1.1.2 Иргэдийн гар аргаар алт, жонш олборлосон газруудыг нөхөн сэргээх, хөрсний эвдрэл, бохирдлыг арилгахад хандивлагч, төсөл хэрэгжүүлэгч байгууллагуудтай хамтран ажиллах;
- 4.1.1.3 Томоохон сумын агаарын бохирдлыг бууруулах дэд хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх;
- 4.1.1.4 Сэргээгдэх эрчим хүч ашиглах явдлыг дэмжих;
- 4.1.1.5 Төв суурин газрын хог хаягдлыг зохистой шийдэх, хогийн цэгүүдийг цэгцлэх, хог хаягдлыг ялгах, зөөх, дарж устгах менежментийг боловсронгуй болгох, хөрсийг эрүүлжүүлэх;
- 4.1.1.6 Аймгийн хэмжээнд агаарын чанарын харуулын тоог нэмэгдүүлнэ;
- 4.1.1.7 Байгальд удаан задардаг, хатуу хог хаягдлыг дахин боловсруулах цехүүдийг байгуулах;
- 4.1.1.8 Агаарын чанарын харуулыг өргөтгөж Байгаль орчны шинжилгээний итгэмжлэгдсэн лабораторитой болгоно;

#### **4.1.2 Тэргүүлэх зорилт: Газар, газрын хэвлийн баялгийг зохистой ашиглах нэгдсэн бодлого хэрэгжүүлнэ.**

##### **Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

- 4.1.2.1 Аймгийн ба сумын тусгай хамгаалалттай газар нутгийг өргөтгөх, шинээр авах, хамгаалалтын менежментийг сайжруулах;
- 4.1.2.2 Улс, аймаг, сумын тусгай хамгаалалттай газар нутгаас уул уурхай, үйлдвэрлэл, аялал жуулчлал, хотхоны зориулалтаар газар чөлөөлөхгүй байх;
- 4.1.2.3 Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийг сайжруулахад олон улсын ба мэргэжлийн байгууллага, төрийн захиргааны төв байгууллагын оролцоог нэмэгдүүлэх;
- 4.1.2.4 Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн дэглэмийг мөрдүүлж, газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх;
- 4.1.2.5 Хариуцлагатай уул уурхайн нэр бүхий найман зарчмыг байгаль орчныг хамгаалан тэтгэх түншлэлээр дамжуулан хэрэгжүүлэх;
- 4.1.2.6 Байгаль орчныг хамгаалан тэтгэх түншлэлд уул уурхайн компаниуд хариуцлагатай уул уурхайн тайлангаа жил бүр хүргүүлдэг болгох;
- 4.1.2.7 Ашигт малтмалын хайгуул, олборлолт, үйлдвэрлэл, тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхлэсэн аж ахуйн нэгжүүдийн байгаль орчныг нөхөн сэргээж буй үйл явцад хяналт мониторингийг тогтмолжуулах;
- 4.1.2.8 Холбогдох хууль журмын хэрэгжилтийг хангуулах. Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй компани аж ахуйн нэгжүүдэд байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг дахин хийх;
- 4.1.2.9 Жил бүр хариуцлагатай уул уурхайн чуулга уулзалтыг зохион байгуулах. Чуулганаар тогтвортой түншлэлийн тайланг авч хэлэлцэж уриалга, зөвлөмж гаргах;
- 4.1.2.10 Аймгийн хариуцлагатай уул уурхайн мэдээллийн санг байгуулах. Мэдээллийн агуулга, хүртээмжийг нэмэгдүүлэх. Иргэдэд зориулсан уулзалт, лекц, семинар зохион байгуулах;
- 4.1.2.11 Аймагт хариуцлагатай уул уурхайг төлөвшүүлэхэд мэргэжлийн байгууллага, ТББ, төрийн захиргааны төв байгууллагын оролцоог нэмэгдүүлэх;
- 4.1.2.12 Түншлэлийн зүгээс хариуцлагатай уул уурхайн зарчмуудыг хангасан уул уурхайн үйлдвэрлэл эрхлэгч аж ахуйн нэгж, иргэдийг нийгэмд алдаршуулах, сурталчлах ажлыг тогтмолжуулах;

**4.1.3 Тэргүүлэх зорилт: Усны нөөцийг бохирдолоос хамгаалах, зохистой ашиглах, хүн амыг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн усаар хангах нөхцлийг бүрдүүлнэ.**

**Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

- 4.1.3.1 “Ус” аймгийн дэд хөтөлбөр боловсруулж батлуулна;
- 4.1.3.2 Усны нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, ус хэмнэх нөөцийн менежменттэй болох;
- 4.1.3.3 Гүний усны ай савын зөвлөл байгуулах;
- 4.1.3.4 Усны хайгуул судалгааг аймгийн хэмжээнд хийж, уст цэгийн нэгдсэн мэдээллийн санг бий болгох;
- 4.1.3.5 Хатуулаг ихтэй уст цэгүүдэд цэнгэгжүүлэх төхөөрөмж суурилуулах;
- 4.1.3.6 Гүний худгуудыг шинээр гаргах, эвдэрсэн уст цэг худгуудыг засварлах тоог нэмэгдүүлэх;
- 4.1.3.7 Усны чанарын хяналтын лаборатори байгуулах;

**4.1.4 Тэргүүлэх зорилт: Ойн нөөцийг тогтвортой ашиглаж, ой хамгаалах, нөхөн сэргээх, экологийн тэнцвэрийг хадгалах нөхцлийг хангана.**

**Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

- 4.1.4.1 Уур амьсгалыг зөөлрүүлж, цөлжилт, хөрсний эвдрэл, түйрэн, элсний нүүдэлтэй тэмцэх зорилгоор мод тариж, ногоон зурвас байгуулах;
- 4.1.4.2 Заган ойн хамгаалалтыг сайжруулах, иргэд, нөхөрлөлд гэрээгээр эзэмшүүлэн хамгаалах, нөхөн сэргээх, зохистой ашиглах;
- 4.1.4.3 Мод үржүүлгийн газрын тоо, чанарыг нэмэгдүүлж говь цөлийн байгаль цаг уурын нөхцөлд дасан зохицох сайн чанарын үр суулгацыг бий болгож ойжуулалтад шаардлагатай тарьц суулгацыг өөрийн аймгаас хангах нөхцлийг бүрдүүнэ;
- 4.1.4.4 Ойг хамгаалах, нөхөн ургуулах, ойн байгалийн нөхөн үржилтийг тэтгэх, сайн чанарын үрийн аж ахуйг эрчимжүүлж модлог ургамал тариалах хэмжээ, хүрээг өргөтгөх, энэ талын ажлыг байгаль хамгаалах үйл ажиллагааны гол чиглэл болгох;
- 4.1.4.5 Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад мод, бут, сөөг тарих, ургуулах, арчилж тордох арга барил, анхан шатны мэдлэг эзэмшүүлэх зорилгоор туршлагын мод үржүүлгийн талбайтай болгоно;
- 4.1.4.6 Мод тарих иргэдийн мэдлэг, чадварыг нэмэгдүүлэхэд чиглэсэн дадлагажих сургалтуудыг тогтмол зохион байгуулах;
- 4.1.4.7 Сум бүрт ойн төгөл байгуулах;
- 4.1.4.8 Хур тунадасны усыг хуримтлуулах замаар усан сан, хөв, цөөрөм байгуулж, бэлчээр, хадлан, тариалан, ногоон байгууламжийн усалгаанд ашиглах аж ахуйн нэгж, иргэдийн үйл ажиллагааг дэмжинэ;

**4.1.5 Тэргүүлэх зорилт: Амьтан, ургамлын аймгийн нөөцийн хомсдолыг хязгаарлаж, тэдгээрийг байгалийн жамаар нөхөн сэргээх, тогтвортой ашиглах нөхцлийг бүрдүүлнэ.**

**Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

- 4.1.5.1 Ан амьтны нөөц, байршил нутгийг тогтоон хамгаалахад зориулагдсан дотоод, гадаадын хөрөнгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэхүйц олон улсын байгууллага, хандивлагч орон, хувь хүний дэмжлэгтэй урт, богино хугацааны төслийг үр ашигтай хэрэгжүүлэхийг дэмжих;

4.1.5.2 Ховор, нэн ховор ургамлын тархац нутаг, нөөцийн судалгаа хийх, удмын санг хамгаалах, бүртгэл мэдээлэл, хяналт шинжилгээний тогтолцоо бүрдүүлэх, сэргээн ургуулах, тарималжуулах ажил зохион байгуулах;

4.1.5.3 Уул уурхайн сөрөг нөлөөллөөс биологийн олон янз байдлыг хамгаалах журам боловсруулж мөрдүүлэх;

4.1.5.4 Биологийн олон янз байдлын нөөц, түүнд үзүүлж буй одоогийн болон ирээдүйн дарамтуудыг судлан тогтоох;

4.1.5.5 Биологийн олон янз байдалд нөлөө үзүүлэх хүн амын хөдөлгөөн, нутагшил суурьшил болон уул уурхайн үйлдвэрлэлийн үнэлгээ, хяналтын тогтолцоог бий болгох;

4.1.5.6 Биологийн олон янз байдлыг хамгаалах олон улсын хамтын ажиллагааг бүх талаар хөгжүүлэх;

4.1.5.7 Биологийн олон янз байдал, түүнийг хамгаалахад нутгийн иргэдийн мэдлэгийг нэмэгдүүлэх, ТББ-уудын үйл ажиллагааг дэмжин хөгжүүлэх;

**4.1.6 Тэргүүлэх зорилт: Уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтэд дасан зохицож, сөрөг үр дагаврыг бууруулах чадавхийг бүрдүүлж хэрэгжүүлнэ.**

**Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

4.1.6.1 Байгаль, цаг уурын нөлөөллийн улмаас хуурайшин гандаж, доройтолд өртсөн болон өртөх магадлал бүхий газар нутгын төлөв байдлыг тодорхойлж, дасан зохицох чадавхыг бэхжүүлэх;

4.1.6.2 Говийн бүсийн нөхцөлд дасан зохицсон, тэсвэрлэх чадвар сайтай үр тариа, төмс, хүнсний ногоо, тэжээлийн ургамлын төрлийг сонгон тариалах, шинэ төрөл сортыг бий болгох, газар тариалангийн дэвшилтэт арга, технологи боловсруулж нэвтрүүлэх;

4.1.6.3 Бүс нутгийн бэлчээрийн даацад тохирсон малын тоо, толгой, сүргийн бүтцийг бүрдүүлэх бодлого боловсруулж, хэрэгжүүлэх;

4.1.6.4 Байгаль, цаг уурын өөрчлөлтөд дасан зохицсон, үр ашигтай, биологийн чадамж сайтай бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуйг хослуулан хөгжүүлэх;

4.1.6.5 Уур амьсгалын өөрчлөлт болон цөлжилт, тэдгээрт дасан зохицох, даван туулах арга зам, сөрөг үр дагаврыг бууруулах талаар олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, мэдлэг олгох, мэдээлэл сурталчилгааны ажлыг өргөжүүлэх;

4.1.6.6 Уур амьсгалын өөрчлөлт, дэлхийн дулаарал, цөлжилт, шар шороон шуурга зэргийн нөлөөнд хамгийн их өртдөг бүс нутгийн хувьд эдгээр асуудлаар Ази, номхон далайн бүснутаг, цаашлаад дэлхийн хэмжээний олон талт хамтын ажиллагаанд идэвхитэй оролцох;

4.1.6.7 Байгаль цаг агаарын өөрчлөлтөд зохицон, байгалийн аюул, ган, зудыг хохирол багатай давахын тулд одоогийн байдалдаа шинжлэх ухааны үндэстэй зөв дүгнэлт хийж, байгалийн унаган төрх алдагдах аливаа үйл ажиллагааг багасган, байгаль хамгаалах, нөхөн сэргээх ажлыг сайжруулах, орон нутгийн ус цаг уур орчны шинжилгээний төв, цаг уурын станц, харуулуудын боловсон хүчний мэдлэг, чадварыг дээшлүүлэх, багаж тоног төхөөрөмжийг шинэчлэх, автоматжуулах арга хэмжээ авах;

4.1.6.8 Агаар чанарын харуулыг агаар, хөрс, усны бохирдолын лаборатори болгон өргөтгөх;

4.1.6.9 Цаг уур ус судлалын өртөө харуулын хөтөлбөрийг гүнзгийрүүлэн байгаль орчинд гарч байгаа хувирал өөрчлөлтийг судлан тогтооход чиглэсэн ажлыг өргөтгөх;

4.1.6.10 Цөлжилтийг бууруулах аймгийн дэд хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ;

- 4.1.6.11 Цөлжилттэй тэмцэх үйл ажиллагааны зардлыг орон нутгийн төсөв болон бусад хөрөнгийн дэмжлэгтэйгээр санхүүжүүлэх;
- 4.1.6.12 Цөлжсөн газарт нутгийн унаган мод, сөөгний сэргэн ургалтыг тэтгэх, шинээр мод, бут тарих;
- 4.1.6.13 Олон салаа автозамыг журамлаж хөрсний эвдрэлээс хамгаалах, орон нутгийн замуудыг тэмдэгжүүлэх, чиглэл тус бүр заагдсан замаар зорьчдог болгох;
- 4.1.6.14 Загны хэрэглээг зогсоож, орлох түлшний үйлдвэрийг байгуулж, хэрэглээг эрчимжүүлнэ;
- 4.1.6.15 Усны эхүүд, баян бүрдүүдийг хамгаалах, хашаа хайс барих ажлыг шат дараалан гүйцэтгэнэ;
- 4.1.6.16 Агаарын бохирдлыг бууруулах үйл ажиллагааг үе шат бүрт хэрэгжүүлнэ;

#### **Гарах үр дүн:**

- Сум суурин газрыг агаарын бохирдолгүй хөгжүүлж, хог хаягдлын цогц менежментийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх замаар орчны бохирдлын эх үүсвэрийг эрс багасгах
- Аймгийн тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг нэмэгдүүлж, нийт газар нутгийн 30-аас доошгүй хувийг тусгай хамгаалалтад авах
- Хүн амын ундны усны чанар стандартыг хангуулах
- Хариуцлагатай уул уурхай хөгжих

## **4.2 Гамшгаас урьдчилан сэргийлэх бодлого**

**Үндэслэл буюу өнөөгийн байдал:** Монгол улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-д тусгагдсан амьдрах орчны аюулгүй байдлыг хангах бодлого, зорилт нь “Дорноговь аймгийн 2011-2021 он хүртэлх хөгжлийн стратеги төлөвлөгөө” ний бүрэлдэхүүн хэсэг болно.

#### **Нэгдүгээр үе шат (2011-2013 он):**

**4.2.1 Тэргүүлэх зорилт: Иргэдийн амьдрах, ажиллах орчны аюулгүй байдлыг хангах, гамшгийн эрсдлийг бууруулах чадавхийг бэхжүүлэх замаар аймгийн эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжлийг хангах таатай орчныг бүрдүүлэхэд хөтөлбөрийн зорилго оршино.**

#### **Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

4.2.1.1 Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэг, дадлагын ажлыг жил бүр зохион байгуулж, албад, мэргэжлийн ангиудын байнгын бэлэн байдлыг хангаж ажиллах

4.2.1.2 Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэг, дадлагын үеэр, ашигт малтмал хууль бусаар олборлогчдын үлдээсэн цооногийг булаах, химийн хорт бодисоор бохирдсон хөрсийг саармагжуулах, хүн амын ундны усны хашаа, хамгаалалтыг сайжруулах зэрэг бүтээлч ажлыг зохион байгуулж байх

4.2.1.3 Орон нутгийн аюулгүй байдлыг хангах нутгийн удирдлага, үүний дотор бүх шатны Засаг дарга, төрийн захиргааны байгууллагууд, хууль сахиулах болон тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагууд, иргэд, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудын идэвх оролцоо, хамтын ажиллагааг сайжруулахад чиглэсэн бодлого, үйл ажиллагаа явуулах

4.2.1.4 Айраг, Замын-Үүд сумдад гал унтраах анги байгуулна.

4.2.1.5 Айраг суманд шатахууны улсын нөөцийн цэг байгуулах

4.2.1.6 Гамшгаас хамгаалах тухай хууль, тогтоомжийн дагуу гамшгаас хамгаалах нэгдсэн сургууль, дадлагын үйл ажиллагааны зардлыг орон нутгийн төсвөөс шийдвэрлэж байх

#### **Хоёрдугаар үе шат (2014-2016 он):**

4.2.1.7 Гамшгаас хамгаалах орон нутгийн тогтолцооны байгууллага, тэдгээрийн удирдлагын гүйцэтгэх үүргийг тодотгож, бэлэн байдлыг хангах сургалт, дадлагын ажлыг тухай бүр зохион байгуулах

4.2.1.8 Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэг, дадлагын үеэр ашигт малтмал хууль бусаар олборлогчдын үлдээсэн цооногийг булах, химийн хорт бодисоор бохирдсон хөрсийг саармагжуулах, хүн амын ундны усны хашаа, хамгаалалтыг сайжруулах зэрэг бүтээлч ажлыг зохион байгуулж байх

4.2.1.9 Томоохон төв, суурингуудын барилга объектуудад галын аюулгүй байдлын хяналтын систем, агаарын дохиолол бий болгоно.

4.2.1.10 Онцгой байдлын хэлтэс, улсын нөөцийн салбарын ажлын нөхцлийг сайжруулахад дэмжлэг үзүүлж ажиллах

4.2.1.11 Гамшгаас хамгаалах бүх төрлийн нөөц, хангалтыг төрийн ба төрийн бус байгууллага, олон нийтийн оролцоотойгоор бүрдүүлэх арга хэмжээ авч байх

4.2.1.12 Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг үндэслэлтэй боловсруулж, түүнд нэмэлт, тодотгол хийж байх.

#### **Гуравдугаар үе шат: (2017-2021 он):**

4.2.1.13 Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэг, дадлагын ажлыг жил бүр зохион байгуулж, албад, мэргэжлийн ангиудын байнгын бэлэн байдлыг хангаж ажиллах

4.2.1.14 Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэг, дадлагын үеэр ашигт малтмал хууль бусаар олборлогчдын үлдээсэн цооногийг булах, химийн хорт бодисоор бохирдсон хөрсийг саармагжуулах, хүн амын ундны усны хашаа, хамгаалалтыг сайжруулах зэрэг бүтээлч ажлыг зохион байгуулж байх

4.2.1.15 Гамшгаас хамгаалах арга хэмжээг орон нутагт хэрэгжүүлэхэд сумын удирдлага, штабуудын үүрэг, гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, авран хамгаалах, хор уршгийг арилгах арга хэмжээний тухай сэдвээр сум, багийн Засаг дарга, алба, мэргэжлийн ангиудын даргын сургалт, дадлагын ажил зохион байгуулах.

4.2.1.16 Гамшгаас хамгаалах бүх төрлийн нөөц, хангалтыг төрийн ба төрийн бус байгууллага, олон нийтийн оролцоотойгоор бүрдүүлэх арга хэмжээ авч байх

## **ТАВ. ЭРХ ЗҮЙТ ТӨРИЙН БАЙГУУЛАЛЫН БОДЛОГО**

### **5.1. Эрх зүйт төрийн байгууллагын үйл ажиллагааг хангах бодлого**

Иргэдийн эрх зүйн ухамсарыг дээшлүүлж, сэтгэл хангалуун ажиллаж амьдрах хууль эрх зүйн таатай орчинг бүрдүүлэхийн зэрэгцээ тэдний орчны аюулгүй байдлыг хангаж ажиллана.

**Өнөөгийн байдал:** Хууль эрх зүйн хүрээнд аймгийн Засаг даргаас болон бусад төрийн байгууллага, албан тушаалтнаас гаргаж байгаа шийдвэрийг хууль тогтоомжид нийцүүлэх замаар хуулийн хэрэгжилтийг хангаж ажилладаг байна. Одоогоор Эрх зүйн мэдээллийн цахим сан /legalinfo.mn/-аас гадна 534 хууль, 1000 гаруй хууль тогтоомж бүхий эрх зүйн гар сантай бөгөөд үүнээс иргэдэд жилд дундажаар 100 гаруй байгууллага, 200 орчим албан тушаалтан, 300 гаруй иргэдэд эрх зүйн лавлагаа, зөвлөгөө, 60 гаруй иргэнд өмгөөллийн үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна.

Түүнчлэн аймаг дахь Төрийн архив нь 20 гаруй тонн архивын баримттай бөгөөд 158 хөмрөг үүсгэгч байгууллагын түүх, эрдэм шинжилгээний ач холбогдол бүхий 27900 гаруй баримтыг хадгалан хамгаалж, байгууллага иргэдэд төрийн үйлчилгээг үзүүлсээр байна. Архивын хувийн гаралтай хөмрөгөөс Улсын баатар Д.Данзанваанчиг, БНМАУ-ын хөдөлмөрийн баатар Д.Даваасамбуу, Хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэн Лувсандамба, сум, нэгдлийн даргаар олон жил үр бүтээлтэй ажиллаж байсан Л.Чанравваанчиг зэрэг хүмүүсийн хөмрөгүүдийг нэрлэж болно. Мөн тус архивын сан хөмрөгт 50 гаруй үнэт баримтууд хадгалагдаж байна. Эдгээр баримтаас дурьдвал: Говийн догшин ноён хутагт Данзанравжаагийн зохиол бүтээлийн эмхэтгэл, Тавдугаар ноён гэгээнтний цадигийн товч хураангуй, Мэргэн вангийн хошууны ноёдын түүх, аймгийн анхдугаар хурлын материал, 23 сумын анх байгуулагдсан тухай хурлын материал, Айраг, Мандах, Хатанбулаг, Сайхандулаан, Ихжаргалан сумдын 1935 оны хүн амын тооллогын бүртгэл, сум, байгууллагуудын түүх, Зүүнбаянгийн нефтийн үйлдвэр, Агаар мандлын дээд давхаргыг судлах төвийн архивын баримтууд нь Монгол улсын түүхэнд холбогдох чухал баримтууд юм.

#### **Давуу тал:**

- ✓ Төрийн албан хаагчийн ажлын байран дээр мэдлэг чадвараа дээшлүүлэх боломж бүрдсэн
- ✓ Эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас гаргасан тогтоол, шийдвэр болон мэдээллийн ил тод, нээлттэй байдал
- ✓ Эрх зүйн сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулахад шаардагдах техник хэрэгслэлээр хангагдсан

#### **Сул тал:**

- Иргэдийн эрхээ хамгаалах эрх зүйн боловсрол дутмаг.
- Нийгмийн идэвхи, оролцоо сул, иргэний хариуцлага хангалтгүй.
- Сумдад дээд боловсролтой боловсон хүчин дутагдалтай, ажиллах хангамж нөхцөл хангалтгүй
- Шийдвэр гаргах түвшинд төрийн болон төрийн бус байгууллагын уялдаа хамтын ажиллагаа сул

#### **Учирч болох эрсдэл, түүнийг тооцох нь:**

- ❖ Хууль тогтоомжийн хэрэгжилт сул байх
- ❖ Нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн хэрэгжилт бодитой үр дүнд хүрэхгүй байх
- ❖ Орон нутгийн өөрөө удирдах байгууллагын төрийн гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй байгууллагуудыг хянах тогтолцоо сул, эрх мэдлийн хуваарилалт ойлгомжгүй, хариуцлага хүлээх этгээд байхгүй байх

- ❖ Авлига өргөжин тэлэх
- ❖ Нийгмийн доройтол удаашрах

### **Бүх үе шат (2011-2021 он)**

**5.1.1 Тэргүүлэх зорилт: Хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулж, иргэдэд үзүүлэх эрх зүйн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлж ажиллана. Энэ хүрээнд:**

5.1.1.1 Аймгийн Засаг дарга болон бусад холбогдох төрийн байгууллагаас гарсан шийдвэрийг хуульд нийцүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллана.

5.1.1.2 Байгууллага, иргэдэд эрх зүйн сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулж, тэдэнд эрх зүйн туслалцаа үзүүлэх үйлчилгээг сайжруулна.

5.1.1.3 Нутаг дэвсгэрийн хууль хяналтын болон хилийн цэргийн байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан, хамтран ажиллана.

**5.1.2 Тэргүүлэх зорилт: Цагдаагийн байгууллагын шуурхай байдлыг хангаж, гэмт хэргийн илрүүлэлтийг нэмэгдүүлэн, нийгмийн дэг журмыг бэхжүүлж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх замаар орчны аюулгүй байдлыг хангаж ажиллана. Энэ хүрээнд:**

5.1.2.1 Гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах, урьдчилан сэргийлэх чиглэлээр явуулж байгаа ажлын явц, үр дүнг дээшлүүлж, гэмт хэргийг бууруулна.

5.1.2.2 Цагдаагийн байгууллагын чадавхи, шуурхай байдлыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх

5.1.2.3 Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын шүүхийн шийдвэр, тогтоолыг биелүүлэх, иргэд байгууллагын зөрчигдсөн эрхийг сэргээх, хуулийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн шийдвэр гүйцэтгэлийн бодит биелэлтийг хангаж ажиллана.

**5.1.3 Тэргүүлэх зорилт: Төрийн бүртгэл мэдээлийн тогтолцоог шинэтгэж, бодитой, үнэмшилтэй цахим мэдээллийн тогтолцоо, сан байгуулна.**

5.1.3.1 Төрийн бүртгэлийг цахим хэлбэрт бүрэн шилжүүлж, төрийн бүртгэлд бүртгүүлснийг батлах баримт бичгийг компьютерт уншигдахаар болгон бусад төрлийн цахим бичигтэй хоршин хэрэглэдэг болгоно.

5.1.3.2 Аймгийн төв, томоохон суурин газрын хаягийн бүртгэлийг шинэчлэн, кодын нэгдсэн тогтолцоог улсын хэмжээнд бий болгож, олон улсын жишигт хүрсэн хаягжуулалт, газар усны нэр, хаягийн нэгдсэн сантай болох

5.1.3.3 Иргэний баримт бичгийг цахимжуулж, бүртгэл, мэдээллийн тогтолцоог богино хугацаанд бүхэлд нь боловсронгуй болгох

**5.1.4 Тэргүүлэх зорилт: Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологийн ололт нэвтрүүлж, төрийн архивын хадгалалт хамгаалалт, нөхөн бүрдүүлэлт, ашиглалтын олон улсын стандартад хүргэх**

5.1.4.1 Төрийн архивын мэдээлэл, эрэлт хайлтын автоматжуулсан сан байгуулах, төрийн архивын мэдээллийн сан бүрдүүлэх, байгууллагын үйл ажиллагаанд цахим бичиг хэргийн тогтолцоог нэвтрүүлэх

5.1.4.2 Цахим баримтын архив бий болгож, ашиглах, нөхөн бүрдүүлэх, хадгалах ажиллагаанд технологийн шинэчлэл хийх

5.1.4.3 Төрийн архивыг стандартын шаардлагад нийцсэн байртай болгох, төрийн архивын хадгалалт, хамгаалалтыг сайжруулна.

### **Хүрэх гол үр дүн**

- Хууль, хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдаж, иргэдийн эрх зүйн боловсрол дээшилнэ.

- Хүний эрх эрх чөлөөг дээдэлдэг, шударга ёсыг эрхэмлэдэг хандлага тогтож, иргэдийн амгалан тайван амьдрах нөхцөл бүрдэнэ.
- Бүртгэл мэдээллийн тогтолцооны хууль эрх зүйн орчин бүрдэж, цахим мэдээллийн тогтолцоо, сан боловсронгуй болно.
- Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаа автоматчлагдаж, цахим бичиг хэргийн тогтолцоо бүрдэнэ.

## **5.2. Нутгийн төр захиргааны байгуулалт, төрийн албаны шинэтгэлийн бодлого**

***Нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллагын чадавхийг бэхжүүлэн төрийн үйлчилгээний өндөр соёл, иргэдийн ажиллаж амьдрах таатай нөхцлийг бүрдүүлж, зорилт чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэх мэдлэг чадвар, ёс зүйтэй төрийн албан хаагчдыг бэлтгэх бодлого баримтална.***

**Өнөөгийн байдал:** Тус аймаг нь засаг захиргааны нэгжийн хувьд 14 сум тэдгээрийн Засаг даргын Тамгын газар, 60 багтай бөгөөд Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 20 агентлаг, аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг 12 байгууллагаас иргэдэд төрийн үйлчилгээг хүргэх ажлыг зохион байгуулж байна.

Тус аймгийн хэмжээнд нийт 2783 төрийн албан хаагч үйл ажиллагаа явуулж байгаагийн 98 нь улс төрийн албан хаагч, 332 нь төрийн захиргааны албан хаагч, 2237 төрийн үйлчилгээний албан хаагч, 84 нь төрийн тусгай албан хаагч байна. Эдгээр албан хаагчид нь боловсролыг түвшингийн хувьд доктор зэрэгтэй 9, магистр зэрэгтэй 71, дээд боловсролтой 1417, тусгай дунд 421, бүрэн дунд 492, бүрэн бус дунд 322, бага боловсролтой 50 иргэн байна. Төрийн албан хаагчдын насны байдлыг авч үзвэл 20-35 насны 1225, 36-45 насны 801, 46-гаас дээш насны 307 иргэн байна.

### **Давуу тал:**

- Нутгийн удирдлагын болон төрийн байгууллагууд шаардлагатай мэргэжлийн боловсон хүчнээр харьцангуй сайн хангагдсан.
- Үйл ажиллагаа явуулах санхүүгийн болон материалын нөөцийг бүрдүүлэх нөхцөл бүрдсэн.

### **Сул тал:**

- Нутаг дэвсгэрийн хэмжээ их, хүн ам тоо цөөн учраас төрийн үйлчилгээг иргэдэд хүргэхэд харьцангуй их зардал гардаг.
- Төрийн үйлчилгээг иргэдэд хүргэж байгаа боловсон хүчнүүдийн ажлын дадлага туршлага, мэргэшсэн байдлыг үе шаттайгаар дээшлүүлэх шаардлагатай.
- Төр, захиргааны бүх шатны байгууллагын үйл ажиллагаа, тэднээс бодлого шийдвэр гаргахдаа иргэд, олон нийтийн оролцуулж байсан туршлага бага.

### **Бүх үе шат (2011-2021 он):**

**5.2.1 Стратегийн зорилт 1. Аймаг, сумын хурал, захиргааны байгууллагуудын шийдвэр гаргах үйл явцыг ил тод, хүртээмжтэй болгож, түүнд иргэдийн оролцох боломжийг хангана. Энэ хүрээнд:**

**5.2.1.1.** Орон нутгийн төр захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийг чиг үүрэгтээ тохирсон, үйл ажиллагааны давхардал хийдэгдэлгүй, бие биенээ дэмжигч систем болгон хөгжүүлэх чиглэл баримтална.



5.2.1.2. Нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллагаас шийдвэр гаргах явцат иргэний нийгмийн оролцоог хангах үүднээс шийдвэр боловсруулах, батлан гаргах үе шатанд хяналт тавих механизм бүрдүүлж, төр-иргэний нийгмийн бүх талын түншлэлийг хөгжүүлнэ.

5.2.1.3. Төрийн захиргааны байгууллагаас гаргах эрх зүйн актын боловсруулалтыг шинжилгээ судалгааны үндэстэй, системтэй болгох,

5.2.1.4. Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлийн болон төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх чиглэл баримтлах.

5.2.1.5. Хууль тогтоомжийг чанд баримталж хэрэгжүүлдэг тогтолцоог бүрдүүлэх.

## **5.2.2 Стратегийн зорилт: Төрийн үйлчилгээг хэрэглэгчдийн эрэлт, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн үзүүлэх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.**

### **Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

5.2.2.1. Төлөвлөх, бодлого боловсруулах, хяналт-шинжилгээ хийх, зохицуулах, үнэлж дүгнэх үйл явц нь ил тод, ажлын гүйцэтгэлд чиглэсэн суралцагч байгууллагыг хөгжүүлэх.

5.2.2.2. Төрийн зарим үйлчилгээг цахим хэлбэрт оруулж, чирэгдэл, хүнд суртлыг арилгах чиглэлийг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

5.2.2.3. Төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд хийгдэх хяналт шинжилгээ үнэлгээний чадвах, үр нөлөөг дээшлүүлж, үр дүнд суурилсан аргад тулгуурлан явуулах чиглэлийг хэрэгжүүлнэ.

5.2.2.4. Төрийн байгууллагуудын ажил үйлчилгээний чанар хүртээмжийн талаар олон нийтийн саналыг судалж үйл ажиллагаандаа ашиглана.

5.2.2.5. Төрийн байгууллагуудын үйлчилгээний стандартыг тогтоож мөрдүүлэх ажлыг үе шаттайгаар зохтон байгуулна.

## **5.2.3 Стратегийн зорилт: Орон нутгийн төр захиргааны байгууллагын хүний хөгжлийн чадавхийг хангах, төрийн албаны шинэтгэлийн бодлого.**

### **Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

5.2.3.1. Төрийн албан хаагчдыг тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллах нийгмийн болон ажлын байрны нөхцлийг үе шаттайгаар бий болгож, сайжруулах арга хэмжээ авна.

5.2.3.2. Төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх, дадлагажуулах ажиллагааг гэрээний дагуу суралцуулах, ажлын байранд нь сургах хэлбэрээр тасралтгүй зохион байгуулна.

5.2.3.3. Олон улсын байгууллага, хандивлагч орнуудын зардлаар өндөр хөгжилтэй орнуудад мэргэжил дээшлүүлэх, дадлагажих ажиллагаанд төрийн албан хаагчдыг өргөнөөр хамруулна.

5.2.3.4. Төрийн албан хаагчийг мэдлэг боловсрол, туршлага чадварыг нь харгалзан томилох, дэвшүүлэх тогтолцоог хэрэгжүүлнэ.

5.2.3.5. Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг баталж, үйл ажиллагаанд нь хяналт тавих олон нийтийн тогтолцоог бүрдүүлнэ.

### **Гарах үр дүн:**

- Төрийн үйлчилгээний чанар, хүртээмж сайжирч, албан хаагчийн ёс зүй, харьцааны соёл дээшилнэ.

- Орон нутгийн төр захиргааны байгууллагын үйл ажиллагаанд оролцох олон нийтийн оролцоо нэмэгдэнэ.
- Төрийн байгууллагын чадавхи дээшилж, иргэдийн нийгмийн идэвхи сайжирна.
- Хяналт шинжилгээ, үнэлгээний чадамж сайжирч, төрийн албан хаагчдын манлайлал дээшилнэ.
- Төрийн албан хаагчийн тогтвор суурьшил, эрхэлсэн ажлын үр дүн бүтээл дээшилнэ.

### 5.3 Гадаад бодлого

**Өнөөгийн байдал:** Энхийг эрхэмлэсэн, идэвхтэй гадаад улс төрийн бодлогыг хэрэгжүүлэх, хөрш болон сонирхогч орнуудтай харилцан ашигтай, найрсаг, тэнцвэртэй харилцааг бүхий л түвшинд хөгжүүлэх талаар “Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого”-ын стратегийн 7.5 ба 17.2 дахь зорилтуудыг орон нутагт хэрэгжүүлэх зорилт “Дорноговь аймгийн 2010-2021 он хүртэлх хөгжлийн стратеги төлөвлөгөө” ний бүрэлдэхүүн хэсэг болно.

**5.3.1 Тэргүүлэх зорилт:** Хөрш болон өндөр хөгжилтэй орнууд, тэдгээрийн муж, хотуудтай харилцаа тогтоож, хамтын ажиллагааг хөгжүүлэн, олон улсын байгууллагаас хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрүүдийн багтай идэвхтэй хамтран ажиллаж, аймгийнхаа эдийн засаг, нийгмийн хөгжилд бодитой дэмжлэг авах нөхцлийг бүрдүүлэх явдал гадаад бодлогын зорилго болно.

#### **Хэрэгжүүлэх үйл ажиллагаа: Нэгдүгээр үе (2011-2013 он):**

5.3.1.1 “Монгол улсын гадаад бодлого нэг цонхоор” бодлогын хүрээнд Гадаад хэргийн яамтай нягт хамтран ажиллаж, хөрш болон өндөр хөгжилтэй орнуудын муж, хотуудтай холбоо тогтоож, бүх талаар харилцан ашигтай, хамтын ажиллагааг хөгжүүлэх гэрээ хэлэлцээр байгуулж ажиллах

5.3.1.2 Монгол улсын Засгийн газрын 2009 оны 32 дугаар тогтоолоор баталсан “Монгол улсын гадаад харилцааг эдийн засагжуулах хөтөлбөр”-ийг орон нутагт хэрэгжүүлэх бодлого барьж, хөрш болон сонирхогч орнуудын ижил төстэй байгууллагуудтай аймгийнхаа төрийн болон бизнесийн байгууллагуудыг холбоо тогтоож ажиллуулах

5.3.1.3 Гадаад орнуудын их, дээд сургуулиудтай оюутан солилцох, өндөр хөгжилтэй орнуудад аймагтаа чухал шаардлагатай байгаа мэргэжлээр оюутан суралцуулах, төрийн албан хаагчдыг туршлага судлах, мэргэшүүлэх арга хэмжээнд оролцуулах

5.3.1.4 Ханги-Мандалын боомтыг байнгын ажиллагаатай болгох асуудлыг төр, засгийн холбогдох байгууллагуудад тавьж шийдвэрлүүлэх, боомтын цогцолборыг гадаадын хөрөнгө оруулалтаар шинэчлэн байгуулах

5.3.1.5 Гадаадад гарч ажиллах хүсэлтэй иргэдэд хууль эрх зүйн хүрээнд дэмжлэг үзүүлэх

#### **Хоёрдугаар үе (2014-2016 он):**

5.3.1.6 “Сайншанд” аж үйлдвэрийн цогцолбор, өмнөд бүсийн төмөр замын сүлжээг өргөтгөх зэрэг эдийн засгийн үр ашигтай томоохон төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхэд гадаадын шууд хөрөнгө оруулалтыг түлхүү ашиглах, гадаадын хөрөнгө оруулалтыг татах бодлого, үйл ажиллагаа явуулах

5.3.1.7 Гадаад оронд ажиллаж амьдарч байгаа нутгийн уугуул иргэдтэй холбоо тогтоож, аймгийн хөгжил дэвшилд тэдний мэдлэг, боловсрол, туршлагыг ашиглах чиглэлээр үйл ажиллагаа явуулах

5.3.1.8 Гадаад орон, олон улсын байгууллагуудын санхүүжилтээр хэрэгжиж байгаа төслүүдийн ажлын багтай нягт хамтран ажиллаж, аймгийн хөгжил дэвшилд үр дүнг нь бодитойгоор ашиглана.

5.3.1.9 Аялал жуулчлалын таатай орчныг бүрдүүлж, гадаад орнуудын жуулчдыг орон нутгийн аялалд оролцуулах тоо хэмжээг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авах

5.3.1.10 Урлаг, соёл, биеийн тамир, спортын байгууллагуудын гадаад харилцааг өргөтгөж, харилцан тоглолт хийх, үзэсгэлэн гаргах, уралдаан тэмцээнийг хоёр талд ээлжээр зохион байгуулах боломжийг судалж хэрэгжүүлэх

#### **Гуравдугаар үе (2017-2021 он):**

5.3.1.11 Гадаад орнуудын эдийн засаг, хөрөнгө оруулалтын бодит сонирхлыг аймгийнхаа хөгжил дэвшил, бүтээн байгуулалтын зорилтод нийцүүлэн үр бүтээлтэй ашиглах, тэгэхдээ орон нутгийн аюулгүй байдал, ард түмний язгуур эрх ашгийг хамгаалах бодлогыг баримтлах

5.3.1.12 БНСУ, Япон, БНХАУ, ОХУ-ын муж, хотуудтай тогтоосон “сайн хөршийн, найрамдал, хамтын ажиллагааны түншлэл”-ийн харилцааг нийгэм, эдийн засгийн бүх салбарт өргөтгөх гэрээ, хэлэлцээрүүдийг байгуулж ажиллах, гэрээ, хэлэлцээрүүдийг дүгнэх, үр дүнг тооцох

5.3.1.13 Терроризм, үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг, хүн худалдаалах, мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисыг хилээр нэвтрүүлэхгүй байх бодлогыг баримталж, орон нутгийн аюулгүй байдлыг хангах тогтолцооны байгууллагуудын чадавхийг бэхжүүлэх

5.3.1.14 Гадаад орон, олон улсын байгууллагуудын санхүүжилтээр хэрэгжиж байгаа төслүүдийн үр дүнг тооцож, үнэлгээ, дүгнэлт гаргах

## **5.4 Батлан хамгаалах салбарын бодлого**

**Үндэслэл буюу өнөөгийн байдал:** Орон нутгийн хамгаалалтад тулгуурласан батлан хамгаалах нэгдмэл тогтолцоог бүрдүүлж бэхжүүлэх талаар “Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого”-ын стратегийн 7.6 дахь зорилтыг орон нутагт хэрэгжүүлэх явдал “Дорноговь аймгийн 2010-2021 он хүртэлх хөгжлийн стратеги төлөвлөгөө”-ний бүрэлдэхүүн хэсэг болно.

**5.4.1 Тэргүүлэх зорилт:** Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-д тусгагдсан оршин тогтнохуйн аюулгүй байдлыг хангахад хөтөлбөрийн зорилго оршино.

#### **Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

#### **Нэгдүгээр үе (2011-2013 он):**

5.4.1.1 Монгол улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэр, хил хязгаарын халдашгүй байдлыг хангах үүрэг бүхий батлан хамгаалах, хил хамгаалах байгууллагуудын хэвийн үйл ажиллагааг хангахад орон нутгийн төр, захиргааны байгууллага, иргэдээс хүлээх үүргийн талаар сургалт, сурталчилгаа явуулах

5.4.1.2 Өсвөр, залуу үеийнхэнд эх орноо хайрлах, ахмад үеийн баатарлаг, дайчин уламжлалаар бахархах үзлийг төлөвшүүлэх олон хэлбэрийн арга хэмжээ зохион байгуулах

5.4.1.3 Аймаг, сумын удирдлагуудыг зэвсэгт хүчин, хил хамгаалах байгууллагуудын анги, салбаруудад танилцах аялалд оролцуулан, орон нутгаас нь алба хааж байгаа дайчидтай уулзуулах, цэргийн амьдралтай танилцуулах ажлыг зохион байгуулах

5.4.1.4 Улсын хил хамгаалахад туслах хүчний зөвлөл болон зэвсэгт хүчин, хил хамгаалах байгууллагуудтай түншийн холбоотой ажиллах төрийн байгууллагуудыг аймаг, сумын Засаг даргын захирамжаар баталж, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллах

5.4.1.5 Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн дагуу цэрэг татлагын ажлыг зохион байгуулж, Зэвсэгт хүчин болон Хилийн цэрэгт алба хаалгах, цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах хяналтын тоог жил бүр ханган биелүүлэх

5.4.1.6 Дайчилгааны 1, 2 дугаар зэргийн бэлтгэл үүрэгтний сургалт, дадлагыг тусгай төлөвлөгөөний дагуу зохион байгуулах

#### **Хоёрдугаар үе (2014-2016 он):**

5.4.1.7 Монгол улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэр, хил хязгаарын халдашгүй байдлыг хангах үүрэг бүхий батлан хамгаалах, хил хамгаалах байгууллагуудын чадавхийг бэхжүүлэх арга хэмжээ авах

5.4.1.8 Монгол улс дэлхийн II дайны төгсгөл болон 1945 оны чөлөөлөх дайнд оролцож ялалт байгуулсны 70 жилийн ойг ёслол төгөлдөр тэмдэглэн өнгөрүүлэх, энэ хүрээнд өсвөр, залуу үеийнхэнд эх орноо хайрлах, ахмад үеийн баатарлаг, дайчин уламжлалаар бахархах үзлийг төлөвшүүлэх олон хэлбэрийн арга хэмжээ зохион байгуулах

5.4.1.9 Монгол улсын Засгийн газраас баталсан “Зэвсэгт хүчний байгуулалтыг 2015 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг тооцож, үнэлгээ, дүгнэлт өгөх, цаашдын бодлогыг тодорхойлоход оролцох

5.4.1.10 Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн дагуу цэрэг татлагын ажлыг зохион байгуулж, Зэвсэгт хүчин болон Хилийн цэрэгт алба хаалгах, цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах хяналтын тоог жил бүр ханган биелүүлэх

#### **Гуравдугаар үе (2017-2021 он):**

5.4.1.11 Халх голын ялалтын 80 жилийн ойг ёслол төгөлдөр тэмдэглэн өнгөрүүлэх, энэ хүрээнд өсвөр, залуу үеийнхэнд эх орноо хайрлах, ахмад үеийн баатарлаг, дайчин уламжлалаар бахархах үзлийг төлөвшүүлэх олон хэлбэрийн арга хэмжээ зохион байгуулах

5.4.1.12 Зэвсэгт хүчин, цэргийн албан хаагчдын хөдөлмөрийн үнэлэмжийг шинэчилж, даатгалын шинэ тогтолцоог бий болгох төрийн бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах

5.4.1.13 Эх орны энхийн бүтээн байгуулалтанд оролцож үүрэг хүлээх зэвсэгт хүчний тусгай ангийг аймагтаа байнга байршуулж ажиллуулах саналыг төр засгийн байгууллагуудад тавьж шийдвэрлүүлэх

5.4.1.14 Аймаг, сумын удирдлагууд, урлаг соёл, биеийн тамир спортын зэрэг байгууллагуудын өргөн бүрэлдэхүүнтэй багийг зэвсэгт хүчний анги, салбаруудад аялуулж, уулзалт, уралдаан, тэмцээн, соёл урлагийн арга хэмжээ зохион байгуулах

5.4.1.15 Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн дагуу цэрэг татлагын ажлыг зохион байгуулж, Зэвсэгт хүчин болон Хилийн цэрэгт алба хаалгах, цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах хяналтын тоог жил бүр ханган биелүүлэх

## **ЗУРГАА. МАСТЕР ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА, ХЭРЭГСЭЛ**

Төлөвлөгөөний хэрэгжилтийг оновчтой удирдлага, зохион байгуулалтаар хангах, төлөвлөгөөг хэрэгжүүлэх дотоод, гадаад таатай орчныг бүрдүүлэх, хөрөнгө санхүүгийн шаардагдах эх үүсвэрийг олж, оновчтой ашиглах, олон нийтийн оролцоог өргөтгөх нь Дорноговь аймгийн хөгжлийн мастер төлөвлөгөөг амжилттай хэрэгжүүлэх үндсэн нөхцөл мөн.

### **6.1 Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалтын үндсэн чиглэл**

**Аймгийн Засаг даргын удирдлагын үүрэг, хариуцлага, манлайлал нь Мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтын суурь нөхцөл болно. Засаг даргын Тамгын газраас Мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд дор дурьдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ.**

1. Монгол Улсын Засгийн газрын түвшинд яамд, агентлагуудын хамтын ажиллагаа, Төвийн бүсийн зөвлөл, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг даргын Тамгын газар, сумдын Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааг мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэх чиглэлээр оновчтой уялдуулах;

2. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх жил бүрийн үндсэн чиглэлд тодорхой тусгаж сумдын хөгжлийн хэтийн төлөвлөгөөний бодлогын зорилт, төсөл хөтөлбөрүүдтэй уялдуулан хэрэгжүүлнэ.

3. Мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэх талаар аймгийн Засаг даргын Тамгын газар, бүсийн зөвлөл, хувийн хэвшил, төрийн бус байгууллагууд, иргэдийн оролцоог хөхүүлэн дэмжих оновчтой арга хэрэгсэл, механизмыг бий болгох;

4. Мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд дутагдах санхүүжилтийн эх үүсвэрийг улс болон орон нутгийн төсөв, төр-хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд бүрдүүлэх;

5. Жил бүрийн улсын төсөв, дунд хугацааны төлөвлөлтийн бусад баримт бичгүүд, төсвийн хүрээний мэдэгдэл, эдийн засаг, нийгмийн салбар бүрээр боловсруулан хэрэгжүүлэх хөтөлбөр, төслүүдийг аймгийн хөгжлийн мастер төлөвлөгөөнд дэвшүүлсэн зорилтууд, хэрэгжүүлэх үйл ажиллагаатай нягт уялдуулах;

6. Мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэх чиглэлээр богино хугацааны төрөлжсөн хөтөлбөр, төслүүдийг боловсруулан хэрэгжүүлэх;

7. Хувийн хэвшил дэх төлөвлөлтийг энэ төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглүүлэх зорилгоор оновчтой механизм, хөшүүргүүдийг бий болгох;

8. Статистикийн бүх түвшний үзүүлэлт, бүртгэл, мэдээллийг хөтөлбөрт дэвшүүлсэн тэргүүлэх зорилтууд, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд хяналт -

шинжилгээ хийж, үнэлэлт дүгнэлт өгөхөд тохиромжтой байх чиглэлээр боловсронгуй болгох;

9. Мастер төлөвлөгөөнд дэвшүүлсэн тэргүүлэх зорилтууд, тэдгээрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэлүүдийг улс төрийн намууд сонгуулийн мөрийн хөтөлбөртөө тусган хэрэгжүүлж байх;

10. Мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэх үе шат бүрийн сүүлийн жилд уг төлөвлөгөөний биелэлтийн явц, хүрсэн түвшин, ололт, дутагдал, дараагийн үе шатанд хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ, үйл ажиллагаа тэдгээрийн санхүүгийн эх үүсвэрийн талаар дэлгэрэнгүй тайлан гаргаж, зайлшгүй тохиолдолд Мастер төлөвлөгөөнд тодотгол хийх саналын хамт аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлж шийдвэрлүүлэх;

11. Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд дотоод, гадаадын хандивлагч бүх талын оролцоог хангах, тэдгээрийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах;

12. Гүйцэтгэлийн явц болон цаашдын чиг хандлагыг харгалзан уг төлөвлөгөөг нөхцөл байдалтай уялдаатайгаар шинэчлэх арга замыг тодорхойлон зөвлөмж гаргах;

13. Үе шат бүрт хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа арга хэмжээ, төсөл, тэдгээрт шаардагдах хөрөнгө, зардлын талаар хэлэлцэж зөвлөмж гаргах.

14. Мастер төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлж байгаа байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх;

15. Мастер төлөвлөгөөний биелэлтийн явц олсон амжилт, хүрсэн түвшин, санхүүгийн нөөцийн зарцуулалтын тухай хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлж байх;

16. Шинжлэх ухаан болон техник, зохион байгуулалтын тулгамдсан асуудлуудыг хэлэлцэж тэдгээрийг шийдвэрлэх талаар эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтран шийдвэрлэдэг байх;

17. Үйлдвэр үйлчилгээний ажлын тухай мэдээллийн нэгдсэн сан байгуулах, олон нийтэд мэдээлэх, сурталчлах;

18. Зорилтот хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх хүрээнд хувийн үйлдвэр, аж ахуйн газруудыг хамруулах, хувийн хөрөнгө оруулагчдыг татан оролцуулах, тухайн бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээний зах зээлийг хөгжүүлэх таатай нөхцөлийг бүрдүүлэх, зах зээлд гарах, байр сууриа бэхжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэх;

## **6.2 Эдийн засгийн өсөлтийг хангах үндсэн арга, хэрэгсэл**

1. Үйлдвэрлэл, технологийн парк, эдийн засгийн болон худалдааны чөлөөт бүсийг эдийн засгийн эрчимтэй өсөлтийг хангах арга хэрэгсэл болгох;

2. Эдийн засгийн хөшүүргүүдийг хэрэглэн экспортын чиглэлтэй үйлдвэрлэлийг түлхүү дэмжих;

3. Өндөр хөгжсөн болон түргэн хурдацтай хөгжиж байгаа орнуудын энэ талын туршлагыг бүтээлчээр хэрэглэх;

4. Хүн ардынхаа оюуны чадавхид тулгуурлан хөгжих бодлогыг тууштай баримталж, боловсролын салбарт тэргүүлэх ач холбогдол өгч, өндөр хөгжилтэй орнуудад нарийн мэргэжлийн боловсон хүчин, инженер, техникийн ажилтан, мэргэжилтэй ажилчдыг бэлтгэх;

5. Эдийн засгийн өсөлтийг өндөр технологид суурилсан уул уурхайн болон боловсруулах үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын эрчимтэй өсөлтөөр хангах чиглэл баримтлах;

6. Экспортыг нэмэгдүүлэх салбар, үйлдвэрлэлийг хөрөнгө оруулалтаар дэмжих;

7. Үйлдвэрлэл, үйлчилгээг татвар, гаалийн бодлогоор оновчтой дэмжих;

8. Өндөр технологи нутагшуулахыг бүх талаар дэмжих;
9. Гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих;
10. Дотоодын хуримтлалыг нэмэгдүүлж, оновчтой төвлөрүүлэн ашиглах механизмыг бий болгох;
11. Санхүү, үнэт цаас, хөдөлмөрийн зах зээлийг хөгжүүлэх;
12. Хөрөнгө оруулагчдын чуулга уулзалтаар хөрөнгө төвлөрүүлэх арга хэмжээг тогтмол зохион байгуулах.

## **6.2 Мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэр**

1. Төр, хувийн хэвшлийн түншлэлийг түлхүү ашиглах
2. Дотоодын банк, санхүүгийн эх үүсвэрийг бүрэн ашиглах;
3. Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг бүх талаар дэмжих;
4. Дотоодын хөрөнгө оруулалтыг хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглүүлэн ашиглах оновчтой арга механизм, хөшүүргийг бий болгох;
5. Бага хүүтэй, урт хугацаатай зээлийн хөтөлбөр хэрэгжүүлэх;
6. Хувийн хэвшил, аймгийн оролцоотой хамтарсан төслүүдийг хэрэгжүүлэх;
7. Гадаадын улс орон, олон улсын байгууллагаас хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор хөнгөлттэй зээл, буцалтгүй тусламж авах;
8. Орон нутгаас үнэт цаас гаргах;

## **6.3 Олон нийтийн харилцаа, хамтын ажиллагааны төлөвлөгөө**

Хөгжлийг хангах хүний хүчин зүйлийн оролцоо:

### **Иргэд:**

1. Аймаг, сум, оршин суугаа газар нутагтаа эзэн нь байж, түүний хөгжлийн төлөө хүч чадал, эрдэм ухаан, арга туршлагаа харамгүй зориулж, бүтээлчээр хөдөлмөрлөх.
2. Бусдын бүтээн байгуулалтыг хүндэтгэж, үр шимийг нь зүй зохистой ашиглах, бусдад тийм боломж олгох.
3. Монгол хүний ёс жудагтай амьдралын хэв маягийг гэр бүлдээ төлөвшүүлж, үр хүүхдээ зөв, боловсон хүмүүжүүлэх.
4. Мэдлэг боловсрол хөгжлийн гол хүчин зүйл болохыг ухамсарлаж, өөрөө болон гэр бүлийн гишүүдийг өндөр боловсролтой иргэн болгохын төлөө чармайн ажиллах.
5. Төр, нийгмийн харилцаанд идэвхитэй оролцож, хөгжил дэвшлийн төлөө саналаа нэмэрлэж, гар бие оролцож байх.

### **Бүх хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллага:**

1. Хэрэглэгчдийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн чанартай бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг бий болгох, өргөтгөх санаачлага гаргаж ажиллах.
2. Бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэхийн тулд үйлдвэрлэлийн техник, технологийг шинэчлэх.
3. Зах зээлд шудрагаар өрсөлдөх, үйл ажиллагаагаа ил тод, нээлттэй явуулах.

4. Ажлын байрны тоог нэмэгдүүлэх, ажлын байрны нөхцөлийг сайжруулах, ажилчин, албан хаагчдын амьдралын баталгааг хангахад чиглэсэн арга хэмжээ авч байх.

5. Байгаль орчинд халгүй технологи нэвтрүүлэх, байгаль орчинд учруулсан хор нөлөөг өөрийн хөрөнгөөр арилгах арга хэмжээ авч байх.

6. Нийгмийн хариуцлагыг гүнээ ухамсарлан үйл ажиллагааныхаа чиг шугам болгох.

#### **Иргэний нийгмийн байгууллагууд:**

1. Төрийн байгууллагуудын үйл ажиллагаа гагцхүү хуулийн хүрээнд явагдаж байгаа эсэх болон ажил, үйлчилгээний чанар, үр дүнд нь хяналт тавьж, зөрчлийг арилгах санал, шаардлага тавьж ажиллах.

2. Улс төрийн тогтвортой байдлыг хангаж, хуулийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байгаа төр, засгийн байгууллагуудын ачааллыг хөнгөвчлөхөд оролцох.

3. Төрийн бус байгууллагуудын гүйцэтгэж чадах олон чиг үүргийг тэдэнд шилжүүлэх замаар төрийн байгууллагуудын орон тоо, төсөв зардлыг бууруулах, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллагуудын түншлэл, хамтын ажиллагааг өргөтгөх.

4. Төрийн байгууллагуудаас олон нийтэд хамаарсан, тэдний эрх ашгийг хөндсөн шийдвэр гаргахад санал оруулах, дуу хоолойгоо нэмэрлэж байх.

5. Нийгмийн оюун санаа, сэтгэл зүйг зөв чиглүүлэн, олон түмний идэвхи оролцоог сайжруулах.

#### **Төр, захиргааны байгууллагууд:**

1. Шийдвэр гаргах бүх түвшинд иргэд олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, ил тод байдлыг хэвшүүлэн төрийн үйлчилгээг сайжруулах;

2. Үйл ажиллагаагаа гагцхүү хуулийн хүрээнд ил тод, нээлттэй, шудрага, шуурхай явуулах

3. Иргэдийнхээ эрүүл, аюулгүй, сэтгэл дүүрэн амьдрах нөхцөлийг бүрдүүлэх.

4. Бизнесийн орчныг эрүүл байлгаж, хуулийн хүрээнд явуулж байгаа бизнесээ өргөтгөхөд нь дэмжлэг үзүүлж байх.

5. Банк, санхүүгийн зохистой, найдвартай тогтолцоог бүрдүүлж, түүний ил тод, нээлттэй байдлыг хангах.

6. Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны тайлан, мэдээллийг иргэд, хэрэглэгчдэд шуурхай хүргэж байх.

7. Нийтийн эрх ашгийг хөндсөн шийдвэрийг гаргахдаа олон нийтийн санаа бодлыг судлах, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллах.

8. Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага, иргэдийг өөрсөдтэй нь холбоотой аливаа асуудлыг шийдвэрлэхэд өргөнөөр оролцуулж тэдгээрийн эрх ашгийг тууштай хамгаалах;

9. Эмэгтэйчүүдийн нийгмийн идэвхи, хөгжилд оролцох хүсэл эрмэлзлэлийг идэвхитэй дэмжих;

10. Аймгийнхаа тулгамдсан асуудал, нийгэм эдийн засгийн хөгжлийн зорилтуудыг шийдвэрлэхэд залуучуудыг өргөн оролцуулах оновчтой хөшүүрэг бий болгох;

11. Аймгийн боловсон хүчний цогц бодлого боловсруулж хэрэгжүүлэх;

12. Үйлдвэрлэл дэд бүтцийг хөгжүүлэх, хөдөө аж ахуйг эрчимжүүлэхэд шаардлагатай мэргэжилтэй ажилчин бэлтгэх тогтолцоог бий болгох;



13. Төрөл бүрийн мэргэжилтэй ажилчин бэлтгэхэд шаардлага бүхий багшлах боловсон хүчнийг сургаж бэлтгэн, нөөцийг бүрдүүлэх;

14. Төрийн албан хаагчид, түүнчлэн төрийн бус байгууллага, бизнесийн байгууллагуудын боловсон хүчний чадавхийг дээшлүүлэх мэргэжил, мэргэшлийн хувьд сургаж бэлтгэх бичил хөтөлбөр боловсруулан, боловсон хүчний чадамжийн стандартыг бий болгож мөрдөх;

15. Төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөр боловсруулан мөрдөж ажиллах

16. Төрийн албан хаагчийн мэдлэг, мэргэжлээ дээшлүүлэх, мэргэшихэд нь зориулж тухайн байгууллагаас нь үзүүлдэг санхүүгийн болон эд материалын дэмжлэгийн хүрээг өргөтгөх, нөөц боломжийг судалж хэрэгжүүлэх;

17. Төрийн байгууллагын үйл ажиллагааны чиг үүргийг тодорхой болгох, дотоод зохион байгуулалт, журмыг боловсронгуй болгох;

18. Аймаг, сум, байгууллагын түвшинд төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөр боловсруулж мөрдөх;

19. Төрийн байгууллагуудын төсвийг хүрэлцээтэй болгох;

20. Төрийн бус байгууллагын олон нийттэй харилцах давуу талыг түшиглэн нийгмийн сэтгэлгээ, эрэлт хэрэгцээг судалдаг, дүгнэлт шинжилгээ хийдэг чиг үүрэг бүхий бүтэц орон тоог бий болгох;

21. Хууль тогтоомж сурталчлах, эрх зүйн сургалт явуулахад шаардагдах зардлыг нутгийн захиргааны байгууллагын жил бүрийн төсөв төлөвлөгөөнд тусгаж үр ашигтай зарцуулан сургалтын үр нөлөөг хянаж, мэдээлдэг тогтолцоог бий болгох;

22. Төрийн байгууллагын үйлчилгээнд нэг цэгийн үйлчилгээ нэвтрүүлэх

23. Нутгийн захиргааны болон төсөвт байгууллагуудыг мэдээллийн нэгдсэн цахим сүлжээтэй болгож, төрийн зарим гол үйлчилгээг электрон хэлбэрээр үзүүлдэг болох;

24. Аймгийн эдийн засаг нийгмийн гол асуудлыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцэхийн өмнө ард иргэдийн дунд хэлэлцүүлэг, санал асуулга явуулж, тэдний санал бодлыг өргөн тусгаж хэрэгжүүлэх үйл ажиллагаанд тэдний оролцоог нэмэгдүүлэх;

25. Бүх шатны иргэдийн хурлын үйл ажиллагаанд иргэдийн оролцох боломж нөхцлийг хангах;

26. Ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх асуудлаар бодлого боловсруулах, шийдвэр гаргахад бизнес эрхлэгчдийг өргөнөөр оролцуулах нөхцлийг бүрдүүлэх;

## **ДОЛОО. МАСТЕР ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ**

Мастер төлөвлөгөөний хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь төлөвлөгөөнд дэвшүүлсэн зорилтуудын хэрэгжилт, гарч буй үр дүнд үнэлгээ өгч, хүндрэл, бэрхшээл, тасалдлыг арилгаж, хэрэгжих таатай нөхцөлийг бүрдүүлэхэд оршино. Хяналт-шинжилгээ, үнэлгээг төлөвлөгөөний бүлэг, дэд бүлэг бүрт багтсан тэргүүлэх зорилтуудын хүрээнд тусгасан үзүүлэлтүүдийг үндэслэн хийнэ.

### **7.1 Мастер төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ерөнхий зарчим**

Мастер төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, гүйцэтгэлд хяналт тавихдаа дор дурьдсан зарчим баримтална:

7.1.1 Мастер төлөвлөгөөний зорилтуудыг хэрэгжүүлэх арга хэмжээний биелэлтийг зохион байгуулахдаа арга зүйн болон мэдээллийн нэгдсэн байдлыг хангах;

7.1.2 Аймгийн болон салбарын түвшний зорилтот хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг зохион байгуулахдаа оролцох байгууллага (Аймгийн засаг даргын тамгын газар, сумдын засаг даргын тамгын газар, бизнесийн байгууллага, мэргэжлийн холбоод гэх мэт)-ын хэрэгжүүлэх чиг үүрэг, хүлээх хариуцлагыг тодорхой зааглах;

7.1.3 Удирдлагын аливаа шийдвэр, дүгнэлтийг хөндлөнгийн бие даасан шинжээчдийн үнэлгээг үндэслэн гаргах.

## 7.2 Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх байгууллага, хугацаа

7.2.1 Аймгийн Засаг даргын Тамгын газар, оролцогч талуудтай хамтран Мастер төлөвлөгөөний хэрэгжилтийн явцыг үнэлэх хяналт-шинжилгээний шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулах, шинжлэх ухаан, технологийн статистик мэдээллийн системд тулгуурлан мэдээллийг цуглуулах, мэдээллийн өгөгдлийн бааз байгуулах, бодлогын дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх, төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан мэдээ гаргаж, гүйцэтгэгч, хандивлагч байгууллага, олон нийтэд мэдээлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ.

7.2.2 Мастер төлөвлөгөөний хүрээнд хэрэгжүүлж байгаа зорилтот хөтөлбөр, төслийн явцад хийх хяналт-шинжилгээ, үнэлгээг тухайн хөтөлбөр, төслийн зорилго, зорилт, арга хэмжээ, хэрэгжүүлэх хугацаанаас хамааран тогтоосон шалгуур үзүүлэлтийн дагуу гүйцэтгэнэ.

7.2.3 Мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэх үе шат бүрийн эцсийн жилд тухайн шатанд тавьсан зорилт, арга хэмжээг бүхэлд нь хамруулан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.

7.2.4 Аймгийн Засаг даргын Тамгын газар Мастер төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад хийсэн хяналт-шинжилгээний дүн, цаашид авах арга хэмжээний саналын хамт үе шат бүрийн эцсийн жилд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлнэ. Шаардлагатай тохиолдолд мастер төлөвлөгөөг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас томилсон хяналтын баг хяналт- шинжилгээний ажлыг гүйцэтгэж, үр дүнг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулж болно. Ингэхдээ Мастер төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаа, хүрэх эцсийн үр дүн, хуваарилагдсан хөрөнгийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулсан эсэх, санхүүжилтийн төсвийн бус эх үүсвэрийг хэрхэн ашигласан байдалд түлхүү анхаарна.

## 7.3 Хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлт (үе шат бүрээр)

Мастер төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ дор дурьдсан үндсэн шалгуур үзүүлэлтийг ашиглахаас гадна хяналт-шинжилгээний зорилго, төрлөөс хамааруулан шаардлагатай шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулан ашиглаж болно.

Төлөвлөгөөний хэрэгжилтийн эхний үе шатны хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг 2013 онд, хөтөлбөрийн хэрэгжилтийн дунд шатны үнэлгээг 2016 онд, эцсийн шатны үнэлгээг 2022 онд тус тус гаргана.

Салбарын нэр	Хяналт шинжилгээ хийж, үнэлгээ өгөх үзүүлэлтүүдийн нэр, тэдгээрийг хэмжих нэгж	I үе шатны үзүүлэлт (2011-2013 он)	II үе шатны үзүүлэлт (2014-2016 он)	III үе шатны үзүүлэлт (2017-2021 он)

0	1	2	3	4
<b>НЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛ ХОЁР. БҮТЦИЙН ХӨГЖИЛ</b>	Аймгийн ДНБ-ний жилийн дундаж өсөлт, /%/	15.0	25.0	54.5
	Аймгийн ДНБ-д аж үйлдвэрийн салбарын эзлэх хувийн жин (үе шатны эцэст), / %/	12.2	26.6	41.0
	Аж үйлдвэрийн салбарын ДНБ-ий жилийн дундаж өсөлт, / дахин, %/	35.0	45.0	75.0
	Боловсруулах аж үйлдвэрийн үйлдвэрлэлийн жилийн дундаж өсөлт, / дахин, %/	2.5	5.0	15.0
	Аймгийн уул уурхайн салбарын үйлдвэрлэлийн жилийн дундаж өсөлт, /дахин, %/	4.0	8.0	15.0
	Аймгийн хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэлийн жилийн дундаж өсөлт, / %/	25.0	30.0	35.0
	Аймгийн газар тариалангийн үйлдвэрлэлийн жилийн дундаж өсөлт, / %/	40.0	55.0	60.0
	Аймгийн мал аж ахуйн салбарын үйлдвэрлэлийн жилийн дундаж өсөлт / %/	25.5	41.0	56.5
	Аймгийн үйлчилгээний салбарын жилийн дундаж өсөлт / %/	32.0	45.0	50.0
	Шинээр баригдсан өргөн төмөр зам, нарийн төмөр замын суурь бүтцийн хэмжээ	2000	31000	520000
	Шинээр баригдсан хатуу хучилттай авто замын хэмжээний өөрчлөлт	500	550	600
	Усан хангамжийн эх үүсвэр, нөөцийн төрөл, тоо хэмжээний өсөлт	3614	3660	3700
	Шинээр баригдсан орон сууцны тоо	750	1752	5000
<b>ГУРАВ. НИЙГМИЙН ХӨГЖИЛ</b>	Үйлдвэрийн ажиллагсдын тооны өсөлт	20625	21930	23235
	Аймгийн хүн амын жилийн дундаж өсөлт, /%/	5.0	5.0	6.0
	Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдах хүүхдийн хувийн жин / %/	90.0	96.0	100.0
	Сургуулийн насны хүүхдийн хамран сургалт, / %/	90,0	95.6	98.0
	Эхийн эндэгдлийн бууралт, / %/	0.0	0.0	0.0
	Нялхсын эндэгдлийн бууралт, / %/	25.4	15.0	13.0
	Ажилгүйдлийн түвшин, / %/	20.7	13.5	6.5
<b>ДӨРӨВ. БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН АШИГЛАЛТ, БАЙГАЛЬ ОРЧНЫ ХАМГААЛАЛ</b>	Амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой өрхийн тоо	2609	2100	1500
	Нөхөн сэргээлт хийх талбайн дундаж хэмжээ /га/	90	120	150
	Аймгийн цэцэрлэгжүүлэх талбайн хэмжээ (2010 оны түвшингээс), %	2.5	6.0	10.0
	Элсний нүүдлээс хамгаалах зорилгоор байгуулсан ойн зурвасын талбайн өсөлт, (2010 оны түвшингээс) /%/	15.0	45.0	60.0
	Усны бохирдлын бууралт, (2010 оны түвшингээс) /%/	30	50	70
	Хот суурин газрын агаарын бохирдлын бууралт (2010 оны түвшингээс) /%/	2.0	5.0	10.0

•

\*

\*